

SAMSUNG

ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

SM-N980F/DS
SM-N985F/DS

Агуулга

Үндсэн ойлголт

5	Төхөөрөмжийг хэрэглэхээс өмнө уншина уу
8	Төхөөрөмж хэт халах нөхцөл ба энэ үед авах арга хэмжээ
11	Төхөөрөмжийн бүтэц, функц
16	S Pen үзгийг хэрэглэх
17	Зай цэнэглэх
21	Нано SIM карт ба eSIM
24	Санах ойн карт (бичил SD карт) (Galaxy Note20 Ultra 5G, Note20 Ultra)
26	Төхөөрөмжийг асаах ба унтраах
27	Бэлтгэх тохиргоо
28	Хурууны хээ таних
30	Нүүр таних
32	Камер

Хэрэглүүрүүд ба функцүүд

48	Танилцуулга
49	Samsung бүртгэл
50	Дэлгэцийн танилцуулга
58	Мэдэгдлийн самбар
60	Бичвэр бичих
62	Хэрэглүүр суурилуулах, устгах
64	Утас
67	Харилцагчид
69	Зурвасууд
71	Интернэт
72	Олон цонх

75	Bixby
77	Bixby Хаpaа
78	Bixby Routines
80	Samsung Kids
81	Samsung Health
82	Samsung Members
82	Samsung Global Goals
82	Samsung TV Plus
82	Galaxy Shop
83	Galaxy Wearable
83	Хуанли
84	Reminder
85	Миний файлууд
85	Цаг
85	Тооцоологч
86	SmartThings
86	Smart View
87	Music Share
89	Windows-н холбоос
90	Google-ийн хэрэглүүрүүд
91	S Pen
103	Samsung Notes
106	PENUP
107	Галерей
111	AR бүс
117	Дуу хураагуур
119	Game Launcher
120	Game Booster

- 121 Агуулга хуваалцах
- 123 Samsung DeX
- 129 Дэлгэцийн зураг авах, бичлэг хийх
- 131 Өмнөх төхөөрөмжөөсөө мэдээлэл дамжуулах (Smart Switch)

Тохиргоо

- 134 Танилцуулга
- 135 Samsung account
- 135 Холболтууд
 - 136 Wi-Fi
 - 138 Bluetooth
 - 139 NFC ба харилцалгүй хийх төлбөр (NFC-идэвхэжсэн загвар)
 - 140 Дата хэмнэгч
 - 140 Мобайл дата зөвхөн хэрэглүүрүүд
 - 141 Мобайл Хотспот
 - 141 Бусад холболтын тохиргоо
- 143 Дуу ба чичиргээ
 - 143 Дууны чанар ба эффект
 - 144 Хэрэглүүрийн дууг тусад нь гаргах
- 144 Мэдэгдлүүд
- 145 Дэлгэц
 - 146 Хөдөлгөөний саадгүй байдал
 - 146 Дэлгэцийн горимыг өөрчлөх эсвэл дэлгэцийн өнгийг тааруулах
- 147 Дэлгэцийн зураг ба хэв маяг
- 147 Загвар
- 148 Эхлэл дэлгэц
- 148 Түгжих дэлгэц
 - 149 Smart Lock
 - 149 Always On Display

- 150 Биометрик ба хамгаалалт
 - 151 Samsung Pass
 - 153 Нууцлалтай Хавтас
 - 156 Найдвартай Wi-Fi
- 157 Нууцлал
- 158 Байрлал
- 158 Данснууд ба нөөцлөлт
 - 159 Samsung Cloud
- 159 Google
- 160 Дэвшилтэт функц
 - 161 Хөдөлгөөн ба дохио
 - 162 Хос Мессенжер
- 163 Digital Wellbeing ба эцэг эхийн хяналт
- 163 Зай ба төхөөрөмжийн тусламж
 - 163 Төхөөрөмжийг сайжруулах
 - 164 Зай
 - 164 Санах байгууламж
 - 165 RAM
 - 165 Төхөөрөмжийн хамгаалалт
- 165 Хэрэглүүр
- 166 Ерөнхий удирдлага
- 167 Тусгай боломжууд
- 167 Software update
- 168 Утасны тухай

Хавсралт

- 170 Тусгай боломжууд
- 184 Гэмтэл оношлох

Үндсэн ойлголт



Төхөөрөмжийг хэрэглэхээс өмнө уншина уу

Төхөөрөмжийг аюулгүй, зохистой хэрэглэхийн өмнө энэхүү гарын авлагыг уншина уу.

- Тайлбарыг төхөөрөмжийн үндсэн тохиргоонд үндэслэн бичив.
- Бүс нутаг, үйлчилгээ үзүүлэгч, загвар, үзүүлэлт, төхөөрөмжийн программ хангамжийн хувилбар зэргээс хамааран зарим агуулга нь таны авсан төхөөрөмжөөс өөр байж болно.
- Төхөөрөмжид зарим хэрэглүүр, функцийг ашиглах үед Wi-Fi эсвэл мобайл сүлжээнд холбогдох шаардлагатай байж магадгүй.
- Их хэмжээний CPU, RAM шаардсан агуулга (өндөр чанарын агуулга) нь төхөөрөмжийн ерөнхий гүйцэтгэлд нөлөөлнө. Төхөөрөмжийн техникийн үзүүлэлт болон түүнийг ашиглаж буй орчноос хамааран тухайн агуулгатай холбоотой хэрэглүүрүүд зөв ажиллахгүй байж болно.
- Samsung нь Samsung-аас өөр газраас нийлүүлсэн хэрэглүүр ашигласны улмаас үүсэх гүйцэтгэлийн асуудалд хариуцлага хүлээхгүй.
- Samsung нь системийн регистрийн тохиргоог өөрчилсөн эсвэл үйлдлийн системийн программ хангамжийг өөрчилснөөс үүдэн гарсан гүйцэтгэлийн эсвэл үл нийцлийн асуудалд хариуцлага хүлээхгүй. Үйлдлийн системийг өөрийн дураар өөрчлөхийг оролдох нь төхөөрөмжийн болоод хэрэглүүрийн ажиллагааг доголдуулж болзошгүй.
- Энэ төхөөрөмжид дагалдан ирсэн программ хангамж, дууны эх сурвалж, дэлгэцийн зураг, зураг болон бусад медиа нь хязгаарлагдмал ашиглалтын зөвшөөрөлтэй болно. Эдгээр материалыг ашиг олох болон бусад зорилгоор гадагш дамжуулах, ашиглах нь зохиогчийн эрхийн хуулийг зөрчсөн хэрэг болно. Медиаг хууль бусаар ашигласан хариуцлагыг хэрэглэгч дангаар хүлээнэ.
- Зурвасаар харилцах, файл байршуулах, татаж авах, автоматаар синхрончлох, байршил тогтоох үйлчилгээг ашиглах зэргээр дата үйлчилгээ авбал таны ашиглаж буй үйлчилгээний багцаас хамааран танаас нэмэлт төлбөр тооцож магадгүй. Их хэмжээний мэдээлэл дамжуулахдаа Wi-Fi ашиглахыг зөвлөж байна.
- Төхөөрөмжтэй дагалдан ирж буй өгөгдмөл хэрэглүүрүүд нь урьдчилан мэдэгдэлгүйгээр шинэчлэгдэх, мөн цаашид ашиглалтын дэмжлэгийг зогсоож болж болно. Төхөөрөмжид дагалдан ирсэн хэрэглүүрийн талаар асуух зүйл гарвал Samsung-ийн засвар үйлчилгээний төвд хандана уу. Хэрэглэгчийн суурилуулсан хэрэглүүрийн талаар үйлчилгээ үзүүлэгчид нь хандана уу.
- Төхөөрөмжийн үйлдлийн системийг өөрчлөх юм уу баталгаагүй эх сурвалжаас программ хангамж суурилуулах нь төхөөрөмжийн ажиллагаа доголдох мэдээлэл эвдрэх, алдагдахад хүргэж болзошгүй. Эдгээр үйлдэл нь Samsung-ийн лицензийн гэрээг зөрчиж байгаа бөгөөд танд олгосон баталгааг хүчингүй болгоно.

- Үйлчилгээ үзүүлэгчээс хамаараад дэлгэцийн хамгаалалтын хуулгыг үйлдвэрлэх, түгээх явцад наасан байдаг. Дэлгэцэд наасан хамгаалалтын хуулгад баталгаа хамаарахгүй.
- Орчны байдлаас хамааран төхөөрөмж мэдрэгч дэлгэцийн ялгарлыг автоматаар тааруулж, гадаа нарны хурц гэрэлд ч гаргацтай тод харагдаж байгааг харж болно. Бүтээгдэхүүний өвөрмөц шинжээс хамааран удаан хугацааны турш дэлгэц дээр тогтмол график дүрс гаргавал дүрс үлдэх (дэлгэц дээр ором гарах) буюу сүүдэр тогтож болзошгүй.
 - Мэдрэгч дэлгэц дээр бүхэлд нь буюу хэсэгчлэн болон бүхэлд нь удаан хугацаагаар тогтмол график дүрс гаргахгүй байх, төхөөрөмжийг хэрэглээгүй үедээ мэдрэгч дэлгэцийг унтрааж байхыг зөвлөж байна.
 - Та хэрэглээгүй үедээ мэдрэгч дэлгэцийг автоматаар унтраах эсэхийг тохируулж болно.
Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Дэлгэц** → **Дэлгэц амрах** дээр товшоод мэдрэгч дэлгэцийг унтраахын өмнө хүлээх хугацааг сонго.
 - Мэдрэгч дэлгэцийн цайралтыг хүрээлэн буй орчноос хамааран автоматаар тохируулахын тулд **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэлгэц** дээр товшиж, **Тохируулж болох цайралт** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.
- Бүс нутаг, загвараас хамааран зарим төхөөрөмжид Холбооны харилцаа холбооны комиссын (FCC) зөвшөөрөл шаардлагатай.

Хэрэв FCC-оос таны авсан төхөөрөмжийг зөвшөөрсөн бол төхөөрөмжийн FCC ID дугаарыг шалгах боломжтой. FCC ID дугаарыг шалгахын тулд **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Утасны тухай** → **Төлөвийн мэдээлэл** дээр товш. Хэрэв таны төхөөрөмжид FCC ID байхгүй бол төхөөрөмжийг АНУ буюу түүний харьяа аль ч нутаг дэвсгэрт худалдахыг зөвшөөрөөгүй гэсэн үг бөгөөд уг төхөөрөмжийн эзэмшигч хувийн хэрэгцээнд хэрэглэхээр АНУ-д авчирсан байж болно.
- Нисэх онгоцонд мобайл төхөөрөмж хэрэглэхийг холбооны улсын болон орон нутгийн захирамж, хязгаарлалтаар зохицуулсан байж болно. Төхөөрөмжөө хэзээ хэрхэн хэрэглэх талаар зохих албадаас мэдээлэл авч, багийн зааварчилгааг заавал баримтална уу.
- Таны төхөөрөмж соронзонтой. Кредит карт болон эмнэлгийн суулгасан төхөөрөмж зэрэг соронзон нөлөөлөл үүсгэх объектоос аюулгүй зайд байлга. Хэрэв танд эмнэлгээс суулгасан төхөөрөмж байгаа бол хэрэглэхийн өмнө эмчээсээ зөвлөгөө ав.

Ус, тоосны хамгаалалтыг ашиглах

Таны авсан төхөөрөмж ус, тоосны хамгаалалттай (IP68). Эдгээр зөвлөмжийн дагуу төхөөрөмжийн ус, тоосны хамгаалалтыг зохистой ашиглана уу. Зөвлөмжийг дагаагүйн улмаас төхөөрөмж гэмтэж болзошгүй.

- Төхөөрөмжийг цэвэр усанд 1,5 м буюу түүнээс доош гүнд 30 минутаас илүү хугацаагаар байлгаж болохгүй. Хэрэв төхөөрөмжийг цэвэр уснаас бусад төрлийн шингэнд, тухайлбал давстай ус, йонжуулсан ус, шүлтлэг ундаан дотор байлгасан бол шингэн төхөөрөмж рүү илүү хурдан нэвтэрнэ.
- Төхөөрөмжийг **хүчтэй урсаж буй усанд** унагаж болохгүй.
- Төхөөрөмжийг цэвэр усанд хүргэсэн бол хуурай цэвэр даавуугаар хаттал арчина. Хэрэв төхөөрөмжийг давстай ус, усан бассейны ус, савантай ус, тос, үнэрт ус, нарнаас хамгаалах тос, гар угаагч, гоо сайхны химийн бүтээгдэхүүнд хүргэсэн бол цэвэр усаар зайлаад хуурай цэвэр даавуугаар хаттал арчина. Хэрэв та зааврыг дагаагүй бол төхөөрөмжийн ажиллагаа, үзэмж муудаж болзошгүй.
- **Хэрэв төхөөрөмжийг усанд унагасан эсвэл чанга яригч юм уу микрофон норсон бол** дуудлага хийх үеэр дуу тод сонсдохгүй байж магадгүй. Төхөөрөмжийг хэрэглэхийн өмнө хуурай даавуугаар арчсаны дараа бүрэн хатаана уу.
- **Төхөөрөмжийг усан дотор хэрэглэвэл** мэдрэгч дэлгэц болон бусад функц хэвийн ажиллахгүй байж болзошгүй.
- **Хэрэв төхөөрөмжийг унагаасан эсвэл гаднын нөлөөнд орсон бол** төхөөрөмжийн ус, тоосны хамгаалалт гэмтэж болзошгүй.
- **Энэхүү төхөөрөмжийг хяналттай орчинд, тусгай (олон улсын "IEC 60529 Degrees of Protection provided by Enclosures [IP Code]" стандартад заасан IP68 ангиллын шаардлагыг хангасан; туршилтын нөхцөл: 15—35°C, 86—106 кПа, цэвэр ус, 1,5 метр, 30 минут) тохиолдолд шалган туршиж ус, тоосны хамгаалалтын гэрчилгээ олгосон. Энэхүү ангиллыг үл харгалзан төхөөрөмж зарим тохиолдолд гэмтэж болзошгүй байна.**

Зааварчилгааны дүрст тэмдгүүд



Анхааруулга: Өөрийн эсвэл бусдын бие махбодод бэртэл учруулж болзошгүй нөхцөл байдлууд



Болгоомжлол: Таны гар утас эсвэл бусад тоног төхөөрөмжид гэмтэл учруулж болзошгүй нөхцөл байдлууд



Мэдэгдэл: Тэмдэглэл, ашиглалтын талаарх зөвлөмж, нэмэлт мэдээлэл

Төхөөрөмж хэт халах нөхцөл ба энэ үед авах арга хэмжээ

Батарейг цэнэглэх үед төхөөрөмж халах

Цэнэглэх үед төхөөрөмж болон цэнэглэгч халж болзошгүй. Утасгүй цэнэглэх, хурдан цэнэглэх горимд төхөөрөмжид хүрвэл халж мэдэгдэж болно. Энэ нь төхөөрөмжийн урт хугацааны эдэлгээ юм уу гүйцэтгэлд нөлөөлөхгүй бөгөөд төхөөрөмжийн ажиллагааны хэвийн горим юм. Хэрэв зай ердийнхөөс илүү халж байвал цэнэглэх хурд буурах юм уу, цэнэглэгч цэнэглэхээ зогсоож болно.

Төхөөрөмж хэт халж эхэлбэл дараах арга хэмжээг ав:

- Цэнэглэгчийг төхөөрөмжөөс салгаж, ажиллаж буй бүх хэрэглүүрийг хаа. Төхөөрөмжийг хөртөл хүлээгээд дахин цэнэглэгчид залга.
- Төхөөрөмжийн доод хэсэг хэт халж байвал залгасан USB кабель гэмтсэн байж болзошгүй. Гэмтсэн USB кабелийн оронд Samsung-с зөвшөөрсөн кабель залга.
- Утасгүй цэнэглэгч хэрэглэхдээ металл биет, соронз, соронзон туузтай карт зэрэг гаднын материалыг утасгүй цэнэглэгч болон төхөөрөмжийн хооронд байрлуулж болохгүй.



Утасгүй цэнэглэх эсвэл хурдан цэнэглэх функцийг зөвхөн зарим загварт ашиглах боломжтой.

Төхөөрөмжийг хэрэглэх үед халах

Цахилгаан тэжээл ихээр зарцуулдаг хэрэглүүр, функцийг удаан хугацаагаар хэрэглэх үед батарейн цэнэгийн зарцуулалт огцом ихэссэнээс төхөөрөмж түр хугацаанд халж болзошгүй. Ажиллаж буй бүх хэрэглүүрийг хаагаад төхөөрөмжийг хэсэг хугацаанд бүү хэрэглэ.

Төхөөрөмж халж болох жишээ тохиолдлуудыг доор үзүүлэв. Таны хэрэглэж буй хэрэглүүр, функцээс хамааран эдгээр жишээ нь таны төхөөрөмжийн загварт хамаарахгүй байж болно.

- Худалдан авсны дараа бэлтгэх тохиргоо хийх үед эсвэл мэдээлэл сэргээх үед
- Их хэмжээний файл татаж авах үед

- Цахилгаан тэжээл ихээр зарцуулдаг хэрэглүүр, функцийг удаан хугацаагаар хэрэглэх үед
 - Удаан хугацаанд өндөр чанартай тоглоом тоглох үед
 - Удаан хугацаагаар бичлэг хийх үед
 - Цайралтыг хамгийн их түвшинд тохируулж видео нэвтрүүлэг хийх үед
 - TV-тэй холбох үед
- Олон үйлдэл зэрэг гүйцэтгэх үед (эсвэл олон хэрэглүүрийг нэгэн зэрэг далд ажиллуулах үед)
 - Олон цонх хэрэглэх үед
 - Видео бичиж байхад хэрэглүүрүүдийг шинэчилсэн эсвэл татаж авах үед
 - Видео дуудлагын үеэр их хэмжээний файл татаж авах үед
 - Залуур хэрэглүүрийг хэрэглэж байхад видео бичлэг хийх үед
- Үүл, цахим шуудан, бусад бүртгэлээр их хэмжээний мэдээлэл синхрончлох үед
- Автомашинд төхөөрөмжийн нарны шууд тусгалд байршуулсан үед залуур хэрэглүүрийг хэрэглэх үед
- Утасгүй интернетийн бүс ба холболтын функцийг хэрэглэх үед
- Сүлжээний дохионы чадал муутай, хүлээн авах боломжгүй газар төхөөрөмжийг хэрэглэх үед
- Гэмтэлтэй USB кабелиар батарейг цэнэглэх үед
- Төхөөрөмжийн олон зориулалттай оролт гэмтсэн, шингэн, тоос, металлын нунтаг, үзгийн хошуу зэрэг гаднын материалд өртсөн бол
- Та роуминг горимд байгаа бол

Төхөөрөмж хэт халж эхэлбэл дараах арга хэмжээг ав:

- Төхөөрөмжийг программ хангамжийн хамгийн сүүлийн хувилбараар шинэчил.
- Ажиллаж байгаа хэрэглүүрүүдийн үл зохилдлогоос төхөөрөмж халж болно. Төхөөрөмжийг унтраагаад асаа.
- Wi-Fi, GPS, Bluetooth функцүүдийг хэрэглээгүй үедээ унтраа.
- Батарейн зарцуулалтыг ихэсгэхэд хүргэдэг эсвэл далд ажиллаж буй хэрэглүүрүүдийг хэрэглээгүй үедээ хаа.
- Хэрэгцээгүй файл, хэрэглүүрүүдийг устга.
- Дэлгэцийн цайралтыг бууруул.
- Хэрэв төхөөрөмж хэт халсан буюу удаан хугацааны турш халж мэдрэгдвэл хэсэг хугацаанд бүү хэрэглэ. Хэрэв төхөөрөмж хэт халсан хэвээр байвал Samsung-ийн засвар үйлчилгээний төвд хандана уу.

Төхөөрөмж хэт халах үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хэрэв төхөөрөмж хэт халж байгаа нь танд таагүй санагдвал төхөөрөмжийг хэрэглэхээ зогсоо.

Төхөөрөмж халж эхэлбэл төхөөрөмж хөрөхийн тулд функцүүд болон гүйцэтгэлийг хязгаарлаж эвсэл унтарна. Энэ функцийг зөвхөн зарим загварт ашиглах боломжтой.

- Хэрэв төхөөрөмж хэт халж, тодорхой хэмд хүрэх үед төхөөрөмж доголдох, гадар нь гэмтэх, батарейн шингэн урсаж болзошгүйг анхааруулах зурвас гарч ирнэ. Төхөөрөмжийн хэмийг буулгахын тулд дэлгэцийн цайралтыг бууруулж, гүйцэтгэлийн хурдыг хязгаарлан, батарейн цэнэглэлтийг зогсооно. Төхөөрөмж хөртөл ажиллаж буй хэрэглүүрүүдийг хааж, яаралтай тусламж хүсэхээс бусад дуудлагын болон бусад функцүүдийг хязгаарлана.
- Төхөөрөмжийн хэм улам нэмэгдсэний улмаас хоёр дахь зурвас гарч ирвэл төхөөрөмж унтарна. Төхөөрөмжийн хэм заасан түвшнээс багастал бүү хэрэглэ. Яаралтай тусламжийн дуудлагын үеэр хоёр дахь анхааруулах зурвас гарч ирвэл албадан унтраах үйлдлээр дуудлагыг таслахгүй.

Ажиллагааны орчинд холбогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Таны төхөөрөмж хүрээлэн буй орчны дараах нөхцөлөөс шалтгаалан халж болзошгүй. Батарейн эдэлгээний хугацааг багасгах, төхөөрөмжийг гэмтээх, гал гарахаас сэргийл.

- Төхөөрөмжийг хэт халуун эсвэл хэт хүйтэн газар бүү хадгал.
- Төхөөрөмжийг нарны шууд тусгал дор удаан хугацаагаар бүү байлга.
- Зуны улиралд битүү машин дотор зэрэг хэт халуун орчинд төхөөрөмжийг удаан хугацаагаар бүү хадгал.
- Төхөөрөмжийг цахилгаан зуух, халдаг гудас гэх мэт хэт халж болзошгүй газар бүү тавь.
- Төхөөрөмжийг халаагуур, бичил долгионы зуух, халуунаар боловсруулах төхөөрөмж, өндөр даралтын сав дотор эсвэл ойр хавьд нь бүү хадгал.
- Шалбарсан болон эвдэрсэн кабелийг бүү хэрэглэ. Эвдэрсэн буюу доголдолтой зай, цэнэглэгчийг бүү хэрэглэ.

Төхөөрөмжийн бүтэц, функц

Багцын агуулгууд


Хайрцагт агуулагдах зүйлсийг товч заавраас харна уу.




- Төхөөрөмжид дагалдаж ирсэн зүйлс болон туслах хэрэгслүүд тухайн бүс нутаг эсвэл үйлчилгээ үзүүлэгчээс хамааран өөр байж болно.
- Дагалдаж ирсэн зүйлс нь зөвхөн тухайн төхөөрөмжид зориулагдсан бөгөөд бусад төхөөрөмжид тохирохгүй байж болно.
- Урьдчилан мэдэгдэлгүйгээр харагдах байдал, техникийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт орж болно.
- Дагалдах хэрэгслүүдийг орон нутаг дахь Samsung-ийн борлуулагчаас худалдан авч болно. Худалдаж авахын өмнө тухайн хэрэгсэл таны төхөөрөмжид тохирох эсэхийг шалгана уу.
- Зөвхөн Samsung-аас зөвшөөрсөн дагалдах хэрэгслийг хэрэглэ. Баталгаагүй дагалдах хэрэгсэл нь баталгаанд хамрагдахгүй доголдол доголдуулж, гүйцэтгэлд бэрхшээл үүсгэх магадлалтай.
- Бүх дагалдах хэрэгслийн хангамж бүхэлдээ үйлдвэрлэгч компаниудаас хамааран өөрчлөгдөж болно. Бэлэн байгаа дагалдах хэрэгслүүдийн талаарх бусад мэдээллийг Samsung-ийн вэбсайтаас авна уу.
- Дагалдах дижитал оролттой чихэвчийг (USB Type-C) зөвхөн энэ төхөөрөмжид хэрэглэхэд зориулсан. Үүнийг өөр аудио гаралттай төхөөрөмжид хэрэглэх боломжгүй байж болно.

Төхөөрөмжийн бүтэц

► Galaxy Note20 Ultra 5G, Note20 Ultra:



► Galaxy Note20 5G, Note20:





- Чанга яригч ашиглах, тухайлбал медиа файл тоглуулах, утасны чанга яригчийг хэрэглэх үедээ төхөөрөмжийг чихэндээ бүү ойртуул.
- Камерын дуранг хурц гэрэл, тухайлбал нарны гэрэл шууд тусахаас болгоомжилно уу. Хэрэв камерын линзэнд нарны гэрэл гэх мэт хурц гэрэл туссан бол камерын зургийн мэдрэгч гэмтэж болзошгүй. Гэмтсэн зургийн мэдрэгчийг засварлах боломжгүй бөгөөд зураг дээр цэг, толбо гарахад хүргэнэ.
- Хэрэв төхөөрөмжийн шилэн болон акрил их биеийн гадаргуу гэмтсэн байхад хэрэглэвэл бэртэх аюултай. Төхөөрөмжийг Samsung-ийн засвар үйлчилгээний төвд засуулсны дараа л хэрэглэнэ үү.
- Микрофон, чанга яригч, хүлээн авагчид тоос эсвэл гаднын биет орвол төхөөрөмжийн дуу багасах юм уу зарим функц ажиллахгүй байж болзошгүй. Хэрэв та тоос эсвэл гаднын биетийг хурц үзүүртэй зүйлээр авахаар оролдвол төхөөрөмж гэмтэж, гадна үзэмжид нөлөөлж болзошгүй.



- Дараах тохиолдолд холболтын асуудал гарч, батарейн цэнэгийг дуустал шавхаж болзошгүй:
 - Төхөөрөмжийн антены орчим металл стикер наасан бол
 - Хэрэв та төхөөрөмжийг металл материалтай хавтсанд хийсэн бол
 - Мобайл дата холболт тогтоосон үед эсвэл дуудлага хийж байхад төхөөрөмжийн антены орчимд гараар эсвэл гаднын биетээр халхалсан
- Samsung-аас зөвшөөрсөн дэлгэцийн хамгаалалтын хуулга хэрэглэхийг зөвлөж байна. Баталгаагүй дэлгэцийн хуулга нь мэдрэгчийн ажиллагааг доголдуулж болзошгүй.
- Ойрын зайн/гэрэл мэдрэгчийн орчмыг дэлгэцийн хамгаалалтын хуулга, дэлгэцийн хамгаалалт, стикер, хавтас гэх мэт дагалдах хэрэгслээр бүү халхал. Ийм тохиолдолд мэдрэгчийн ажиллагаа доголдож болзошгүй.
- Дуудлагын үеэр ойрын зайн мэдрэгч ажиллавал төхөөрөмжийн дээд талд гэрэл анивчиж болно.
- Зах дэлгэцийн өнгө таны харах өнцгөөс хамааран өөр байж болно. (Galaxy Note20 Ultra 5G, Note20 Ultra)

Их биеийн товч


Товч	Функц
Хажуугийн товч	- Төхөөрөмж унтарсан бол удаан дараад асаана. - Үүнийг дараад дэлгэцийг асаах юм уу түгж. - Удаан дараад Bixby-тэй ярилцана. Дэлгэрэнгүй мэдээллийг Bixby-г хэрэглэх-ээс авна уу. - Та тохируулсан функц буюу аппликейшнээ ажиллуулахын тулд хоёр удаа дар эсвэл удаан дар.
Хажуугийн товч + Дуу намсгах товч	- Нэгэн зэрэг дараад дэлгэцийн зураг авна. - Зэрэг удаан дараад төхөөрөмжийг унтраана.

Хажуугийн товчны тохиргоо

Хажуугийн товчийг хоёр удаа товшиж эсвэл Хажуугийн товчийг удаан дарж аль нэг аппликейшнийг буюу функцийг сонго.


Тохиргоо аппликейшнийг ажиллуулж, **Дэвшилтэт функц** → **Хажуу товч** дээр товшиж, дараа нь хүсэж буй сонголтоо хий.

Мэдрэгч товч



Төхөөрөмжийг асаахад мэдрэгч товчнууд дэлгэцийн доод хэсэгт гарч ирнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Залуурдах мөр \(мэдрэгч товчнууд\)](#)-ээс авна уу.


S Pen үзгийг хэрэглэх



-  S Pen үзгийг хэрэглэх явцдаа хэт чанга дарах юм уу гулзайлгаж болохгүй. S Pen үзэг эвдрэх юм уу хошууны хэлбэр алдагдаж болзошгүй.
- S Pen үзгээр дэлгэц дээр хэт чанга дарахгүй байх хэрэгтэй. Үзэгний хошууны хэлбэр алдагдаж болзошгүй.
-  Төхөөрөмжийн ойролцоо соронзон байвал цэнэглэх юм уу мэдрэгч дэлгэцийг товших зэрэг S Pen үзэгний зарим үйлдэл ажиллахгүй байж болзошгүй.
- S Pen үзэг бүрэн цэнэггүй болсон ч та мэдрэгч дэлгэц дээр товших юм уу Агаарын команд зэрэг S Pen үзгийн бусад функцийг хэрэглэж болно.
- Хэрэв та S Pen үзгийг дэлгэц дээр хурц өнгөөр барьж хэрэглэдэг бол төхөөрөмж S Pen үзгийн үйлдлийг танихгүй байж магадгүй.
- Хэрэв S Pen үзгийн үүр лүү ус орвол төхөөрөмжийг сэгсэрч үүрнээс усыг зайлуулж байгаад хэрэглэвэл зохино.
- Хэрэв S Pen үзэг зүй ёсоор ажиллахгүй байвал Samsung-ын засвар үйлчилгээний төвд аваачиж шалгуулна уу.

S Pen үзгийг салгах

S Pen үзгийн араас татаж сугална. S Pen үзгийг үүрнээс нь гаргана. S Pen үзгийг хадгалахдаа үүрэнд нь буцаан хийж, түгжигдтэл зөөлөн түлхэнэ.



S Pen үзгийг цэнэглэх

S Pen товчоор хэрэглүүрүүдийг зайнаас удирдахын тулд S Pen үзгийг цэнэглэсэн байх ёстой.

S Pen үзгийг үүр лүү нь хиймэгц цэнэглэж эхэлнэ.

Хэрэв Агаарын үйлдлийн функц идэвхгүй болсон бол S Pen үзгийг зөвхөн төхөөрөмж цэнэглэх үед цэнэглэнэ.

Зай цэнэглэх

Анхны удаа эсвэл удаан хугацаагаар хэрэглээгүй орхисны дараа хэрэглэхийн өмнө зайг цэнэглэнэ.



Зөвхөн Samsung-гаас зөвшөөрсөн таны төхөөрөмжид зориулан хийсэн зай, цэнэглэгч болон кабелийг хэрэглэ. Тохирохгүй зай, цэнэглэгч болон кабел таны төхөөрөмжийг гэмтээж болно.




- Цэнэглэгчийг буруу холбовол төхөөрөмжид ноцтой гэмтэл учирч болзошгүй. Буруу хэрэглэсний улмаас үүссэн аливаа гэмтэлд баталгаа үйлчлэхгүй.
- Зөвхөн төхөөрөмжид дагалдах USB Type-C кабелийг хэрэглэ. Хэрэв бичил USB кабелийг гэмтээвэл төхөөрөмж гэмтэж болзошгүй.



Эрчим хүч хэмнэх үүднээс цэнэглэгчийг хэрэглээгүй үедээ цахилгаанаас салгаж байх хэрэгтэй. Цэнэглэгч нь цахилгааны унтраалгагүй тул эрчим хүчийг үр ашиггүй зарцуулахгүйн тулд цэнэглэгчийг хэрэглээгүй үедээ цахилгаанаас салгаж байх ёстой. Цэнэглэгчийг тэжээлийн залгуурт ойр, мөн цэнэглэж байх үед хүрэхэд амар газар байлгавал зохино.

Утсаар цэнэглэх

USB кабелийг USB тэжээлийн адаптерт залгаж, кабелийг төхөөрөмжийн олон зориулалттай оролтод залгаж зайг цэнэглэнэ. Цэнэглэж дууссаны дараа цэнэглэгчийг төхөөрөмжөөс салга.



Утасгүй цэнэглэх

Төхөөрөмжийн дотор утасгүй цэнэглэх ороомог бий. Та батареийг утасгүй цэнэглэгчээр (тусад нь худалдаж авна) цэнэглэж болно.

Зайг цэнэглэхийн тулд төхөөрөмжийн ар талын төв хэсгийг утасгүй цэнэглэгч дээр голлуулж тавь. Бүрэн цэнэглэсний дараа төхөөрөмжийг утасгүй цэнэглэгчээс салга.

Цэнэглэхээр тооцсон хугацаа мэдэгдлийн самбарт гарч ирнэ. Бодит цэнэглэх хугацаа нь цэнэглэх нөхцөлөөс шалтгаалж болно.



Утасгүй цэнэглэх үеийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Төхөөрөмжийг утасгүй цэнэглэгч дээр тавихдаа завсар нь юм уу хавтсанд нь төлбөрийн карт, радио давтамж таних (FRID) картыг (тухайлбал нийтийн тээврийн эсвэл түлхүүр-карт) байрлуулж болохгүй.
- Утасгүй цэнэглэгч дээр төхөөрөмжийг тавихдаа завсар нь дамжуулагч материал, тухайлбал металл биет, соронз зэргийг байршуулж болохгүй.

Төхөөрөмжийг зүй ёсоор цэнэглэж чадахгүй эсвэл хэт халж, тэдгээр картууд гэмтэж болзошгүй.



- Хэрэв утасгүй цэнэглэгчийг сүлжээний дохионы чадал муутай газар хэрэглэвэл төхөөрөмжийн сүлжээ тасарч болзошгүй.
- Samsung-аас зөвшөөрсөн утасгүй цэнэглэгчийг хэрэглэнэ үү. Хэрэв өөр утасгүй цэнэглэгч хэрэглэвэл батареийг зүй ёсоор цэнэглэхгүй байж болзошгүй.

Хурдан цэнэглэх

Тохиргоо аппликейшныг нээгээд **Зай ба төхөөрөмжийн тусламж** → **Зай** → **Илүү их зайн тохиргоо** дээр товшоод хүссэн функцээ идэвхжүүл.

- **Хурдан цэнэглэж байна:** Хурдан цэнэглэх функцийг ашиглахын тулд адаптив хурдан цэнэглэхэд тохирсон зайн цэнэглэгчийг хэрэглэнэ үү.
- **Маш хурдан цэнэглэх:** Хэт хурдан цэнэглэх функцийг ашиглахын тулд үүнд зориулсан USB PD (цэнэг дамжуулах) цэнэглэгчийг хэрэглэнэ үү.
- **Хурдан утасгүй цэнэглэлт:** Энэ функцийг хэрэглэхийн тулд утасгүй хурдан цэнэглэх функцэд тохирсон цэнэглэгч, дагалдах хэрэгслүүдийг хэрэглэнэ.




- Төхөөрөмж эсвэл дэлгэц нь унтарсан үед зайг илүү хурдан цэнэглэж болно.
- Утасгүй хурдан цэнэглэх явцад цэнэглэгчийн дотор талын сэнс дуугарч болно. **Bixby Routines** ашиглан урьдчилан тохируулсан цагт автоматаар унтрахаар утасгүй хурдан цэнэглэх функц тохируулах горимыг нэмж оруулаарай. Утасгүй хурдан цэнэглэх функц унтарсан бол цэнэглэгчийн сэнсний чимээ, заагч гэрэл багасна.


Утасгүй тэжээл хуваалцах

Та өөрийн төхөөрөмжийн батарейгаар өөр төхөөрөмжийг цэнэглэж болно. Мөн өөрийн төхөөрөмжийг цэнэглэнгээ өөр төхөөрөмжийг цэнэглэж болно. Таны хэрэглэж байгаа дагалдах хэрэгслүүд болон хавтасны төрлөөс хамаарч, Утасгүй тэжээл хуваалцах функц ажиллахгүй байж болно. Энэ функцийг хэрэглэхийн өмнө дагалдах хэрэгслүүдийг салгахыг зөвлөж байна.


- 1 Мэдэгдлийн самбарыг нээж, доош шудар, тэгээд  дээр дараад **(Утасгүй тэжээл хуваалцах)** товшиж үүнийг идэвхжүүл. Хэрэв та түргэн самбараас  **(Утасгүй тэжээл хуваалцах)**-г олж чадаагүй бол  дээр товшиж, товчийг чирээд нэмнэ үү.
- 2 Нөгөө төхөөрөмжийг ар талаар нь өөрийн төхөөрөмжийн ар тал дээр голлуулж байрлуул.



Ухаалаг утас



Galaxy Watch



Galaxy Buds

- 3 Цэнэглэж дуусмагц төхөөрөмжүүдийг салга.

 Цэнэг хуваалцаж байх үед чихэвч хэрэглэж болохгүй. Ингэснээр ойролцоох төхөөрөмжүүдэд нөлөөлнө.



- Утасгүй цэнэглэх ороомгийн байршил төхөөрөмжийг загвар бүрд ялгаатай байж болно. Төхөөрөмжүүдийг хооронд нь зөв холбохын тулд хөдөлгөж тааруул.
- Цэнэг хуваалцаж байхад зарим функц ажиллахгүй байж болно.
- Зөвхөн утасгүй цэнэглэх функц бүхий төхөөрөмжүүдэд энэ функцийг хэрэглэн цэнэглэх боломжтой. Зарим төхөөрөмж цэнэглэгдэхгүй байж болно. Төхөөрөмжүүд Утасгүй тэжээл хуваалцах функцийг дэмжих эсхийг харахын тулд, Samsung вэб хуудсанд зочилно уу.
- Зөв цэнэглэхийн тулд төхөөрөмжүүдийн аль нэгийг хөдөлгөж, хэрэглэж болохгүй.
- Нөгөө төхөөрөмжид очиж буй цэнэгийн хэмжээ таны төхөөрөмжөөс дамжуулж буй цэнэгийн хэмжээнээс бага байж болно.
- Хэрэв та өөрийн төхөөрөмжийг цэнэглэнгээ нөгөө төхөөрөмжийг цэнэглэж байгаа бол цэнэглэх хурд буурч эсвэл цэнэглэгчийн төрлөөс хамаараад төхөөрөмж зүй ёсоор цэнэглэгдэхгүй байж болно.
- Төхөөрөмжийн нөхцөл байдал, хүрээлэн буй орчноос хамаараад цэнэглэх хурд эсвэл үр ашигт байдал янз бүр байж болно.

Цэнэг хуваалцах хязгаарыг тогтоох

Та төхөөрөмжийг зайных нь үлдэгдэл цэнэгийн хэмжээ тодорхой түвшинд хүрэхэд цэнэг хуваалцахаа зогсоохоор тохируулж болно.

Тохиргоо аппликейшныг ачаалж, **Зай ба төхөөрөмжийн тусламж** → **Зай** → **Утасгүй тэжээл хуваалцах** → **Зайн хязгаар** дээр товшиж лимитийг тохируул.

Зайны хэрэглээг багасгах

Таны төхөөрөмжид батарейн цэнэгийг хэмнэх олон алга бий.

- Төхөөрөмжийн арчилгааны функцийг хэрэглэн төхөөрөмжийн хэрэглээг сайжруулна уу.
- Төхөөрөмжийг хэрэглээгүй үедээ Хажуугийн товчийг дарж дэлгэцийг унтраа.
- Тэжээл хэмнэх горимыг идэвхжүүл.
- Хэрэгцээгүй файлуудыг хаа.
- Bluetooth функцийг хэрэглээгүй бол унтраа.
- Синхрончлох хэрэгцээтэй хэрэглүүрүүдийн автомат синхрончлолыг идэвхгүй болго.
- Дэлгэцийн гэрэлтүүлгийн хугацааг багасга.
- Дэлгэцийн цайралтыг бууруул.

Зайг цэнэглэх зөвлөмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Хэрэв батарей огт цэнэггүй болсон бол төхөөрөмж цэнэглэгч залгасан ч нэн даруй асахгүй. Төхөөрөмжийг асаахын өмнө цэнэггүй болсон батарейг хэсэг хугацаанд цэнэглэ.
- Олон тооны хэрэглүүр, сүлжээний хэрэглүүр, өөр төхөөрөмжтэй холбогдох хэрэгцээтэй хэрэглүүрүүдийг нэгэн зэрэг хэрэглэвэл батарейн цэнэгийг хурдан шавхана. Мэдээлэл дамжуулах үед цэнэггүй болохоос сэргийлж, зайг бүрэн цэнэглэсний эдгээр хэрэглүүрийг хэрэглэнэ үү.
- Цэнэглэгчээс бусад цахилгааны эх үүсвэр, тухайлбал компьютер ашиглавал цахилгаан гүйдлийн хэмжээ бага байхаас шалтгаалан цэнэглэх хурд буурна.
- Төхөөрөмжийг цэнэглэх үед хэрэглэж болох ч зайг бүрэн цэнэглэхийн тулд илүү хугацаа шаардлагатай.
- Цэнэглэх явцад төхөөрөмжид очих цахилгаан тэжээл тогтворгүй байвал мэдрэгч дэлгэц ажиллахгүй байж болзошгүй. Хэрэв ийм зүйл тохиолдвол цэнэглэгчийг төхөөрөмжөөс салга.

- Цэнэглэж байх үед төхөөрөмж халж болзошгүй. Энэ нь хэвийн үзэгдэл бөгөөд төхөөрөмжийн эдэлгээний хугацаа, гүйцэтгэлд ямар нэг нөлөө үзүүлэхгүй. Хэрэв зай ердийнхөөс илүү халж байвал цэнэглэгч цэнэглэхээ больж болно. Утасгүй цэнэглэх үед ийм зүйл тохиолдвол төхөөрөмжийг цэнэглэгчээс салгаад, дахин цэнэглэ.
- Олон зориулалттай оролт чийгтэй байхад төхөөрөмжийг цэнэглэвэл төхөөрөмж гэмтэж болзошгүй. Төхөөрөмжийг цэнэглэхийн өмнө олон зориулалттай оролтыг бүрэн хатаана уу.
- Хэрэв төхөөрөмж зохих ёсоор цэнэглэгдэхгүй байвал цэнэглэгчийн хамт Samsung-ийн засвар үйлчилгээний төвд аваачна уу.

Нано SIM карт ба eSIM

Үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн SIM буюу USIM картыг төхөөрөмжид байрлуул.


Нэг төхөөрөмж дээр хоёр өөр дугаар юм уу өөр операторын үйлчилгээг ашиглахыг хүсвэл eSIM-ийг идэвхжүүлэх юм уу хоёр SIM карт хийнэ үү. Бодит нано SIM картаас ялгаатай нь eSIM бол цахим SIM карт юм. Нано SIM карт ба eSIM-ийг хамтад нь хэрэглэснээр зарим газар мэдээлэл дамжуулалт удааширч болзошгүй.




- Бүс нутаг, үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад eSIM-г ашиглах боломжгүй байж магадгүй.
- Үйлчилгээ үзүүлэгчээс хамааран сүлжээний холболт шаардлагатай зарим үйлчилгээг хэрэглэх боломжгүй байж болно.

SIM буюу USIM карт хэрэглэх

► Galaxy Note20 Ultra 5G, Note20 Ultra:




► Galaxy Note20 5G, Note20:



- 1 Шургуулга дээрх нүх рүү хатгуураар хатгаж шургуулгыг сугална.
 - 2 Шургуулгыг үүрнээс нь зөөлөн татаж гарга.
 - 3 Шургуулгад SIM эсвэл USIM картын алтлаг контактыг доош харуулж тавиад SIM буюу USIM картыг шургуулга руу зөөлөн дарж хөдөлгөөнгүй байрлуулна.
 - 4 Шургуулгыг үүрэнд нь байрлуул.
- ❗
- Зөвхөн nano SIM карт хэрэглэнэ үү.
 - SIM буюу USIM картыг гээхгүй байх, бусдад ашиглуулахаас сэрэмжил. Samsung нь гэсэн эсвэл хулгайд алдсан карттай холбоотойгоор учирсан аливаа хохирлыг хариуцахгүй.
 - Хатгуурыг нүхэнд эгц босоо чигт хатгавал зохино. Эс бол төхөөрөмжийг гэмтээж болзошгүй.
 - Хэрэв картыг шургуулгад зөв тааруулаагүй бол SIM карт шургуулгаас сугарч, унаж болзошгүй.
 - Үүр чийгтэй байхад шургуулгыг төхөөрөмж рүү хийвэл төхөөрөмж гэмтэж болзошгүй. Шургуулгыг үргэлж хуурай байлга.
 - Шургуулгыг үүрэнд нь бүтнээр нь хийж төхөөрөмжид гаднаас шингэн орохоос хамгаал.

Картыг зөв суулгах (Galaxy Note20 Ultra 5G, Note20 Ultra)



eSIM-ийг идэвхжүүлэх

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Холболтууд** → **SIM карт удирдах** → **Мобайл багц нэмэх** дээр товш. Мобайл үйлчилгээг олсны дараа eSIM-г идэвхжүүлэхийн тулд дэлгэц дээр гарч ирэх зааврыг дага.

Хэрэв танай үйлчилгээ үзүүлэгчийн QR код байгаа бол **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Холболтууд** → **SIM карт удирдах** → **Мобайл багц нэмэх** → **Операторын QR кодыг уншуулах** дээр товшоод QR кодыг уншуул.

SIM карт удирдах


Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Холболтууд** → **SIM карт удирдах** дээр товш.

- **SIM картууд:** SIM картыг хэрэглэх болон тохиргоог өөрчлөхдөө SIM идэвхжүүл.
- **eSIM-үүд:** eSIM картыг идэвхжүүлнэ.
- **Сонгосон SIM карт:** Хоёр карт идэвхжүүлсэн тохиолдолд яриан дуудлага зэрэг тодорхой функцүүдийг хэрэглэхэд зориулсан SIM картыг сонгоно.
- **Автоматаар өгөгдөл шилжүүлэх:** Санал болгосон SIM карт сүлжээнд холбогдож чадахгүй байгаа үед дата үйлчилгээнд өөр SIM хэрэглэхээр төхөөрөмжийг тохируул.
- **Илүү их SIM картын тохиргоо:** дуудлагын болон eSIM тохиргоог хийх.

Санах ойн карт (бичил SD карт) (Galaxy Note20 Ultra 5G, Note20 Ultra)

Санах ойн карт байрлуулах

Таны төхөөрөмжийн санах ойн картын багтаамж бусад загвартай харьцуулахад өөр байж болох ба санах ойн картын үйлдвэрлэгч, төрлөөс хамааран таны төхөөрөмжид тохирохгүй байж болзошгүй. Төхөөрөмжийнхөө санах ойн картын дээд багтаамжийг Samsung-ийн вэб сайтаас үзнэ үү.



- 1 Шургуулга дээрх нүх рүү хатгуураар хатгаж шургуулгыг сугална.
- 2 Шургуулгыг үүрнээс нь зөөлөн татаж гарга.
- 3 Шургуулгад санах ойн картын алтлаг контактыг доош харуулж тавиад санах ойн картыг шургуулга руу зөөлөн дарж хөдөлгөөнгүй байрлуулна.
- 4 Шургуулгыг үүрэнд нь байрлуул.



- Зарим санах ойн карт нь таны төхөөрөмжид бүрэн тохирохгүй байж магадгүй. Тохирохгүй карт ашиглавал төхөөрөмж эсвэл санах ойн карт гэмтэх, түүнд хадгалагдаж байсан мэдээллийг гэмтээхэд хүргэж болзошгүй.
- Санах ойн картыг баруун талаар нь дээш харуулан болгоомжтой хий.
- Хатгуурыг нүхэнд эгц босоо чигт хатгавал зохино. Эс бол төхөөрөмжийг гэмтээж болзошгүй.
- Төхөөрөмжөөс шургуулгыг салгахад мобайл дата холболт идэвхгүй болно.
- Хэрэв санах ойн картыг шургуулгад зөв тааруулаагүй бол карт шургуулгаас сугарч, унаж болзошгүй.
- Үүр чийгтэй байхад шургуулгыг төхөөрөмж рүү хийвэл төхөөрөмж гэмтэж болзошгүй. Шургуулгыг үргэлж хуурай байлга.
- Шургуулгыг үүрэнд нь бүтнээр нь хийж төхөөрөмжид гаднаас шингэн орохоос хамгаал.



- Энэ төхөөрөмжид FAT болон exFAT файлын систем бүхий санах ойн карт тохирно. Өөр файлын системээр форматалсан карт хийвэл төхөөрөмж түүнийг дахин форматлах эсэхийг асуух буюу картыг танихгүй. Уг санах ойн картыг хэрэглэхийг хүсвэл форматлах шаардлагатай. Хэрэв төхөөрөмж санах ойн картыг форматалж чадахгүй эсвэл танихгүй байвал санах ойн картын үйлдвэрлэгчтэй холбоо барих буюу Samsung-ийн засвар үйлчилгээний төвд хандана уу.
- Санах ойн картад ойр ойрхон мэдээлэл бичих, арилгах нь эдэлгээний хугацааг богиносгодог.
- Санах ойн картыг төхөөрөмж рүү хийхэд **Миний файлууд** → **SD карт** хавтсанд санах ойн картан дахь файлын директорын бүтэц харагдана.

Санах ойн картыг гаргаж авах

Санах ойн картыг гэмтээлгүй гаргаж авахын тулд эхлээд үүнийг салга.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээж **Зай ба төхөөрөмжийн тусламж** → **Санах байгууламж** дээр товш.
- 2 **SD карт** хуудсыг үзэхийн тулд зүүн тийш шударна уу.
- 3 **⋮** → **Салгах** дээр товш.



Төхөөрөмж мэдээллийг дамжуулж, уншиж, байхад эсвэл мэдээлэл дамжуулж дуусангуут санах ойн карт, USB санах ой зэрэг гадаад санах ойг салгаж болохгүй. Ингэсэн тохиолдолд мэдээлэл гэмтэх, алдагдах, гадаад санах ой, төхөөрөмж гэмтэж болзошгүй. Samsung нь гадаад санах ойн төхөөрөмжийг зохистой хэрэглээгүйгээс үүдэн учирсан хохирол, үүнд: мэдээлэл алдагдах явдалд хариуцлага хүлээхгүй.

Санах ойн карт форматлах

Компьютероор форматалсан санах ойг карт төхөөрөмжид тохирохгүй байж магадгүй. Санах ойн картыг төхөөрөмжөөр форматла.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээж **Зай ба төхөөрөмжийн тусламж** → **Санах байгууламж** дээр товш.
- 2 **SD карт** хуудсыг үзэхийн тулд зүүн тийш шударна уу.
- 3 **⋮** → **Формат** дээр товш.




Санах ойн картыг форматлахын өмнө уг санах ой картад хадгалагдаж буй бүх чухал мэдээллийг хуулбарлан нөөцөлж авах нь зүйтэй. Үйлдвэрлэгчийн баталгаа нь хэрэглэгчийн үйлдлээс үүдэлтэй мэдээлэл алдагдал асуудлыг хамрахгүй.

Төхөөрөмжийг асаах ба унтраах



Агаарын хөлөг онгоц, эмнэлэг зэрэг утасгүй төхөөрөмж хэрэглэхийг хязгаарласан газарт эрх бүхий хүмүүсийн зааврыг дагаж, байрлуулсан бүх анхааруулгыг дагаж мөрд.



Дуу намсгах товч

Хажуугийн товч



Төхөөрөмжийг асаах

Хажуугийн товчийг хэдэн секундйн турш удаан дарж төхөөрөмжийг асаана.

Төхөөрөмжийг унтраах

- 1 Төхөөрөмжийн унтраахдаа хажуугийн товч ба дуу намсгах товчийг нэгэн зэрэг удаан дар. Эсвэл мэдэгдлийн самбарыг нээгээд доош шударч,  дээр товш.
- 2 **Унтраах** дээр товш.
Төхөөрөмжийг унтраагаад асаахын тулд **Дахин эхлүүлэх** дээр товш.



Та Хажуугийн товчийг удаан дарахад төхөөрөмжийг унтраахаар тохируулж болно. **Тохиргоо** хэрэглүүрийг ажилуулж, **Дэвшилтэт функц** → **Хажуу товч** дээр товшиж, **Дараад барь** дор буй **Цэсийг унтраах** дээр товшино уу.

Албадан унтрааж асаах

Хэрэв таны төхөөрөмж гацсан, хариу үйлдэл байхгүй бол хажуугийн товчийг дуу намсгах товчтой нэгэн зэрэг 7 секундээс багагүй хугацаанд дараад унтрааж асаана уу.

Яаралтай тусламжийн горим

Батарейн цэнэг зарцуулалтыг багасгахын тулд яаралтай тусламжийн горимд шилжүүлж болно. Зарим хэрэглүүр, функцийг хязгаарлана. Яаралтай тусламжийн горимд та яаралтай тусламжийн дуудлага хийж, өөрийн байршлыг бусдад мэдэгдэж, яаралтай тусламжийн дохио дуугаргах зэрэг үйлдэл хийж болно.

Яаралтай тусламжийн горимыг идэвхжүүлэхдээ Хажуугийн товч ба Дуу Намсгах товчийг нэгэн зэрэг удаан дараад **Яаралтай тусламжийн горим** дээр товш. Эсвэл мэдэгдлийн самбарыг нээгээд доош шударч,  → **Яаралтай тусламжийн горим** дээр товш.

Яаралтай тусламжийн горимыг идэвхгүй болгохын тулд  → **Яар. тусл. горимыг унтраах** дээр товш.



Хэрэглэх хугацаа нь зайн цэнэг дуусах хүртэл хэр хугацаа үлдсэнийг заана. Хэрэглэх хугацаа нь таны төхөөрөмжийн тохиргоо, ажиллагааны нөхцөлөөс хамаарна.

Бэлтгэх тохиргоо

Төхөөрөмжийг анх удаа эсвэл шинээр тохируулсны дараа асааж байгаа бол дэлгэц дээрх зааврыг дагаж төхөөрөмжийг тохируул.



Хэрэв та Wi-Fi сүлжээнд холбогдоогүй бол бэлтгэх тохиргооны явцад төхөөрөмжийн зарим функцийг тохируулах боломжгүй байж болзошгүй.

Хурууны хээ таних

Хурууны хээ таних функцийг зохих ёсоор ажиллуулахын тулд хурууны хээний мэдээллийг төхөөрөмжид бүртгэсэн байх ёстой.



- Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад энэ функцийг ашиглах боломжгүй байж болзошгүй.
- Хурууны хээ таних технологи нь хурууны хээ тус бүрийн үл давхцах үзүүлэлтийг ашиглан төхөөрөмжийн аюулгүй байдлыг сайжруулдаг. Мэдрэгчид адил төстэй хурууны хээг танихдаа будилах магадлал маш бага байдаг. Гэвч өөр хурууны хээ төстэй байх нэн ховор тохиолдолд мэдрэгч адил мэтээр таньж болзошгүй.
- Таны төхөөрөмжид дэлгэцийн хамгаалалт наасан байгаа. Хэрэв үүнийг соливол дэлгэцийн хамгаалалт нь хурууны хээний хэт авиан мэдрэгчид нөлөөлөх эсэхийг шалгана уу. Бүс нутаг эсвэл үйлчилгээ үзүүлэгчээс хамааран дэлгэцийн хамгаалалтыг наагаагүй байж болно.
- Хурууны хээ таних дэлгэцийн түгжээний аргыг хэрэглэж байгаа бол төхөөрөмжийг дөнгөж асаасны дараа үүнийг хэрэглэх боломжгүй. Төхөөрөмжийг хэрэглэхийн тулд хурууны хээ бүртгэхдээ хэрэглэсэн хээ, PIN, нууц үгээр дэлгэцийн түгжээг тайлах ёстой. Хээ, PIN, нууц үгээ мартахгүй байхад анхаарна уу.
- Хэрэв таны хурууны хээг танихгүй байвал хурууны хээ бүртгэхэд хэрэглэсэн хээ, PIN, нууц үгээр төхөөрөмжийн түгжээг тайлаад хурууны хээгээ дахин бүртгэнэ үү. Хэрэв хээ, PIN, нууц үгээ мартсан бол төхөөрөмжийг шинээр тохируулах хүртэл хэрэгдэх боломжгүй. Түгжээ тайлах кодыг мартсанаас үүдэн гарах мэдээлэл алга болох зэрэг хохиролд Samsung хариуцлага хүлээхгүй.
- Хэрэв та дэлгэцийн түгжээг хамгаалалтгүй хэлбэр болох **Шудрах** эсвэл **Байхгүй** гэж тохируулсан бол таны биометр мэдээллийг устгана. Хэрэв та зарим хэрэглүүр, функцэд биометр ашиглахыг хүсвэл, биометр мэдээллээ дахин бүртгэнэ үү.

Хурууны хээг улам сайн таних


Хурууны хээгээ төхөөрөмжид уншуулах үед тухайн функцийг ажиллагаанд нөлөөлж болзошгүй эдгээр зүйлийг анхаарна уу:

- Үрчийсэн, сорви тогтсон хурууны хээг төхөөрөмж танихгүй байж болзошгүй.
- Жижиг, хэт нарийхан хурууны хээг төхөөрөмж танихгүй байж болзошгүй.
- Таних үйлдлийг сайжруулахын тулд голчлон үйлдэл гүйцэтгэдэг гарынхаа хурууны хээг бүртгэ.
- Уг төхөөрөмжийн дэлгэцийн доод захын дунд хэсэгт хурууны хээ таних мэдрэгч бий. Мэдрэгч дэлгэцийн хамгаалалтын хуулга нь хурууны хээ таних мэдрэгчийн хэсэгт зоос, түлхүүр, хүзүүний зүүлт зэрэг биетээр зурагдаагүй бүтэн байвал зохихыг анхаар.

- Дэлгэцийн доод захын дунд талд байх хурууны хээ таних мэдрэгчийн талбай, таны хуруу цэвэр, хуурай байх ёстой.
- Хэрэв хуруугаа нугалсан, эсвэл хурууны үзүүрийг хүргэж байгаа бол төхөөрөмж таны хурууны хээг танихгүй байж болзошгүй. Хурууны хээ таних талбайд хурууны өндөг бүтэн хүрэлцэж байхаар хуруугаа дар.

Хурууны хээ бүртгэх

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Биометрик ба хамгаалалт** → **Хурууны хээ** дээр товш.
- 2 Дэлгэц дээрх зааврыг уншаад **Үргэлжлүүлэх** дээр товш.
- 3 Дэлгэц түгжих аргыг тохируул.
- 4 Хуруугаа хурууны хээ таних мэдрэгч дээр тавь. Төхөөрөмж таны хурууг таньсны дараа хуруугаа салгаж, хурууны хээ таних мэдрэгч дээр дахин тавь.
Хурууны хээ бүртгэж дуустал үйлдлийг давт.



- 5 Хурууны хээгээ бүртгэж дууссан бол **Дууслаа** дээр товш.
Та **Нэмсэн хурууны хээг шалгах** дээр товшоод таны хурууны хээг бүртгэсэн эсэхийг шалгаж болно.

Хурууны хээгээр дэлгэцийн түгжээг тайлах

Хээ, PIN, нууц үгийн оронд хурууны хээгээр дэлгэцийн түгжээг тайлж болно.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Биометрик ба хамгаалалт** → **Хурууны хээ** дээр товш.
- 2 Урьдчилан тохируулсан аргаар түгжээг тайлна.
- 3 **Хурууны хээгээр нээх** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
- 4 Түгжээтэй дэлгэц дээрх хурууны хээ таних мэдрэгч дээр хуруугаа тавиад хуруугаа уншуул.

Хурууны хээ таних дүрсийн тохиргоог өөрчлөх

Таныг дэлгэц унтарсан үед дэлгэцийг товшиход хурууны хээ таних дүрсийг нуух, харуулах эсэхийг тохируулна.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Биометрик ба хамгаалалт** → **Хурууны хээ** дээр товш.
- 2 Урьдчилан тохируулсан аргаар түгжээг тайлна.
- 3 **Дэлгэц унтрах үед дүрс харуулах** дээр товшоод зохих сонголтыг хийнэ.

Бүртгэсэн хурууны хээ устгах

Бүртгэсэн хурууны хээг устгаж болно.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Биометрик ба хамгаалалт** → **Хурууны хээ** дээр товш.
- 2 Урьдчилан тохируулсан аргаар түгжээг тайлна.
- 3 Устгах гэж буй хурууны хээг сонгоод **Арилгах** дээр товш.

Нүүр таних

Та өөрийн нүүрийг таниулаад төхөөрөмжийн түгжээг тайлахаар тохируулж болно.



- Нүүр таних дэлгэцийн түгжээний аргыг хэрэглэж байгаа бол төхөөрөмжийг дөнгөж асаасны дараа үүнийг хэрэглэх боломжгүй. Төхөөрөмжийг хэрэглэхийн тулд нүүрээ бүртгүүлэхдээ хэрэглэсэн хээ, PIN, нууц үгээр дэлгэцийн түгжээг тайлах шаардлагатай. Хээ, PIN, нууц үгээ мартаггүй байхад анхаарна уу.
- Хэрэв та дэлгэцийн түгжээг хамгаалалтгүй хэлбэр болох **Шудрах** эсвэл **Байхгүй** гэж тохируулсан бол таны биометр мэдээллийг устгана. Хэрэв та зарим хэрэглүүр, функцэд биометр ашиглахыг хүсвэл, биометр мэдээллээ дахин бүртгэнэ үү.

❗ Нүүр таних арга хэрэглэхэд анхаарах зүйлс

Нүүр царай таних технологийг төхөөрөмжийн түгжээ тайлахад хэрэглэхийн өмнө дараах анхааруулгыг байнга санах шаардлагатай.

- Таны дүр төрхтэй тун адил хүн төхөөрөмжийн түгжээг тайлж чадна.
- Нүүр таних арга нь хээ, PIN, нууц үгнээс нууцлал багатай.

Нүүрийг улам сайн таниулах

Нүүр таних аргыг хэрэглэх явцад үүнийг анхаарвал зохино:

- Нүдний шил зүүсэн, малгай өмссөн, амны хаалт зүүсэн, сахалтай, хэт их нүүрний будагтай эсэх
- Бүртгэх үед та гэрэлтүүлэг сайтай байж, камерын дуран цэвэр байх
- Сайн таниулахын тулд зураг бүдгэрээгүй байх

Нүүр бүртгэх

Нүүрийг зөв танихын тулд нүүрээ нарны шууд тусгалгүй, дотор орчинд бүртгэнэ үү.

1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Биометрик ба хамгаалалт** → **Нүүр танилт** дээр товш.

2 Дэлгэц дээрх зааврыг уншаад **Үргэлжлүүлэх** дээр товш.

3 Дэлгэц түгжих аргыг тохируул.

4 Нүүрээ дэлгэц дээрх хүрээнд багтааж тусга.

Камер таны нүүрийг уншина.



- Хэрэв таны нүүрээр дэлгэцийн түгжээ тайлагдахгүй байвал **Нүүрний өгөгдлийг арилга** дээр товшоод бүртгэсэн нүүрний мэдээллийг устгаад дахин бүртгэнэ үү.
- Царай танилтыг сайжруулахын тулд, **Танилтыг сайжруулахын тулд орлох дүр төрх нэмнэ үү** дээр товшиж царайн өөр хувилбарыг нэмнэ.

Нүүрээр дэлгэцийн түгжээ тайлах

Та хээ, PIN, нуу үгийн оронд нүүрээрээ дэлгэцийн түгжээг тайлж болно.

1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Биометрик ба хамгаалалт** → **Нүүр танилт** дээр товш.

2 Урьдчилан тохируулсан аргаар түгжээг тайлна.

3 **Нүүрээр түгжээ тайлах** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

4 Түгжээтэй дэлгэц дээр дэлгэц рүү хар.

Нүүрийг таньсан бол дахин дэлгэц түгжих арга хэрэглэхгүйгээр дэлгэцийн түгжээг тайлж болно.

Таны нүүрийг танихгүй байвал урьдчилан тохируулсан дэлгэц түгжих аргыг хэрэглэ.

Бүртгэсэн нүүрний мэдээллийг устгах

Бүртгэсэн нүүрний мэдээллийг устгаж болно.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Биометрик ба хамгаалалт** → **Нүүр танилт** дээр товш.
- 2 Урьдчилан тохируулсан аргаар түгжээг тайлна.
- 3 **Нүүрний өгөгдлийг арилга** → **Арилгах** дээр товш.
Бүртгэсэн нүүрний мэдээллийг устгасан бол холбогдох бүх функцийг идэвхгүй болгоно.

Камер

Танилцуулга

Төрөл бүрийн горимд гэрэл зураг авч, видео бичлэг хийнэ.

Камерын ёс зүй

- Бусдын гэрэл зургийг зөвшөөрөлгүй зургийг бүү ав.
- Хуулиар хориотой газар гэрэл зураг авч, бичлэг хийж болохгүй.
- Бусдын хувийн эрхийг зөрчиж болзошгүй газруудад гэрэл зураг бүү ав.

Зураг авах

- 1 **Камер** хэрэглүүрийг нээнэ.

Хажуугийн товчийг хоёр удаа хурдан дараад эсвэл түгжих дэлгэц дээр -г зүүн тал руу чирээд хэрэглүүрийг нээж болно.




- **Камер** хэрэглүүрийг түгжих дэлгэцээс нээсэн эсвэл дэлгэц түгжих аргаар дэлгэцийг унтраасан бол камерын зарим функцийг ашиглах боломжгүй байж магадгүй.
- Камерыг хэрэглээгүй бол автоматаар унтарна.
- Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад зарим аргыг ашиглах боломжгүй байж болзошгүй.

- 2 Урьдчилан харах дэлгэцийн зураг дээр товшиж камерийн фокусыг тохируулна.

Зурганд гэгээ оруулахын тулд, дугуй хүрээний тохируулах бар дээр дээш доош чирж өөрчилнө.

3 ○ дээр товшоод зураг ав.

Зураг авах горимыг өөрчлөхдөө зураг авах горимын жагсаалтыг зүүн, баруун тийш чирэх юм уу урьдчилан харах дэлгэц дээр баруун, зүүн тийш шударна.



- Зураг авах горим, хэрэглэж буй камераас хамаараад урьдчилан харуулах дэлгэц янз бүр байж болно.
- Өндөр нягтралтай эсвэл ихээр татаж томруулан зураг авах, видео бичлэг хийхэд объект хэт ойр байвал фокус таарахгүй байж болно. Зохих зайнаас зураг авч, бичлэг хийнэ үү.
- Хэрэв авсан гэрэл зураг бүдгэрсэн бол камерын дуранг цэвэрлээд дахин оролдоно уу.
- Дуран гэмтээгүй, бохирдоогүй байвал зохино. Эс бол төхөөрөмж өндөр нягтрал шаарддаг зарим горимд зөв ажиллахгүй байж болзошгүй.
- Таны төхөөрөмжийн камер өргөн өнцгийн дурантай. Хэрэв камер болон объект хоорондын зай ойрхон бол дэвсгэр дээр бүдгэрүүлэх эффект хийгдсэн тул объект ялгарна. Хэрэв объект улам холдвол объект болон дэвсгэр хоёуланг нь цэвэрхэн авах боломжтой.
- Өргөн өнцгөөр гэрэл зураг авах, видео бичлэг хийхэд бага зэргийн гажилт үүсэж болох бөгөөд төхөөрөмжийн гүйцэтгэлд бэрхшээл гарсан гэж үзэхгүй.
- Видео бичлэг хийх багтаамж нь нягтралаас хамааран янз бүр байж болно.
- Хэрэв төхөөрөмжийг гэнэт гадаа гаргах эсвэл дотор оруулбал үүний таг, агаарын температурын өөрчлөлтөөс болж конденсац үүсэж камер цантаж болно. Камерыг хэрэглэх гэж байгаа бол ийм нөхцөл үүсэхээс болгоомжлоорой. Хэрэв цантал, видео бичлэг хийх, зураг авахын өмнө камерыг өрөөний температурт байлгаж хатаагаарай, ингэхгүй бол бүдэг зураг авна.

Томруулах функц хэрэглэх

.5/1/5-ыг сонгох эсвэл томруулж жижгэрүүлэхийн тулд зүүн эсвэл баруун тийш чир. Эсвэл дэлгэц дээгүүр хоёр хуруугаар салгах хөдөлгөөнөөр томруулж, чимхэх хөдөлгөөнөөр багасга. Хэрэв томруулах харьцаа тодорхой түвшнээс хэтэрсэн бол томруулах чиглүүлэгч таныг зургийн аль хэсгийг томруулж байгааг харуулна.

- **.5**: Хэт өргөн камер нь газар орныг бодитоор харж буй мэт өргөн өнцгөөр зураг авах, бичлэг хийх боломж олгоно.
- **1**: Өргөн өнцгийн камерыг ердийн гэрэл зураг авах, видео бичлэг хийхэд хэрэглэнэ.
- **5**: Телефото камер нь объектыг сайтар томруулж зураг авах, бичлэг хийх боломж олгоно.



Зөвхөн арын камер хэрэглэж байгаа үед томруулах функцийг хэрэглэх боломжтой байна.

Камерын товчийг хэрэглэх

- Камерын товчийг товшиж удаан дараад бичлэг хийнэ.
- Багц зураг авахын тулд камерын товчийг дэлгэцийн ирмэг хүртэл шудраад барина.
- Хэрэв өөр нэгэн камерын товч нэмсэн бол түүнийгээ дэлгэцийн дурын хэсэгт байрлуулаад хялбархан зураг авч болно. Урьдчилан харах дэлгэц дээр  → **Зураг авах арга** дээр товшоод **Хөвөгч Хөшиг товчлуур** сэлгүүрийг товшиж үүнийг идэвхжүүлнэ.

Сонгосон зураг авах горимын сонголт

Урьдчилан харах дэлгэцийг товшоод дараах сонголтуудыг ашигла.

-  : Гялсгуурыг идэвхжүүлэх юм уу идэвхгүй болгоно.
-  : Камер зургийг авахаас өмнө саатуулах хугацааг сонгоно.
-  : Гэрэл зургийн харьцаа, нягтралыг сонгоно.
-  : Хөдөлгөөнт зургийг идэвхжүүлэх юм уу идэвхгүй болгоно. Хэрэв энэ функцийг идэвхжүүлсэн бол камерын товчийг товшоод хэдхэн секундын видео клип бичиж болно.
-  : Видеоог тогтворжуулахын тулд супер тогтвортой онцлогийг идэвхжүүлэх эсвэл идэвхгүй болгоно уу.
-  : Кадрын хурдыг сонгоно.
-  : Видео бичлэгийн дүрсийн харьцааг сонгоно.
-  : Видео бичлэгийн нягтралыг сонго.
-  : Шүүлтүүрийн болон гоо сайхны эффектийг оруулна.

-  : Хэмжих аргыг сонгоно. Энэ нь гэрлийн утгыг хэрхэн тооцоолохыг тодорхойлдог.  **Голдоо төвлөрсөн хэмжилт** нь зургийн төв хэсгийн гэрлийг ашиглан зураг буулгалтыг тооцоолно.  **Цэгийн хэмжилт** нь зургийн нягтарсан төв талбарын гэрлийг ашиглан зураг буулгалтыг тооцоолно.  **Матрикс хэмжилт** нь нийт үзэгдлийг дундажлана.
-  : Өнгийн тоныг тааруулна.
-  : Видео дүрсэн дэх гэрлийн хуваарилалтын графикийг харуулах юм уу нууна.
-  : **ХООЛ** горимд тойрог дотор фокус тааруулж, тойргийн гадна хэсгийг бүдгэрүүлнэ.
-  : **ХООЛ** горимд өнгийн тоныг тааруулна.
-  : Супер удаашруулсан видео бичлэг хийх үеэр хөдөлгөөн илрүүлэхийг идэвхжүүлэх юм уу идэвхгүй болгоно.
-  : **ДАВХАР БИЧЛЭГ** горимд дэлгэцийг өөрчилнө.
-  : Нэг дарж зураг авах үеийн зураг авах сонголтыг тохируулан өөрчилнө.

 Боломжит сонголтууд нь тухайн загвар болон зураг авах горимоос хамааран өөр байж болно.

Зургийн горим

Камер орчны байдлаас хамааран гэрэл зураг авах сонголтыг автоматаар тааруулж, хялбар зураг авах боломж олгоно.

Зураг авах горимын жагсаалт дээр **ГЭРЭЛ ЗУРАГ** дээр товшиж,  дээр товшоод зураг авна.

Өндөр нягтралтай зураг авах

Өндөр нягтралтай зураг ав. Та тухайн хэсгийг томруулж байгаад өндөр нягтралтай зургийг тайрч, өндөр нягтралтай файл болгон хадгалж болно.

Зураг авах сонголтууд дотор  **3:4** →  **3:4 108MP** юм уу  **3:4 64MP** дээр товшоод зураг ав.


 Загвараас хамаараад нягтрал өөр байж магадгүй.

Зургийн саналууд

Камер тухайн байрлалыг болон таны авах гэж буй биетийн өнцгийг таньж, тухайн гэрэлт зурагт тохирох төгс зохиомжийг санал болгоно.

Урьдчилан харах дэлгэц дээрх  дээр товшиж, **Зургийн саналууд** сэлгүүрийг товшоод идэвхжүүлнэ.

- 1 Зураг авах горимын жагсаалтаас **ГЭРЭЛ ЗУРАГ** дээр товш.
Урьдчилан харах дэлгэц дээр шугам гарч ирнэ.
- 2 Шугамыг объект руу чиглүүл.
Камер зохиомжийг таньж, санал болгож буй зохиомжийг урьдчилан харах дэлгэц дээр харуулна.
- 3 Төхөөрөмжийг хөдөлгөвөл санал болгосон зохиомж дээр чиглүүлэгчийг тааруулна.
Зохиомж төгс болсон бол шугамын өнгө шар болж өөрчлөгдөнө.
- 4  дээр товшоод зураг ав.



Сельфи зураг авах

Урд талын камераар сельфи зураг авна.

- 1 Урьдчилан харах дэлгэц дээр дээш, доош шудраад эсвэл  дээр товшоод өөрийн хөрөг зураг авахад зориулсан урд камерыг сонгоно.
- 2 Урд камерын дуран руу нүүрээ харуул.
Өөрийн хөрөг зургийг орчин тойрноо оролцуулан өргөн өнцгөөр эсвэл хүмүүстэй хамт байгаагаар авах бол  дээр товш.
- 3  дээр товшоод зураг ав.

Шүүлтүүр, гоо сайхны эффект оруулах

Та зураг авахаас өмнө шүүлтүүрийн эффектийг сонгож, арьсны өнгө, нүүрний хэлбэр зэрэг нүүрний онцлогийг өөрчилж болно.

1 Урьдчилан харах дэлгэц дээр  дээр товш.

2 Эффектийг сонгоод зураг ав.

Хэрэв та Миний шүүлтүүр функцийг хэрэглэж байгаа бол **Галерей** байгаа зурагтай адил өнгийн тон бүхий зургийг хэрэглэн өөрийн шүүлтүүрийг үүсгэж болно.

Фокус түгжих (AF) ба зураг буулгалт (AE)

Та фокусыг түгжиж эсвэл сонгосон хэсгийн зургийг буулгаснаар камерыг объектын эсвэл гэрлийн үүсгүүрийн өөрчлөлтөөс хамааран автоматаар тохируулахыг хязгаарлаж болно.

Фокуслах газрыг товшоод удаан дарвал тэнд AF/AE хүрээ гарч ирэх ба фокус, зураг буулгалтын тохиргоог түгжинэ. Таныг зураг авсны дараа энэ тохиргоо өөрчлөгдөхгүй.

Видео горим

Камер видео бичлэгийг хялбархан хийхдээ орчны зураг авах сонголтуудыг автоматаар тааруулна.

1 Зураг авах горимын жагсаалт дээр **ВИДЕО** дээр товшиж, дараа нь  дээр товшоод видео бичлэг хийнэ.

- Бичлэг хийнгээ урд эсвэл арын камер луу шилжихдээ харуулж буй дэлгэц дээр дээш, доош шударх юм уу -г товшино.
- Видео бичлэгийн дундуур зураг авахын тулд  дээр товш.
- Видео бичлэг хийх үеэр фокусыг өөрчлөхийн тулд фокус тааруулахыг хүссэн цэг дээр товших ба барина. Автомат фокусын горим ашиглах бол  дээр товшиж гараар фокус тааруулахыг зогсооно.
- Видео бичлэг хийх үед заасан чиглэлээс гарч буй дууны түвшнийг өндрөөр бичихдээ камерыг тухайн зүг рүү чиглүүлээд дүрсийг тааруулан томруулна.

2  дээр товшоод видео бичлэгийг зогсооно.



- Хэрэв та видео бичлэг хийх үеэр видео томруулах функцийг удаан хугацаагаар хэрэглэвэл төхөөрөмжийг хэт халахаас сэргийлж бичлэгийн чанарыг бууруулж болзошгүй.
- Оптикоор томруулах функц гэрэл багатай орчинд ажиллахгүй байж болзошгүй.

Өндөр нягтралтай видео бичлэг хийх

Хамгийн ихдээ 8K өндөр нягтралтай видео бичлэг хийнэ.

 →  дээр товшоод видео бичлэг хий.

Видео бичлэг хийж дуусах үед **Галерей** аппаар видеог тоглуул. Өөрийн дуртай хүрэн дээрх  дээр товшвол тухайн хүрээг өндөр нягтралтай гэрэл зураг болгон хадгална.

 8K эсвэл 4K -н (UHD) 60 кадр/сек-ийн өндөр нягтралтай видео бичлэг хийхэд зөвхөн дотоод санах ойд хадгалагддаг.

Видеоог тогтворжуулах (Супер тогтвортой)

Видео бичлэг хийхдээ Супер тогтворжуулагч функцийг ашиглан тогтворжуул.


Зураг авах горимын жагсаалтаас **ВИДЕО** дээр товшиж, зураг авах сонголтууд дээр -г товшиж идэвхжүүлээд видео бичлэгийг хийнэ.

Нэг удаа авах горим

Нэг удаагийн зураг авалтаар олон зураг авч, видео бичлэг хийнэ.

Төхөөрөмж хамгийн сайн зураг, бичлэгийг автоматаар сонгоз, шүүлтүүртэй зураг авах юм уу тодорхой нэг хэсгийг давтсан видео бичлэг хийнэ.

- 1 Зураг авах горимын жагсаалтаас **ГАНЦ УДАА АВАХ** дээр товш.
- 2 -г товшоод камерыг хөдөлгөж хүссэн үзэгдлийнхээ зургийг ав.
- 3 Дууссан бол урьдчилан харах товчийг товш.
Бусад үр дүнг харахын тулд — дүрсийг дээш чирнэ. Үр дүнг тус бүрд нь хадгалахыг хүсвэл **Сонгох** дээр товшоод, хүссэн зүйлсээ сонгоод  дээр товш.



Хөрөг зургийн горим / Хөрөг видео горим

Камер танд фоныг бүдгэрүүлж, объектыг орчноос нь тодруулж зураг авах, видео бичих боломж олгоно. Та мөн зураг авсныхаа дараа фонд эффект оруулж болно.

- 1 Зураг авах горимын жагсаалтаас **БОСОО** эсвэл **БУСАД** → **БОСОО ВИДЕО** дээр товш.
- 2  дээр товшоод хүссэн дэвсгэр эффектийг сонго.
Зургийн фоны эффектийн эрчийг тааруулахдаа тохируулгын хөндөл дээгүүр зүүн тийш чирнэ.
- 3 Урьдчилан харах дэлгэц дээр **Бэлэн** гарч ирвэл  дээр товшоод зураг авах юм уу  дээр товшоод видео бичнэ.



- Ашиглах боломжтой тохиргоонууд тухайн зураг авах горимоос хамааран өөр өөр байж болно.
- Энэ функцийг гэрэл сайтай газар хэрэглэнэ.
- Дараах тохиолдолд фон бүдгэрэхгүй байж болзошгүй:
 - Төхөөрөмж эсвэл объект хөдөлсөн.
 - Объект нарийхан эсвэл тунгалаг.
 - Объект арын фонтой адил өнгөтэй.
 - Объект, арын фон хоёул цулгүй.

AR зураг зурах горим

Виртуал орчинд нүүр царай гэх мэт төрөл бүрийн газарт гараар бичих, зурах үйлдлийг хөгжилтэй бичлэг болгоно.

Зураг авах горимын жагсаалтаас **БУСАД** → **AR DOODLE** дээр товш. Дэлгэрэнгүй мэдээллийг [AR Doodle](#)-ээс авна уу.

Про горим/Про видео горим

Зураг авах, бичлэг хийх, ISO хэмжээ зэрэг зураг авах параметруудийг гараар тааруулж зураг авна.

Зураг авах горимын жагсаалтаас **БУСАД** → **ПРО** эсвэл **МЭРГЭЖЛИЙН ВИДЕО** дээр товш.

Сонголтуудаас нэгийг сонгоод тохиргоог өөрчилж,  дээр товшоод зураг авах юм уу -г товшоод видео бичлэг хийнэ.

Боломжит сонголтууд

-  : Тохиргоог шинээр тохируулна.
- **ISO**: ISO үнэлгээг сонго. Камерын гэрлийн мэдрэмжийг тааруулна. Тогтвортой, гэрэлтүүлэг сайтай объектод хэмжээг багаар тааруулна. Хурдан хөдөлж байгаа, муу гэрэлтэй объектод хэмжээг ихэсгэнэ. Гэвч ISO тохиргоо өндөр байснаас зураг, видео бичлэгт "шуугиан" үүсдэг.
- **SPEED**: Зураг дарах хурдыг тохируул. Хөшигний хурд бага байх тусам гэрэл их нэвтрүүлэх тул гэрэл зураг, видео бичлэг төдий хэмжээгээр цайрна. Үүнийг шөнийн цагаар гэрэл зураг авах, бичлэг хийхэд хэрэглэх нь маш тохиромжтой. Хөшигний хурд их байх тусам гэрэл бага нэвтрүүлнэ. Үүнийг хурдан хөдөлгөөнтэй объектын зургийг авах, бичлэг хийхэд хэрэглэнэ.
- **EV**: Гэрэл сүүдэр тохируулах. Энэ нь камерын мэдрэгч хэчнээн их гэрэл хүлээн авч байгааг тогтооно. Гэрэлтүүлэг багатай орчинд зураг буулгалтын хэмжээг ихэсгэнэ.
- **FOCUS**: Фокусны төлөв өөрчлөх. Тохируулгын хөндлийг чирээд фокусыг автоматаар тааруулна.
- **WB**: Цагаан өнгийн зохих тэнцвэрийг сонгох, ингэснээр зураг жинхэнэ-амьд өнгөний хэмжээтэй болно. Та өнгийн температурыг тохируулж болно.
- **MIC**: Аль чиглэлийн дуу чимээг өндөр түвшинд бичихээ сонго. USB юм уу Bluetooth микрофоныг төхөөрөмждөө холбоод (Про видео горим) хэрэглэж болно.
- **ZOOM**: Томруулах хурдыг тааруулна (Про видео горим).

Өндөр нягтралтай про видео бичлэг хийх

Хамгийн ихдээ 8K өндөр нягтралтай про видео бичлэг хийнэ.

FHD 30 → **8K** 24 дээр товшоод про видео бичлэг хий.

Про видео бичлэг хийж дуусах үед **Галерей** аппаар үүнийг тоглуул. Өөрийн дуртай хүрээн дээрх  дээр товшвол тухайн хүрээг өндөр нягтралтай гэрэл зураг болгон хадгална.

 8K, 4K (UHD) 60 кадр/сек эсвэл FHD (120 кадр/сек)-ийн өндөр нягтралтай видео бичлэг хийхэд зөвхөн дотоод санах ойд хадгалагддаг.

Фокуслах талбар, зураг буулгах талбарыг тусгаарлах

Та фокус тааруулах талбар болон дүрс буулгах талбарыг тусгаарлаж болно.

Урьдчилан харах дэлгэцийг товшоод удаан дар. AF/AE хүрээ дэлгэц дээр гарч ирнэ. Уг хүрээг фокус, дүрс буулгалтыг салгах гэж буй талбар луу чирнэ.



Панорам горим

Панорам горимд дараалсан олон зураг авч хооронд нь зүйгээд өргөн үзэгдэлтэй гэрэл зураг бүтээдэг.

1 Зураг авах горимын жагсаалтаас **БУСАД** → **ПАНОРАМ** дээр товш.

2  дээр товшиж төхөөрөмжийг нэг чиглэлд хөдөлгө.

Камерын шагайвч дээрх хүрээнд зургийг багтаана. Хэрэв урьдчилан харж буй зураг чиглүүлж буй хүрээний гадна байх юм уу та төхөөрөмжийг хөдөлгөөгүй бол төхөөрөмж зураг авахаа автоматаар зогсооно.

3  дээр товшоод зураг авахыг зогсооно.

 Цэлмэг тэнгэр, цулгүй хана зэрэг ялгарах зүйлгүй орчны зураг авах хэрэггүй.

Хоолны горим

Хоолны зургийг тод өнгөөр авна.

- 1 Зураг авах горимын жагсаалтаас **БУСАД** → **ХООЛ** дээр товш.
- 2 Дэлгэцийг товшоод тойргийг тодруулахыг хүссэн хэсэг рүү чирнэ.
Тойргийн гадна талбайн зургийг бүдгэрүүлнэ.
Тойргийн хэмжээг өөрчлөхийн тулд хүрээний булангаас чирнэ.
- 3 Өнгийн тоныг өөрчлөхийн тулд  дээр товшоод тохируулгын хөндлийг чир.
- 4  дээр товшоод зураг ав.

Шөнийн горим


Гэрэлтүүлэг багатай нөхцөлд гялсуур хэрэглэхгүй зураг авна. Гурван хөлт суурь ашиглаж байгаа бол илүү тод, тогтвортой үр дүнд хүрэх боломжтой.

- 1 Зураг авах горимын жагсаалтаас **БУСАД** → **ШӨНӨ** дээр товш.
- 2  дээр товшоод зураг авч дуустал төхөөрөмжийг тогтвортой барь.

Супер удаашруулсан хөдөлгөөний горим

Супер удаашруулсан хөдөлгөөн бол хурдтай хөдөлгөөнийг удаашруулан бичдэг функц тул хожим үзэхэд таатай байх болно.

- 1 Зураг авах горимын жагсаалт дээр **БУСАД** → **СУПР УДАН ХӨД** дээр товшиж, дараа нь  дээр товшоод видео бичлэг хийнэ.
Төхөөрөмж супер удаашруулсан хөдөлгөөний агшныг бичиж, видео бичлэг болгон хадгална.
- 2 Урьдчилан харах дэлгэц дээрх өнгөц зургийг товш.
Супер удаашруулсан хөдөлгөөнтэй хэсгийг засахдаа  дээр товшоод хэсэгчлэн засах хөндлийг зүүн эсвэл баруун тийш чирнэ.





Энэ функцийг гэрэл сайтай газар хэрэглэнэ. Гэрэлтүүлэг муутай дотор орчинд видео бичлэг хийх үед дэлгэц харанхуйлах юм уу элсэрхэг ширхэгтэй болж болзошгүй. Зарим төрлийн, тухайлбал өдрийн гэрлээс шалтгаалан дэлгэц анивалзаж болзошгүй.

Супер удаашруулсан хөдөлгөөний видеог автоматаар бичих

Хөдөлгөөн таних талбарт хөдөлгөөн илэрмэгц тухайн агшныг супер удаашруулж бичихийн тулд  дээр товшоод идэвхжүүлнэ. Хөдөлгөөн илрүүлэх функцийг идэвхжүүлэх ба урьдчилан харуулан дэлгэц дээр хөдөлгөөн илрүүлэх талбар харагдана.



дээр товшоод бичиж эхэл. Хөдөлгөөн илэрмэгц, төхөөрөмж удаашруулан бичиж эхлэх ба видео бичлэгт хадгална.



Супер удаашруулсан хөдөлгөөний бичлэг хүссэн агшинд эхлээгүй байж болох дараах тохиолдлууд бий:

- Төхөөрөмжийг сэгсэрсэн эсвэл өөр биет хөдөлгөөн илрүүлж буй объектын орчим хөдөлсөн.
- Өдрийн гэрэл гэх мэт анивчсан гэрэлтэйд бичлэг хийсэн.

Удаашруулсан хөдөлгөөний горим

Удаашруулсан хөдөлгөөнөөр харахад зориулан видео бичлэг хийнэ. Та видео бичлэгээс удаашруулах гэж буй хэсгийг зааж болно.


1 Зураг авах горимын жагсаалт дээр **БУСАД** → **УДААН ХӨДӨЛГӨӨН** дээр товшиж, дараа нь  дээр товшоод видео бичлэг хийнэ.

2 Бичлэг хийж дууссан бол  дээр товшиж зогсооно.

3 Урьдчилан харах дэлгэц дээрх өнгөц зургийг товш.

Видео бичлэгийн хурдан хэсгийн хөдөлгөөнийг удаашруулах ба видеог тоглуулж эхэлнэ. Видео бичлэгээс хоёр хүртэлх хэсгийн хөдөлгөөнийг удаашруулна.

Удаашруулсан хөдөлгөөнтэй хэсгийг засахдаа  дээр товшоод хэсэгчлэн засах хөндлийг зүүн эсвэл баруун тийш чирнэ.



Хураагдмал горим

Нүдний өмнүүр өнгөрөх хүмүүс, машины хөдөлгөөн бүхий үзэгдлийг бичиж, хурдасгасан хөдөлгөөнтэй видео болгон үзнэ.

- 1 Зураг авах горимын жагсаалтаас **БУСАД** → **ХУРААГДМАЛ** дээр товш.
- 2  дээр товшоод кадрын хурдыг сонго.
Хэрэв та хүрээний харьцааг  -аар тохируулбал, тус төхөөрөмж нь үзэмжний өөрчлөгдөж буй харьцааг даган хүрээний харьцааг автоматаар өөрчилнө.
- 3  дээр товшоод бичиж эхэл.
- 4  дээр товшоод бичлэгийг зогсоо.

Камерын тохиргоог тохируулан өөрчлөх

Урьдчилан харах дэлгэц дээрх  дээр товш. Зураг авах горимоос шалтгаалан зарим сонголтыг ашиглах боломжгүй байж магадгүй.

Ухаалаг функцүүд

- **Үзэгдэл оновчлогч:** Төхөөрөмж өнгийн тохиргоог автоматаар тааруулах ба үзэгдэл, объектоос хамааран хамгийн оновчтой эффектийг автоматаар оруулна.
- **Зургийн саналууд:** Тухайн байрлалыг болон таны авах гэж буй биетийн өнцгийг таньж, тухайн зурагт тохирохуйц төгс зохиомжийг санал болгоно.
- **QR код уншуулах:** QR кодыг уншуулахын тулд урьдчилан харах дэлгэцээс төхөөрөмжийг тохируулна уу.

Зургууд

- **Зураг дарах товчийг шудар:** Камерын товчлуурыг дэлгэцийн ирмэгрүү шударч түүнийгээ тогтоохдоо гүйцэтгэх үйлдлийг сонгоно уу.
- **Зургийн форматууд:** Зургийг хэрхэн хадгалахаа сонго.
 - **Өндөр бүтээмжтэй зургууд:** High Efficiency Image Format (HEIF) форматаар зураг авах.
 - **RAW хуулбарууд:** Төхөөрөмжид зурган файлуудыг мэргэжлийн/про төлөвт RAW/ Боловсруулж шахаагүй хэлбэрээр (DNG файлын форматаар) хадгалахаар тохируул. RAW файл нь хамгийн чанартай зурагт зориулан гэрэл зургийн бүх мэдээллийг хадгалж үлдэх боловч санах ойд их зай эзэлнэ. Тус **RAW хуулбарууд** функцийг хэрэглэж байхад, зураг болгоныг DNG болон JPG гэсэн хоёр форматаар хадгална.

Сельфи

- **Селфиг урьдчилан харахаар хадгл:** Урд камераар авсан зургуудыг эргэлдүүлэхгүйгээр, урьдчилан харах дэлгэц дээр харагдах байдлаар хадгалахаар тохируулах.
- **Сельфийн өнгөний аяс:** Сельфи хийхэд хэрэглэх өнгөний дэвсгэрийг сонго.

Видео

- **Видео тогтворжуулалт:** Видео бичлэг хийх үеэр камер доргисноос болж зураг бүдгэрэхийг багасгаж, сэргийлэхийн тулд доргилтоос хамгаалах функцийг идэвхжүүлнэ.
 - **Бичлэгийн нэмэлт сонголтууд:** Төхөөрөмжид бичлэгийн дэвшилтэт сонголтыг хэрэглэх эсэхийг тохируулна.
 - **Файлын хэмжээг багасгах:** Та видеог High Efficiency Video Codec (HEVC) форматараар бичиж болно. HEVC видео бичлэгийг шахсан файл болгон хадгалж, төхөөрөмжийн санах ойг хэмнэнэ.
 - **HDR10+ видео:** Та үзэгдэл тус бүрт өнгө ялгаралын оворчлолтой видео бичлэг хийж чадна.
 - **Ойртуулах микрофон:** Видео бичлэг хийх явцдаа та илүү өндөр дууны түвшинд томруулсан чиглэлээс дууг бичих боломжтой.
-  • HEVC видео бичлэгийг бусад төхөөрөмжөөр тоглуулж, онлайнаар хуваалцах боломжгүй.
- Супер удаашруулсан хөдөлгөөн ба удаашруулсан хөдөлгөөний видеог HEVC форматаар бичих боломжгүй.
 - HDR10+ видео бичлэгийг зөв тоглуулахын тулд төхөөрөмж HDR10+ онцлогтой байх шаардлагатай.

Ерөнхий

- **Авто HDR:** Баялаг өнгөтэй зураг авч гэрэлтэй, бараан газар ч дүрсийг нарийн гаргана.
- **Автомат фокусыг хянах:** Төхөөрөмж сонгосон объектыг автоматаар дагах эсэхийг тохируулна. Урьдчилан харах дэлгэц дээр объектыг сонговол төхөөрөмж уг объект хөдөлж байсан ч эсвэл та камерыг хөдөлгөсөн ч түүнд автоматаар фокус тааруулна.
 -  Дараах нөхцөлд объектыг дагаж чадахгүй байж магадгүй:
 - Объект хэт том эсвэл хэт жижиг.
 - Объект хэт их хөдөлж байгаа.
 - Объектын араас гэрэл туссан эсвэл та харанхуй орчинд зураг авч байгаа.
 - Объект болон фон дээрх өнгө, хээ адил.
 - Жалюз гэх мэт хөндлөн судалтай объект.
 - Камер хэт их доргиж байгаа.
 - Видео дүрсийн нягтрал өндөр.
 - Томруулсан, багасгасан эсвэл оптикоор томруулах функцийг хэрэглэсэн.
- **Торон шугамууд:** Сэдвийг сонгох үед зохиомж хийхэд туслах үүднээс шагайвчийн хөтчийг харуулна.
- **Байрлалын шошгонууд:** Гэрэл зурагт GPS байршлын тэмдэглэгээ нэмнэ.
 - 
 - Өндөр барилгуудын хооронд, нам дор газар, цаг агаарын таагүй нөхцөл гэх мэт долгионд саад учруулж болзошгүй газарт GPS дохионы чадал буурч болзошгүй.
 - Гэрэл зургуудыг интернетэд байршуулбал тэдгээр зурагт таны байршил харагдаж болзошгүй. Үүнээс зайлсхийхийн тулд байршлын шошгын тохиргоог идэвхгүй болго.
- **Зураг авах арга:** Гэрэл зураг авах, видео бичлэг хийхэд зориулсан зураг авах нэмэлт аргыг сонгоно.
- **Хадгалах тохиргоо:** Камерыг нээх үед зураг авах горим зэрэг сүүлд хэрэглэсэн тохиргоог хэвээр хадгална.
- **Хадгалах байршил:** Санах ойгоос хадгалах байршлыг сонгоно. Санах ойн карт байрлуулсан тохиолдолд энэ функц харагдана.
- **Чичиргээний хариу үйлдэл:** Камерын товч дээр товших зэрэг тодорхой нөхцөлүүдэд чичрэхээр төхөөрөмжийг тохируул.

Нууцлал

- **Нууцлалын Мэдэгдэл:** Нууцлалын санамжийг харах.
- **Зөвшөөрлүүд:** Камерын аппыг хэрэглэхэд шаардлагатай зөвшөөрлүүдийг харах.
- **Тохиргоог сэргээх:** Камерын тохиргоог шинээр тохируулна.
- **Бидэнтэй холбоо барих:** Асуулт асуух буюу асуулт, хариултыг харуулна.
- **Камерын тухай:** Камерын хэрэглүүрийн хувилбар болон эрхзүйн мэдээллийг харна.



Загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж магадгүй.

Хэрэглүүрүүд ба функцүүд

Танилцуулга

Хэрэглүүрүүд ба төхөөрөмжийн онцлог шинж чанарыг ашиглана уу.

Энэхүү бүлэг бол Samsung төхөөрөмжүүдийн аппликейшн болон функцүүдийн нийтлэг гарын авлага юм.

Загвараас хамаарч зарим агуулга өөр байж болно, эсвэл таны төхөөрөмжид зориулагдаагүй аппликейшн болон функцийн тайлбарууд орсон байж болно.



Samsung бүртгэл

Таны Samsung бүртгэл бол мобайл төхөөрөмжөөр үзүүлж буй Samsung-ийн төрөл бүрийн үйлчилгээ, TV, Samsungs-ийн вэб сайтыг үзэх боломж олгосон нэгдсэн бүртгэлийн үйлчилгээ юм.

Samsung бүртгэлээр хэрэглэж болох үйлчилгээний жагсаалтыг account.samsung.com хуудаснаас үз.

1 **Тохиргоо** -г ажиллуулаад **Samsung account** дээр товш.

Сонголттойгоор, **Тохиргоо** аппликейшныг ажиллуулж **Данснууд ба нөөцлөлт → Бүртгэлүүд удирдах → Данс нэмэх → Samsung account** дээр товш.

2 Танд Samsung бүртгэл байгаа бол Samsung бүртгэлдээ нэвтэр.

- Хэрэв та Google бүртгэлээрээ нэвтрэхийг хүсвэл **Google-р үргэлжлүүлэх** дээр товшино уу.
- Хэрэв танд Samsung бүртгэл байхгүй бол **Аккаунт үүсгэх** дээр товш.

ID-гаа олж, нууц үгээ шинээр тохируулах

Хэрэв та Samsung бүртгэлийн ID эсвэл нууц үгээ мартсан бол нэвтрэх дэлгэц дээр **ID олох** эсвэл Samsung бүртгэлийн ID дээр **Нууц үг мартсан уу?** дээр товш. Та шаардлагатай мэдээллээ оруулсны дараа ID-гаа мэдэж авч, нууц үгээ шинээ тохируулж болно.

Samsung бүртгэлээсээ гарах

Samsung бүртгэлээсээ гарах үед харилцагчид, үйл явдал зэрэг таны мэдээллүүдийг ч бас төхөөрөмжөөс устгана.

1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Данснууд ба нөөцлөлт → Бүртгэлүүд удирдах** дээр товш.

2 Дэлгэцний доор байх **Samsung account → Миний профиль** ба дэлгэцийн доод хэсэгт байрлах **Гарах** дээр товш.


3 **Гарах** дээр товшоод Samsung бүртгэлийн нууц үгээ оруулаад **ОК** дээр товш.

Дэлгэцийн танилцуулга

Мэдрэгч дэлгэцийг удирдах


Товших

Дэлгэцийг товшино.




Товшоод удаан дарах

Дэлгэцийг товшоод 2 секунд орчим дар.




Чирэх

Дэлгэц дээрх зүйлийг товшоод удаан дарж хүргэх байрлал руу нь чирнэ.




Давхар товших

Дэлгэцийг давхар товшино.




Шудрах

Дээш, доош, зүүн тийш, баруун тийш шударна.



Салгах, чимхэх

Дэлгэц дээр хоёр хуруугаар чимхэх, салгах хөдөлгөөн хийнэ.




- Мэдрэгч дэлгэцийг аливаа цахилгаан хэрэгсэлд хүргэж болохгүй. Хуримтлагдсан цахилгаан цэнэгт цохиулснаар мэдрэгч дэлгэцийн ажиллагааг доголдуулж болзошгүй.
- Мэдрэгчтэй дэлгэцийг гэмтэхээс хамгаалахын тулд хурц үзүүртэй зүйлээр товшиж, мөн хуруугаараа хэт хүчтэй бүү дарж болохгүй.
- Мэдрэгч дэлгэц дээр хэсэгчлэн болон бүхэлд нь удаан хугацаагаар тогтмол график дүрс гаргахгүй байхыг зөвлөж байна. Ингэснээр дүрс үлдэх (дэлгэц дээр ором гарах) буюу сүүдэр тогтож болзошгүй.



Төхөөрөмж нь энэ нь мэдрэгчийн оролтын гадна байх дэлгэцийн зах орчимд шүргэх үйлдлийг танихгүй байж магадгүй.

Залуурдах мөр (мэдрэгч товчнууд)

Дэлгэцийн асаахад дэлгэцийн доод талд залуурдах мөрөн дээр мэдрэгч товч харагдана. Мэдрэгч товчнууд нь ердийн нөхцөлд Саяхны товч, Үндсэн товч, Буцах товч байна. Товчнуудын үйлдэл хэрэглэж буй хэрэглүүрээс, орчноос хамааран өөрчлөгдөж болно.



Товч	Функц
	Саяхны
○	Үндсэн
<	Буцах

Залуурдах мөрийг нуух

Файл үзэхдээ эсвэл хэрэглүүр хэрэглэхдээ залуурдах мөрийг нуугаад дэлгэцийн өргөсгөж болно.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Дэлгэц** → **Чиглүүлэх мөр** дээр товшоод **Чиглүүлэх төрөл** дор буй **Дохиог шудрах** дээр товшино уу. Залуурдах мөр харагдахгүй болж, дохионы ором харагдана. **Илүү их сонголт** дээр товшоод хүссэн сонголтоо сонго.



Доорроос шудрах



Хажуу талаас болон доорроос шудрах

Хэрэв дэлгэцийн доод талд буй эдгээр дохионы ормыг ч мөн далдлахыг хүсвэл **Дохионы тусламж** сэлгүүрийг идэвхгүй болго.

Үндсэн дэлгэц ба хэрэглүүрийн дэлгэц


Үндсэн дэлгэц нь төхөөрөмжийн бүх функцэд хандах эхлэлийн цэг юм. Үүн дээр тоноглол, холбоос, хэрэглүүр зэрэг олон зүйлийг харуулна.

Хэрэглүүрийн дэлгэц нь шинэ суурилуулсан болгоныг оролцуулан бүх хэрэглүүрийн дүрсийг харуулна.

Үндсэн дэлгэц ба хэрэглүүрийн дэлгэцийн хооронд шилжих

Хэрэглүүрийн дэлгэцийг нээхдээ үндсэн дэлгэц дээр дээш шудар.

Үндсэн дэлгэц рүү буцахын тулд хэрэглүүрийн дэлгэц дээр дээш эсвэл доош шудар. Эсвэл Үндсэн товчийг эсвэл Буцах товчийг товш.




Хэрэв үндсэн дэлгэц дээр хэрэглүүрийн товчийг нэмбэл уг товчийг товшоод Хэрэглүүрийн дэлгэцийг нээнэ. Үндсэн дэлгэц дээр, хоосон хэсэгт дарж байгаад, **Тохиргоо** дээр товш, тэгээд **Эх дэлгэц дээр Хэрэглүүрийн дэлгэц товчлуур харуул** дарж үүнийг идэвхжүүл. Хэрэглүүрийн товч үндсэн дэлгэцийн доод талд нэмэгдэнэ.



Үндсэн дэлгэцийг өөрчлөх

Үндсэн дэлгэц дээр хоосон зайг товшоод удаан дарж эсвэл хоёр хуруугаар чимхэж өөрчлөх сонголт руу орно. Энд дэлгэцийн зураг, тоноглол зэрэг зүйлсийг тохируулж болно. Мөн Үндсэн дэлгэцийн самбаруудыг нэмж, устгаж, цэгцэлж болно.

- Самбар нэмэх: Зүүн тийш шудраад  дээр товш.
- Самбарыг зөөх: Самбарыг товшоод удаан дарж шинэ байрлал руу нь чир.
- Самбарыг устгах: Уг самбар дээрх  дээр товш.



- **Дэлгэцийн зураг ба хэв маяг:** Үндсэн дэлгэц ба түгжээтэй дэлгэцийн зургийн тохиргоог өөрчилнө.
- **Загвар:** Төхөөрөмжийн загварыг өөрчилнө. Интерфейсийн өнгө, дүрс, дэлгэцийн зураг зэрэг дүрслэлийн элементүүдийг сонгосон загвараар өөрчилнө.
- **Тоноглолууд:** Тоноглол бол үндсэн дэлгэц дээр хэрэглүүрийн заасан функцийг ажиллуулж мэдээлэл авах, хялбархан хандахад зориулсан жижиг хэрэглүүр юм. Виджетийг сонгож **Нэмэх**. Үндсэн дэлгэц дээр уг тоноглолыг нэмнэ.
- **Тохиргоо:** Үндсэн дэлгэц дээрх тохиргоог тааруулна. Жишээ нь дэлгэцийн зураглал.

Үндсэн дэлгэц дээр бүх хэрэглүүрийг харуулах

Хэрэглүүрийн дэлгэцийг тусад нь хэрэглэлгүй үндсэн дэлгэц дээр бүх хэрэглүүрийг харуулахаар тохируулж болно. Үндсэн дэлгэц дээр хоосон зайг товшоод удаан дарж, **Тохиргоо** → **Эх дэлгэцийн зураглал** → **Зөвхөн Эх дэлгэц** → **Хэрэглэх** дээр товш.

Та одоо үндсэн дэлгэцийг зүүн тийш шударч байгаад бүх хэрэглүүрт хандаж болно.

Хайгчийг нээх

Төхөөрөмж дээрх контентыг хялбархан хайна.

- 1 Хэрэглүүрийн дэлгэц дээр **Хайх** дээр товш. Эсвэл мэдэгдлийн самбарыг нээгээд доош шударч, **Q** дээр товш.
- 2 Хайх үгийг оруул.
Таны төхөөрөмж дээрх аппликейшнүүд болон контентуудаас хайлтыг хийнэ.
Товчлуурт гар дээрх **Q** дээр товшвол бусад контентыг хайна.

Дэлгэц дээрх зүйлийг зөөх

Дэлгэц дээрх зүйлийг товшоод удаан дарж шинэ байрлал руу нь чир. Тухайн зүйлийг өөр самбар луу зөөхийн тулд дэлгэцийн хажуу тал руу чир.

Үндсэн дэлгэц дээр хэрэглүүрийн холбоосыг нэмэхийн тулд хэрэглүүрийн дэлгэц дээрх зүйлийг товшоод удаан дарж, **Эх дэлгэц нэм** дээр товш. Үндсэн дэлгэц дээр холбоос нэмэгдэнэ.


Та мөн тогтмол хэрэглэдэг хэрэглүүрүүдээ үндсэн дэлгэцийн доод талд байх холбоосны талбайд байрлуулж болно.

Хавтас үүсгэх

Хавтас үүсгээд төстэй хэрэглүүрүүдийг цуглуулж, хялбархан хурдан нээнэ.

Үндсэн дэлгэц дээр эсвэл хэрэглүүрийн дэлгэц дээр хэрэглүүрийг товшоод удаан дарж нөгөө хэрэглүүр дээр давхацтал чирнэ.

Сонгосон хэрэглүүрүүдийг агуулсан шинэ хавтас үүснэ. **Хавтасны нэр** дээр товшиж хавтасны нэрийг оруул.



- **Өөр хэрэглүүр нэмэх**

Хавсан дээрх **+** дээр товш. Хэрэглүүрүүдийг тэмдэглээд **Болсон** дээр товш. Мөн хэрэглүүрийг хавтас руу чирээд нэмж болно.

- **Хэрэглүүрийг хавтаснаас зөөх**

Хэрэглүүрийг товшоод удаан дарж шинэ байрлал руу нь чир.

- **Хавтас устгах**


Хавтсыг товшоод удаан дарж **Хавтсыг устгах** дээр товш. Зөвхөн тухайн хавтас устана. Уг хавтсанд байсан хэрэглүүрүүдийг хэрэглүүрийн дэлгэц дээр байрлуулна.

Захын самбар

Захын самбараас дуртай хэрэглүүр, функц рүүгээ хялбар орж болно.

Захын самбарын бариулыг дэлгэцийн төв рүү чир.

Хэрэв Захын самбарын бариул харагдахгүй байвал **Тохиргоо** хэрэглүүрийг нээж, **Дэлгэц** дээр товшиж, дараа нь **Захын самбарууд** сэлгүүрийг товшоод үүнийг идэвхжүүл.



Түгжих дэлгэц

Хажуугийн товчийг дарвал дэлгэцийг унтрааж, түгжинэ. Мөн төхөөрөмжийг заасан хугацааны турш хэрэглээгүй бол төхөөрөмжийн дэлгэц унтарч, автоматаар түгжигдэнэ.

Дэлгэцийн түгжээг тайлахын тулд дэлгэц ассан үед дурын чигт шударна.

Дэлгэц унтарсан бол Хажуугийн товчийг дараад дэлгэцийг асаана. Эсвэл дэлгэцийг давхар товшино.

Дэлгэц түгжих аргыг өөрчлөх

Дэлгэц түгжих аргыг өөрчлөхийн тулд **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Түгжих дэлгэц** → **Дэлгэцийн түгжээний төрөл** дээр товшоод аль нэг аргыг сонго.

Дэлгэцийн түгжээний төрлөөс PIN, нууц үг, биометр мэдээллийг аль нэгийг тохируулбал бусад этгээд төхөөрөмжид нэвтрэхээс сэргийлж, хувийн мэдээллээ хамгаалж чадна. Дэлгэцийн түгжээний төрлийг тохируулсны дараа төхөөрөмжийн түгжээг тайлахаар оролдох үед түгжээ тайлах код шаардана.



Хэрэв түгжээ тайлах кодыг хэд хэдэн удаа буруу оруулж, оролдлогын тоог дуусгасан бол төхөөрөмж үйлдвэрийн тохиргоог сэргээх үйлдлийг гүйцэтгэхээр тохируулж болно. **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Түгжих дэлгэц** → **Хамгаалалтын түгжээний тохиргоо** дээр товшоод урьдчилан тохируулсан түгжээ тайлах аргаар дэлгэцийн түгжээг тайлж, **Үйлд. тохиргоог авто.р сэргээх** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.

Заагч дүрс

Дэлгэцийн дээд талд төлөвийн мөрөн дээр заагч дүрс харагдана. Доорх хүснэгтэд буй дүрсүүд нь нийтлэг хэрэглэгддэг дүрсүүд юм.

Дүрс	Утга
	Сүлжээгүй
	Дохионы чадал
	Роуминг (үйлчилгээний хамрах хүрээнээс гадна байна)
	GPRS сүлжээнд холбогдсон
	EDGE сүлжээнд холбогдсон
	UMTS сүлжээнд холбогдсон
	HSDPA сүлжээнд холбогдсон
	HSPA+ сүлжээнд холбогдсон
	LTE сүлжээнд холбогдсон
	Wi-Fi холбогдсон
	Bluetooth функц идэвхжсэн

Дүрс	Утга
	Байршлын үйлчилгээг ашиглаж байна
	Дуудлага хийгдэж байна
	Аваагүй дуудлага
	Шинэ текстэн эсвэл мультимедиа зурвас
	Сэрүүлэг идэвхэжсэн
	Дуугүй горим/Чичиргээт горим
	Нислэгийн горим идэвхжсэн
	Алдаа гарсан эсвэл болгоомжлох шаардлагатай
	Зай цэнэглэж байна / Зайн цэнэгийн түвшин




- Зарим хэрэглүүрт дэлгэцийн дээд талд төлөвийн мөр харагдахгүй байж магадгүй. Төлөвийн мөрийг гаргахын тулд дэлгэцийн дээд ирмэгээс доош чир.
- Зарим заагч дүрс зөвхөн мэдэгдлийн самбарыг нээхэд л харагдана.
- Заагч айкон нь төхөөрөмжийн нийлүүлэгч, загвараас хамаарч янз бүрийн байдалтай харагдана.

Мэдэгдлийн самбар

Та шинэ мэдэгдэл хүлээн авахад, заагч айконууд төлөвийн бар/мөр дээр харагдана. Заагч дүрсийн талаар бусад мэдээллийг харахыг хүсвэл мэдэгдлийн самбарыг нээгээд дэлгэрэнгүй мэдээллийг хар.


Мэдэгдлийн самбарыг нээхдээ төлөвийн мөрийг доош чир. Мэдэгдлийн самбарыг хаахдаа дэлгэц дээгүүр дээш шудар.

Дараах функцүүдийг мэдэгдлийн самбарт хэрэглэж болно.



Шуурхай тохиргооны товч хэрэглэх

Шуурхай тохиргооны товчийг товшоод функцүүдээс сонгож идэвхжүүл. Мэдэгдлийн самбар дээгүүр доош шудраад бусад товчийг хар. Нэмэлт товч нэмэх бол (+) -г товш.



Функцийн тохиргоог өөрчлөхдөө товч бүрийн доорх бичвэрийг товш. Дэлгэрэнгүй тохиргоог харахдаа товчийг товшоод удаан дар.

Товчнуудыг цэгцлэхдээ  → **Товчлууруудыг засварлах** дээр товшиж, товчлуур дээр товших ба тогтоож, өөр байрлал руу чирнэ.

Медиа тоглуулагчийг удирдах

Медиа функцээр дуу хөгжим, видеог хялбархан удирдаж тоглуулна. Та мөн өөр төхөөрөмж дээр үргэлжлүүлэн тоглуулж болно.

- 1 Мэдэгдлийн самбарыг нээж **Медиа гаралт** дээр товш.
- 2 Удирдлага дээрх дүрсийг товшоод тоглуулагчийг удирдана.
Өөр төхөөрөмж дээр үргэлжлүүлэн тоглуулахын тулд **Smart View** дээр товшоод хүссэн төхөөрөмжөө сонгоно.

Ойролцоох төхөөрөмжийг хянах


Хурдан нээж, холбоотой байгаа ойролцоох төхөөрөмжүүдийг болон байнга хэрэглэдэг SmartThings төхөөрөмжүүдийг мэдэгдлийн самбарт хянана.

- 1 Мэдэгдлийн самбарыг нээгээд **Төхөөрөмжийн удирдлага** дээр товш.
Холбоотой байгаа ойролцоох төхөөрөмжүүд болон SmartThings төхөөрөмжүүд болон орчин харагдана.
- 2 Хянах гэж буй ойролцоох төхөөрөмжийг эсвэл SmartThings төхөөрөмжийг сонгох юм уу орчныг сонгоод нээнэ.

Бичвэр бичих

Товчлуурт гарын зураглал

Бичвэр оруулах үед товчлуурт гар автоматаар харагдана.



Зарим хэлээр бичвэр оруулах боломжгүй. Текст оруулахын тулд та оролтын хэлийг аль нэг дэмжигддэг хэлээр солих ёстой.

Оролтын хэлийг өөрчлөх

⚙️ → **Хэл, төрөл** → **Оролтын хэлүүдийг удирдах** дээр товшоод хэрэглэх хэлээ сонгоно уу. Хоёр буюу түүнээс олон хэл сонгосон үед оролтын хэлийг сэлгэхдээ зай авах товчлуурыг зүүн, баруун тийш шудар.

Товчлуурт гарыг өөрчлөх

Залуурдах мөрөн дээр дээр товшиж товчлуурт гарыг өөрчилнө.

Товчлуурт гарын төрлийг өөрчлөхийн тулд ⚙️ → **Хэл, төрөл** дээр товшоод хэлээ сонгож, хүссэн товчлуурт гарын төрлийг сонгоно.



- Хэрэв Залуурдах мөр дээр товчлуурын товчнууд () харагдахгүй бол, **Тохиргоо** аппликейшныг ачааллаж, **Ерөнхий удирдлага** → **Гарын жагсаалт ба өгөгдмөл** дээр товшоод, **Чиглүүлэх мөрөн дээрх гарын товчлуур** дээр дарж үүнийг идэвхжүүл.
- 3 x 4** товчлуурт гар дээр гурав эсвэл дөрвөн үсэгтэй товчнууд байна. Тэмдэгт оруулахын тулд хүссэн тэмдэгт гарч ирэх хүртэл харгалзах товчлуурыг давтаж товшино уу.

Хуулах, буулгах

- 1 Бичвэр дээр товшоод удаан дар.
- 2  эсвэл  дүрсийг хүссэн бичвэр дээгүүр чирээд сонгох юм уу **Бүгдийг сонгох** дээр товшиж бүх бичвэрийг хуулна.
- 3 **Хуулах** эсвэл **Хайчлах** дээр товш.
Сонгосон бичвэрийг санамж руу хуулна.
- 4 Бичвэрийг оруулах гэж буй газраа товшоод удаан дарж **Наах** дээр товш.
Өмнө хуулсан бичвэрээ буулгахдаа **Түр санах ой** дээр товшоод бичвэрээ сонгоно.

Хэрэглүүр суурилуулах, устгах

Galaxy Store

Хэрэглүүрийг худалдаж аваад татаж авна. Та Samsung Galaxy төхөөрөмжид зориулсан хэрэглүүрүүдийг татаж авч болно.

Galaxy Store хэрэглүүрийг нээнэ үү. Түлхүүр үг хайхын тулд аппыг категороор нь үзэх эсвэл **Q** дээр товшино уу.



- Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад энэ хэрэглүүрийг ашиглах боломжгүй байж болзошгүй.
- Автоматаар шинэчлэх тохиргоог өөрчлөхдөө **≡** → **⚙** → **Автоматаар шинэчлх хэрэглүүрүүд** дээр товшоод аль нэгийг сонгоно.

Play Store

Хэрэглүүрийг худалдаж аваад татаж авна.

Play Store хэрэглүүрийг нээнэ үү. Хэрэглүүрийг төрлөөр нь ангилан үзэх юм уу түлхүүр үгээр хайна уу.



- Автоматаар шинэчлэх тохиргоог өөрчлөхдөө бүртгэлийнхээ дүрс дээр товшиж **Тохиргоо** → **Сүлжээний тохиргоо** → **Аппуудыг автоматаар шинэчлэх** дээр товшоод аль нэгийг сонгоно.

Хэрэглүүрүүдийг удирдах

Хэрэглүүрийг устгах эсвэл идэвхгүй болгох

Хэрэглүүрийг товшоод удаан дараад аль нэгийг нь сонгоно.

- **Устгах:** Татаж авсан хэрэглүүрийг устгана.
- **Идэвхгүй болгох:** Төхөөрөмжөөс устгах боломжгүй өгөгдмөл хэрэглүүрийг сонгоод идэвхгүй болгоно.



- Зарим хэрэглүүрт энэ функц тохирохгүй.

Хэрэглүүрийг идэвхжүүлэх

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Хэрэглүүр** → **⌵** → **Идэвхгүй болсон** → **Батлах** дээр товшиж аль нэг хэрэглүүрийг сонгоод **Идэвхжүүлэх** дээр товшино.

Хэрэглүүрийн зөвшөөрлийг тохируулах

Зарим хэрэглүүрүүд зөв ажиллахын тулд таны төхөөрөмж дээрх мэдээлэлд хандах юм уу ашиглах хэрэгтэй байдаг.

Хэрэглүүрийнхээ зөвшөөрлийн тохиргоог харахын тулд **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Хэрэглүүр** дээр товшино. Хэрэглүүрийг сонгоод **Зөвшөөрлүүд** дээр товшино. Та хэрэглүүрийг зөвшөөрлүүдийн жагсаалтыг харж, өөрчилж болно.

Зөвшөөрлийн тохиргоог ангиллаар нь харах юм уу өөрчлөхийн тулд **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Хэрэглүүр** →  → **Зөвшөөрлийн менежер** дээр товшино уу. Аль нэгийг сонгоод хэрэглүүрийг сонго.



Хэрэв та хэрэглүүрт зөвшөөрөл олгоогүй бол тухайн хэрэглүүрийн үндсэн функцүүд ажиллахгүй байж болзошгүй.

Утас

Танилцуулга


Яриан болон видео дуудлага хийж, дуудлагад хариулна.



Хэрэв дээд талын микрофоны орчим халхлагдсан байвал дуудлагын явцад шуугианыг дарахгүй байж болзошгүй. Дэлгэцийн хамгаалалтын хуулга, дээд микрофоны орчим стикер зэрэг дагалдах зүйлсийг салгаж ав.

Дуудлага хийх

- 1 **Утас** хэрэглүүрийг нээгээд **Товчлуур** дээр товш.
- 2 Утасны дугаарыг оруул.
- 3  дээр товшоод яриан дуудлага хийх юм уу  эсвэл  дээр товшоод видео дуудлага хий.



Дуудлагын бүртгэлээс эсвэл харилцагчийн жагсаалтаас дуудлага хийх

Утас хэрэглүүрийг нээгээд **Сүүлийн** эсвэл **Харилцагчид** дээр товшоод харилцагчийг эсвэл утасны дугаарыг баруун тийш шудраад дуудлага хийнэ.

Хэрэв энэ онцлог идэвхгүй болсон байвал, **Тохиргоо** → **Бусад дуудлагын тохиргоо**, нь дээр товшиж дараан **Шудрч дуудлага хийх ба текст бич** сэлгүүр дээр товшиж идэвхжүүл.

Хурдан залгах аргыг ашиглах

Хурдан залгах дугаарыг тохируулахын тулд **Утас** хэрэглүүрийг нээгээд **Товчлуур** эсвэл **Харилцагчид** → **Шууд залгалтын дугаар** дээр товшиж, хурдан залгах дугаараа сонгоод утасны дугаарыг нэмнэ.

Дуудлага хийхдээ товчлуурын хурдан залгахаар сонгосон дугаарыг товшоод удаан дарна. 10 буюу түүнээс дээших хурдан залгах дугаараар залгахдаа эхний цифрүүдийг товшиж цуглуулсны дараа сүүлийн орныг товшоод удаан дарна.

Жишээлбэл: Хэрэв та **123** гэсэн дугаараар хурдан залгахаар тохируулах гэж байгаа бол **1**-ийг товшиж, **2**-ыг товшоод дараа нь **3**-ыг товшоод удаан дарна.

Олон улсын дуудлага хийх

- 1 **Утас** хэрэглүүрийг нээгээд **Товчлуур** дээр товш.
- 2 **0** товчийг товшиж, **+** тэмдэг гартал дарна.
- 3 Улсын код, утасны дугаарыг оруулаад  дээр товш.

Дуудлага хүлээн авах

Дуудлагад хариулах

Дуудлага ирэх үед  дүрсийг тойргоос гартал чирнэ.

Дуудлагаас татгалзах

Дуудлага ирэх үед  дүрсийг тойргоос гартал чирнэ.

Ирж буй дуудлагаас зурвас бичиж татгалзахдаа **Зурвас илгээх** мөрийг дээш чирч илгээх зурвасаа сонгоно.

Татгалзах зурвасыг олон янзаар үүсгэхийн тулд **Утас** хэрэглүүрийг нээгээд **Тохиргоо** → **Зурвасаас түргэн татгалзах** дээр товшоод зурвасаа оруулж **+** дээр товш.

Утасны дугаарыг хориглох

Хориглох жагсаалтад заасан дугааруудаас ирэх дуудлагыг хориглоно.

- 1 **Утас** хэрэглүүрийг нээгээд  → **Тохиргоо** → **Дугааруудыг хориглох** дээр товш.
- 2 **Сүүлийн** эсвэл **Харилцагчид** дээр товшоод харилцагч юм уу утасны дугаарыг сонгоод **Болсон** дээр товш.
Дугаарыг гараар оруулахын тулд **Утасны дугаар нэмэх** дээр товшиж, утасны дугаарыг оруулаад  дээр товш.

Хориглосон дугаар тан руу залгахад та мэдэгдэл хүлээн авахгүй. Дуудлагыг дуудлагын бүртгэлд хадгална.



Та дуудлагын дугаараа харуулаагүй хүмүүсээс ирж буй дуудлагыг хааж болно. **Үл мэдх/хув.н дугаарудг хоригло** дээр товшиж энэ функцыг идэвхжүүл.

Харилцагчид

Танилцуулга

Төхөөрөмж дээр шинэ харилцагч үүсгэх эсвэл харилцагчдыг удирдана.

Харилцагч нэмэх

Шинэ харилцагч үүсгэх

- 1 **Харилцагчид** хэрэглүүрийг нээгээд **+** дээр товш.
- 2 Санах ойн байрлалыг сонгоно.
- 3 Харилцагчийн мэдээллийг оруулаад **Хадгалах** дээр товш.

Харилцагчдын мэдээллийг импортлох

Өөр санах ойгоос харилцагчдыг импортолж таны төхөөрөмжид нэмнэ.

- 1 **Харилцагчид** хэрэглүүрийг нээгээд **≡** → **Харилцагчдыг удирдах** → **Харил.чид импортлох, экспортлох** → **Import** дээр товш.
- 2 Дэлгэц дээрх зааврыг дагаж харилцагчдыг импортолно.

Харилцагчдын санг вэб бүртгэлтэйгээ синхрончлох

Төхөөрөмж дээрх харилцагчдыг Samsung бүртгэл гэх мэт вэб бүртгэлд хадгалагдсан онлайн харилцагчидтай синхрончилно.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд, **Данснууд ба нөөцлөлт** → **Бүртгэлүүд удирдах** дээр товшиж синхрончлох бүртгэлээ сонгоно уу.
- 2 **Данс синхрончлох** дээр товшоод **Харилцагчид** сэлгүүрийг товшоод синхрончилно.

Харилцагчийг хайх

Харилцагчид хэрэглүүрийг нээ. Харилцагчийн жагсаалтын дээд талд **Q** дээр товшоод хайлтын шалгуурыг оруулна.

Харилцагчийг товш. Дараа нь дараах үйлдлийн нэгийг гүйцэтгэнэ:

-  : Яриан дуудлага хий.
-  /  : Видео дуудлага хий.
-  : Зурвас бич.
-  : Цахим шуудан бич.

Харилцагчдыг устгах

1 **Харилцагчид** хэрэглүүрийг нээгээд  → **Харилцагчдыг устгах** дээр товш.

2 Харилцагчдыг сонгоод **Устгах** дээр товш.

Харилцагчдыг нэг бүрчлэн устгахын тулд харилцагчидын жагсаалтаас харилцагчийг товшоод **Бусад** → **Устгах** дээр товш.

Харилцагчдын мэдээллийг хуваалцах

Та янз бүрийн хуваалцах сонголтын тусламжтай харилцагчдыг хуваалцаж болно.

1 **Харилцагчид** хэрэглүүрийг нээгээд  → **Харилцагчдыг хуваалц** дээр товш.

2 Харилцагчдыг сонгоод **Хуваалцах** дээр товш.

3 Хуваалцах хэлбэрийг сонго.

Бүлэг үүсгэх

Та гэр бүл, найзууд зэрэг бүлэг нэмж харилцагчдаа бүлэглэн удирдаж болно.

1 **Харилцагчид** хэрэглүүрийг нээгээд  → **Бүлгүүд** → **Бүлэг үүсгэх** дээр товш.

2 Дэлгэц дээрх зааврыг дагаж бүлэг үүсгэнэ.

Давхардсан харилцагчдыг нэгтгэх

Хэрэв таны харилцагчдын жагсаалтад харилцагчид давхардаж байвал нэгтгээд жагсаалтаа цэгцлээрэй.

1 **Харилцагчид** хэрэглүүрийг нээгээд  → **Харилцагчдыг удирдах** → **Харилцагчдыг нэгтгэх** дээр товш.

2 Харилцагч дээр тэмдэг тавиад **Нэгтгэх** дээр товш.

Зурвасууд


Танилцуулга

Зурвас илгээж, харилцан яриагаар бүлэглэж харна.

Та роуминг горимд зурвас илгээж, хүлээн авбал нэмэлт төлбөр тооцож болзошгүй.

Зурвас илгээх

- 1 **Зурвасууд** хэрэглүүрийг нээгээд  дээр товш.
- 2 Хүлээн авагчдыг нэмээд зурвасаа бичнэ.
Дуут зурвас бичиж, илгээхийн тулд  дээр товшоод удаан дарж зурвасын агуулгыг хэлж, хуруугаа салгана. Зурвасын оролт хоосон үед л бичлэгийн дүрс харагдана.
- 3  дээр товшоод зурвасыг илгээ.



Зурвас харах

- 1 **Зурвасууд** хэрэглүүрийг товшоод **Ярианууд** дээр товш.
- 2 Зурвасын жагсаалт дээр харилцагчийг эсвэл утасны дугаарыг сонго.
 - Хариу зурвас илгээхийн тулд зурвас дээр товшиж, зурвасаа бичээд  дээр товшино.
 - Үсгийн хэмжээг тааруулахын тулд дэлгэц дээр хоёр хуруугаар чимхэх, салгах хөдөлгөөн хийнэ.

Зурвасыг эрэмбэлэх

Та зурвасыг ангиллаар ялгаж, хялбархан удирдаж болно.

Зурвасууд аппликейшныг ачаалж **Ярианууд** →  дээр товш.

Хэрэв ангиллын сонголт харагдахгүй байвал  → **Тохиргоо** дээр товшоод **Харилцан ярианы ангилал** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.

Зурвас устгах

Устгах зурвас дээрээ товшиж удаан дараад **Устгах** дээр товш.

Зурвасын тохиргоог өөрчлөх

Зурвасууд хэрэглүүрийг нээж  → **Тохиргоо** дээр товш. Хэрэгцээгүй зурвасуудыг хориглож, мэдэгдлийн тохиргоо зэргийг өөрчилж болно.

Интернэт

Интернэтээр аялж, таалагдсан вэб хуудсандаа хавчуурга тавьж, тэдгээрт хандахад амархан байна.

1 **Интернэт** хэрэглүүрийг нээ.

2 Вэб хаягийг оруулаад **Очих** дээр товш.

Хэрэгслийн мөрийг харахын тулд дэлгэц дээр хуруугаар үл ялиг доош чирнэ.

Хуудас хооронд хурдан шилжихийн тулд хаягийн талбар дээгүүр зүүн эсвэл баруун тийш шударна.



Нууц горим ашиглах

Хэрэв та нууцалсан горимын нууц үгийг тохируулсан бол өөрийн хайлтын түүх, вэб үзсэн түүх, хадгалсан хуудсуудыг бусад хүмүүст харуулахаас сэргийлж болно.

1 → **Нууц горимыг идэвхжүүл** дээр товш.

2 **Нууц горимыг түгжих** сэлгүүрийг товшиж идэвхжүүлээд, **Эхлүүлэх** дээр товшоод нууц горимын нууц үгийг тохируул.


Нууц горимд төхөөрөмжийн хэрэгслийн мөрний өнгө өөрчлөгдөнө. Нууц горимыг идэвхгүй болгохын тулд → **Нууц горимыг идэвхгүй болгох** дээр товш.

Нууц горимд та дэлгэцийн зураг авах гэх мэт зарим функцийг ашиглах боломжгүй.


Олон цонх

Танилцуулга

Олон цонхоор хоёр хэрэглүүрийг нэгэн зэрэг дэлгэцийг хувааж ажиллуулна. Попап цонхоор ч мөн олон хэрэглүүрийг нэгэн зэрэг хэрэглэж болно.



Дэлгэц хувааж харах



Попап



Зарим хэрэглүүрт энэ функц тохирохгүй.

Дэлгэц хувааж харах

- 1 Саяхны товчийг товшоод саяхан хэрэглэсэн хэрэглүүрүүдийг нээ.
- 2 Зүүн эсвэл баруун тийш шударч, хэрэглүүрийн дүрсийг товшоод **Дэлгэц хуваах горимд нээх** дээр товш.
- 3 Хэрэглүүрийн жагсаалт дээрээс, өөр нээх хэрэглүүр сонгоно.

Захын самбараас хэрэглүүрийг нээх

- 1 Хэрэглүүр ашиглах үед Захын самбарын бариулыг дэлгэцийн төв рүү чирнэ.
- 2 Хэрэглүүр дээр товшиж удаан дараад зүүн тийш шударч, **Энд орхиж нээнэ үү** гэсэн газарт нээнэ. Сонгосон хэрэглүүрийг дэлгэц хувааж харах горимд нээнэ.



Хэрэглүүрийг нэг товшоод дэлгэц хувааж харах горимд нээхээр тохируулж болно.  → **Засварлах** →  дээр товшоод **Дэлгэц хувааж харахаар нээх** дор буй **Товших** дээр товшино уу. Хэрэв та **Сүүлийн хэрэглүүрүүдийг харуул** сэлгүүрийг товшиж идэвхжүүлсэн бол сүүлд хэрэглэсэн хэрэглүүрүүдээ Захын самбараас дэлгэц хувааж харах горимд нээж болно.

Хос хэрэглүүр нэмэх

Байнга хэрэглэдэг хоёр хэрэглүүрийг Захын самбар луу нэмж, нэг товшилтоор хамтад нь дэлгэц хувааж нээнэ.

- 1 Дэлгэц хувааж харах горимд хэрэглүүрийн цонхнуудын хооронд байгаа дугуйг товшино.
- 2  дээр товш.
Дэлгэц хувааж харах горимд хэрэглэж байгаа хоёр хэрэглүүрийг Захын самбарт хос хэрэглүүр болгон хадгална.

Цонхны хэмжээг өөрчлөх

Цонхны хэмжээг тохируулахын тулд хэрэглүүрийн цонхны хоорондох тойргийг чирнэ үү.

Цонхнуудын хоорондын дугуйг дэлгэцийн ирмэг хүртэл чирвэл цонхыг томоор дэлгэнэ.

Попап

- 1 Саяхны товчийг товшоод саяхан хэрэглэсэн хэрэглүүрүүдийг нээ.
- 2 Зүүн эсвэл баруун тийш шударч, хэрэглүүрийн дүрсийг товшоод **Жижиг цонхонд нээх** дээр товш. Хэрэглүүрийн дэлгэц попап цонхонд гарч ирнэ.
Попап цонхыг хэрэглэх үед Үндсэн товчийг товшвол цонхыг буулгах ба хэрэглүүрийн дүрс болгож харуулна. Попап цонхыг дахин хэрэглэхийн тулд хэрэглүүрийн дүрсийг дахин товш.

Захын самбараас хэрэглүүрийг нээх

- 1 Захын самбарын бариулыг дэлгэцийн төв рүү чир.
- 2 Хэрэглүүр дээр товшиж удаан дараад зүүн тийш шударч, **Энд тавьж жижиг цонх хэлбэрээр харна уу** гэсэн газарт нээнэ.
Сонгосон хэрэглүүрийг попап цонхонд нээнэ.

Попап цонхнуудыг зөөх

Попап цонхыг зөөхдөө цонхны хэрэгслийн мөрийг товшоод зөөнө.

Bixby

Танилцуулга

Bixby бол төхөөрөмжийг өөрт илүү эвтэйхэн ашиглах тань туслах хэрэглэгчийн интерфейс юм.

Та Bixby-тэй ярьж, бичгээр харилцаж болно. Bixby таны хүссэн функцийг нээж, хүссэн мэдээллийг тань харуулна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.samsung.com/bixby хуудаснаас авна уу.



Bixby-г зөвхөн цөөн хэлээр ашиглах боломжтой тул танай бүс нутгаас хамааран ашиглах боломжгүй байж болно.

Bixby-г эхлүүлэх

Хажуугийн товчийг удаан дараад Bixby-г нээнэ. Bixby-г танилцуулах хуудас гарч ирнэ. Bixby-д хэрэглэх хэлээ сонгосны дараа Samsung бүртгэлдээ нэвтэрч, дэлгэц дээрх зааврыг дагаж тохиргоог хийсний дараа Bixby дэлгэц гарч ирнэ.

Bixby-г хэрэглэх

Хажуугийн товчийг удаан дараад, Bixby-д юу хүсэж буйгаа хэлээд товчноос хуруугаа авна. Эсвэл "Hi, Bixby" гэж хэлээд юу хүсэж байгаагаа хэлнэ.

Жишээлбэл: Хажуугийн товчийг удаан дараад "How's the weather today?" (Өнөөдөр цаг агаар ямар байна вэ?) гэж хэл. Дэлгэц дээр цаг агаарын мэдээлэл гарч ирнэ.

Маргаашийн цаг агаарын талаар мэдэхийг хүсэж байвал Хажуугийн товчийг удаан дарж байгаад "Tomorrow?" (Маргааш?) гэж хэл.

Хэрэв Bixby тантай ярилцаж байхдаа асуулт асуувал Хажуугийн товчлуурыг дарж байгаад Bixby-д хариултаа өгнө үү. Эсвэл  дээр товшоод Bixby-д хариул.

Хэрэв чихэвч юм уу Bluetooth аудио төхөөрөмж хэрэглэж байгаа бол "Hi, Bixby" гэж хэлээд яриа эхэлж дүрсийг товшилгүйгээр яриаг үргэлжлүүлж болно. **Bixby** хэрэглүүрийг нээгээд  →  → **Automatic listening** → **Hands-free only** дээр товшино уу.

Дуу хоолойгоор Bixby-г сэрээх

Та "Hi, Bixby" гэж хэлээд Bixby-тэй яриа эхэлж болно. Дуу хоолойгоор бүртгүүлбэл Bixby таныг "Hi, Bixby" гэж хэлэх дуу хоолойнд хариу үйлдэл үзүүлнэ.

- 1 **Bixby** хэрэглүүрийг нээгээд  →  → **Voice wake-up** дээр товш.
- 2 **Wake with "Hi, Bixby"** дээр товшоод үүнийг идэвхжүүлнэ.
- 3 Идэвхжүүлэхийн тулд **Recognise voice** товшиж сэлгэ.
- 4 Дэлгэц дээрх зааврыг дагаж тохиргоог дуусгана уу.
Та одоо "Hi, Bixby" гэж хэлээд ярилцаж эхэлж болно.

Бичвэр бичиж харилцах

Орчны шуугианаас болж таны дуу хоолойг танихгүй байвал эсвэл та ярихад хэцүү нөхцөлд байгаа бол Bixby-тэй бичгээр харилцаж болно.

Bixby хэрэглүүрийг нээгээд  дээр товшиж, хүсэж буй зүйлээ бич.

Харилцах явцад Bixby танд дуу хоолойгоор бус бичвэрээр хариулах болно.

Bixby Хараа

Танилцуулга

Bixby хараа бол зургаас дүрс таних олон янзын функцэд суурилсан үйлчилгээ юм. Та объектын мэдээллийг шуурхай хайхын тулд Bixby харааг хэрэглэж болно. Bixby харааны олон тооны хэрэгцээтэй функцүүдийг хэрэглээрэй.



- Энэ функцийг хараахан хэрэглэх боломжгүй бөгөөд зургийн хэмжээ, формат, нягтралаас хамааран танд хайлтын үр дүнг зөв харуулахгүй байж болно.
- Samsung нь Bixby хараагаар үзүүлж байгаа бүтээгдэхүүний тухайд хариуцлага хүлээхгүй.

Bixby харааг нээх

Эдгээр аргын аль нэгээр Bixby харааг нээнэ.

- **Камер** хэрэглүүрт зураг авах горимоос **БУСАД** дээр товшоод **BIXBY VISION**-г товш.
- **Галерей** хэрэглүүрт зургийг сонгоод товшино .
- **Интернэт** хэрэглүүрт зургийг товшоод дарж байгаад **Bixby Vision-р хайх** дээр товшино.
- Хэрэв та хэрэглүүрийн дэлгэц дээр Bixby харааг нэмсэн бол **Bixby Vision** хэрэглүүрийг нээ.

Bixby харааг хэрэглэх

1 Bixby харааг нээнэ.

2 Хэрэглэхийг хүссэн функцээ сонго.

-  : Бичиг баримт, зургаас бичвэр таньж, орчуулна.
-  : Онлайнаар илрүүлсэн объекттой төстэй зураг болон холбогдох мэдээллийг хайна.
-  : Бүтээгдэхүүний мэдээллийг хайна.



Танай бүс нутаг, үйлчилгээ үзүүлэгчээс хамаараад хэрэглэж болох функц, хайлтын үр дүн өөр байж болно.

Bixby Routines

Танилцуулга

Хэрэглээний давтамжаа хэвшил болгон нэмээд төхөөрөмжөө илүү тухтай хэрэглэх боломжтой.

Жишээ нь "унтахын өмнө" хэвслээр унтахын өмнө утсаа төхөөрөмжийг хэрэглэхэд нүд, чихэнд тээр болохгүйн тулд чимээгүй горим ба харанхуй горимыг идэвхжүүлнэ.

Хэвшил нэмэх

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **Bixby Routines** дээр товш.
- 2 **Олж нээх** жагсаалт дээр хүссэн хэвслээ сонгох, эсвэл **Хэвшил нэмэх** дээр товшиж өөрийн хэвслийг нэмнэ.
 - Та **Олж нээх** жагсаалтад хэвслийн нөхцөл ба үйлдлээ тохируулж болно.
 - Хэрэв тухайн хэвслийн ажиллах нөхцөлийг гараар тохируулахыг хүсвэл **Гараар эхлүүлэх** дээр товшоорой. Ажиллаж байгаа хэвшил байхгүй тохиолдолд л энэ сонголт харагдана. Попап цонх гарч ирвэл **Нэмэх** дээр товш. Үндсэн дэлгэц дээр хэвслийг тоног болгон нэмээд түүнд хурдан хандаж болно.



Зөвлөж буй хэвшлийг нэмэх

Төхөөрөмж таны хэрэглээний хэв шинжийг судалж, танд хэрэгтэй гэж үзсэн эсвэл таны тогтмол хэрэглэж байгаа функцийг хэвшил гэж үзэж нэмэхийг санал болгоно.

Зөвлөмжийн мэдэгдэл гарч ирэхэд мэдэгдэл дээр товшоод өөрийн хэвшил болгон хадгал.

Хэвшлийг хэрэглэх

Автомат хэвшлийг ажиллуулах

Автомат хэвшлүүд нь заагдсан нөхцөл нь бүрдсэн үед автоматаар ажиллана.

Хэвшлийг гараар ажиллуулах

Гараар эхлүүлэх гэсэн нөхцөлд ажиллахаар тохируулсан хэвшлүүдийг ажиллуулахдаа дурдсан товчийг товшоод хялбархан ажиллуулж болно.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **Bixby Routines** → **Миний хэвшил** дээр товшиж, хэрэглэхийг хүссэн зуршлын дэргэдэх  дээр товш. Эсвэл үндсэн дэлгэц дээр хэвшлийн тоноглолыг нэмээд, товшиж хэрэглэж болно.

Ажиллаж буй хэвшлийг харах

Тухайн мөчид идэвхтэй байгаа хэвшлүүдийг мэдэгдлийн самбарт харуулна. Хэвшлийн дэлгэрэнгүй мэдээллийг харахдаа мэдэгдлийг товш.

Мөн та ажиллаж буй хэвшлийг хялбархан зогсоож болно. Мэдэгдлийн самбарт хэвшлийн дэргэдэх  -г товшоод **Зогсоох** дээр товш.

Хэвшлийг удирдах

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **Bixby Routines** → **Миний хэвшил** дээр товш. Таны хэвшлүүд харагдана.

Хэвшлийг идэвхгүй болгохын тулд, хэвшил →  → **Энэ хэвслг идэвхгүй болго** гэдгийг товшино уу.

Хэвшлийг устгахдаа  → **Засварлах** дээр товшиж, устгах хэвшлийг тэмдэглээд **Устгах** дээр товш.

Samsung Kids

Та хүүхэд төхөөрөмжийг хэрэглэх үедээ зарим хэрэглүүрт хандахаас сэргийлэх, тэдний хэрэглэх хугацааг тохируулах, хүүхдэд зориулсан хөгжилтэй, аюулгүй орчин бүрдүүлэхийн тулд тохиргоог тааруулж болно.

Мэдэгдлийн самбарыг нээгээд, доош шударч,  (**Kids**) дээр товшоод идэвхжүүл. Хэрэв та Түргэн Самбараас  (**Kids**)-г олж чадаагүй бол  дээр товшиж, товчийг чирээд нэмнэ үү. Samsung Kids-ийг анх удаа эсвэл төхөөрөмжийг дахин тохируулсны дараа нээж байгаа бол дэлгэц дээрх зааврыг дагаад тохиргоог дуусгана уу.

Samsung Kids-ийн дэлгэц дээр хэрэглэхийг хүссэн хэрэглүүрээ сонго.



Таны урьдчилан тохируулсан дэлгэц түгжих арга буюу урьдчилан тохируулсан PIN код **Эцэг эхийн хяналт** функцийг буюу Samsung Kids-ийг идэвхжүүлж хаахад хэрэглэгдэнэ.

Эцэг эхийн хяналтын функцийг хэрэглэх

Та Samsung Kids-ийн тохиргоог тааруулж, хэрэглээний түүхийг харж болно.

Samsung Kids дэлгэц дээр,  → **Эцэг эхийн хяналт** дээр товшоод түгжээ тайлах кодоо оруул.

Samsung Kids-ийг хаах

Samsung Kids-ийг хаахын тулд Буцах товчийг эсвэл  → **Samsung Kids-г хаах** дээр товшоод түгжээ тайлах кодоо оруулна.

Samsung Health

Танилцуулга


Samsung Health танд эрүүл мэнд, дасгал хөдөлгөөнөө хянахад тусална. Дасгал хөдөлгөөний зорилтоо тодорхойлох, явцыг шалгаж, эрүүл мэнд, дасгал хөдөлгөөнийг бүхэлд нь хянана. Мөн бүртгэсэн алхалтын тоогоо Samsung Health-ийн бусад хэрэглэгчтэй харьцуулж, эрүүл мэндийн зөвлөмж уншиж болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.samsung.com/samsung-health хуудаснаас авна уу.

Samsung Health-г хэрэглэх

Samsung Health хэрэглүүрийг нээ. Энэ хэрэглүүрийг анх удаа эсвэл төхөөрөмжийг дахин тохируулсны дараа нээж байгаа бол дэлгэц дээрх зааврыг дагаад тохиргоог дуусгана уу.

Samsung Health үндсэн дэлгэц дээрх зүйлсийг өөрчлөхдөө, үндсэн картуудын жагсаалтын доорх **Зүйлсийг удирдах** дээр товш.



- Бүс нутгаас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж магадгүй.
- Хэрэв та машин болон гал тэргээр аялахдаа алхамын карт хэрэглэдэг бол, таны алхамын тоогоор чичиргээ мэдрэгдэнэ.

Samsung Members

Samsung Members бол хэрэглэгчдэдээ төхөөрөмжийн доголдлыг оношлох, хэрэглэгчээс асуулт болон алдааны мэдээлэл илгээх боломж олгодог тусламжийн үйлчилгээ юм. Galaxy хэрэглэгчдийн сүлжээгээр бусадтай мэдээллээ хуваалцаж, шинэ мэдээ, зөвлөмж үзэж болно. **Samsung Members** нь төхөөрөмжийг хэрэглэх явцад гарсан аливаа асуудлыг шийдэхэд тусална.

Samsung Global Goals

Бөмбөрцөгийн Зорилгууд, НҮБ-ийн Ерөнхий Ассемблейгаас 2015 онд гаргасан бөгөөд нийгмийг дэмжих үндсэн зорилготой гаргасан. Эдгээр зорилгод ядуурлыг устгах, тэгш бус байдлын эсэргүүцэх, цаг уурын өөрчлөлтийг зогсоох хүч байгаа.

Samsung Global Goals-г хэрэглэн, Бөмбөрцгийн Зорилгын талаар дэлгэрэнгүй мэдэн авч, ирээдүйн төлөө шилжилтэнд нэгдээрэй.

Samsung TV Plus

ТВ ашигладаг шиг сувгаа сонгоод янз бүрийн видео контент үнэгүй үзээрэй.

Samsung TV Plus хэрэглүүрийг нээнэ үү.



Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад энэ хэрэглүүрийг ашиглах боломжгүй байж болзошгүй.

Galaxy Shop

Samsung-ын вэб сайтад хандаж бүтээгдэхүүнтэй холбоотой төрөл бүрийн мэдээллийг харна уу.

Тус **Galaxy Shop** аппликейшныг ачаалла.

Galaxy Wearable

Galaxy Wearable бол зүүдэг төхөөрөмжийг удирдахад зориулсан хэрэглүүр юм. Зүүдэг төхөөрөмжөө холбохдоо зүүсгэлийн тохиргоо, хэрэглүүрийг тохируулан өөрчилж болно.

Galaxy Wearable хэрэглүүрийг нээ.

Эхлүүлэх дээр товшиж төхөөрөмжөө зүүдэг төхөөрөмжтэйгээ холбо. Дэлгэц дээрх зааврыг дагаж тохиргоог дуусга. Зүүсгэлийг хэрхэн төхөөрөмжтэйгөө холбох, хэрэглэх талаар бусад мэдээллийг зүүсгэлийн хэрэглэгчийн гарын авлагаас үзнэ үү.

Хуанли

Төлөвлөгөөндөө болох үйл явдлуудыг оруулж, цагийн хуваарийг зохицуулна.

Үйл явдал үүсгэх

- 1 **Хуанли** ппыг ажиллуулаад  дээр товших эсвэл огноог давхар товшино уу.
Тухайн өдөр үйл явдал, хийх ажил хадгалагдсан бол өдрийг товшоод  дээр товш.
- 2 Үйл явдлын мэдээллийг оруулаад **Хадгалах** дээр товш.

Үйл явдлыг бүртгэлдээ синхрончлох

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд, **Данснууд ба нөөцлөлт** → **Бүртгэлүүд удирдах** дээр товшиж дараа нь синхрончлох бүртгэлээ сонгоно уу.
- 2 **Данс синхрончлох** дээр товшоод **Хуанли** сэлгүүрийг товшоод синхрончилно.

Синхрон хийх бүртгэлүүдийг нэмэхдээ, **Хуанли** аппликейшныг нээгээд  →  → **Цаглабаруудыг удирд** →  дээр товш. Дараа нь синхрончлох бүртгэлээ сонгоод нэвтэрнэ. Бүртгэл нэмэгдсэн бол бүртгэлийн нэрийн дэргэд хөх тойрог харагдана.

Reminder

Хийх ажлын жагсаалтыг сануулга болгон бүртгэж, тохируулсан нөхцөлийнхөө дагуу мэдэгдэл хүлээн авна.



- Илүү нарийвчлалтай мэдэгдэл хүлээн авахын тулд Wi-Fi эсвэл мобайл сүлжээнд холбогд.
- Байршлын сануулгыг ашиглахын тулд GPS функцийг идэвхжүүлсэн байвал зохино. Загвараас хамааран Байршлын сануулгыг ашиглах боломжгүй байж болзошгүй.

Reminder-г асаах

Хуанли хэрэглүүрийг нээгээд → **Reminder** дээр товш. Сануулга дэлгэц гарч ирэх ба Хэрэглүүрийн дэлгэц дээр Сануулга хэрэглүүрийн дүрс () нэмэгдэнэ.

Сануулга үүсгэх

- 1 **Reminder** хэрэглүүрийг нээ.
- 2 дээр товшиж дэлгэрэнгүйг оруулаад **Хадгалах** дээр товш.

Сануулгыг гүйцэтгэх

Сануулгын жагсаалт дээр дээр товшиж, эсвэл сануулгыг сонгоод **Дууслаа** гэж товш.

Сануулгыг сэргээх

Гүйцэтгэсэн сануулгуудыг сэргээнэ.

- 1 Сануулгын жагсаалт дээр → **Гүйцэтгэсэн** дээр товш.
- 2 Сэргээх гэж буй сануулгыг сонгоод **Сэргээх** дээр товш.
Сануулгыг жагсаалт руу нэмэх тул танд дахин сануулна.

Сануулга устгах

Сануулгыг устгахын тулд сануулгыг сонгоод **Устгах** дээр товш. Олон тооны сануулга устгахдаа сануулгыг товшоод удаан дараад, устгах сануулга дээр тэмдэг тавиад **Устгах** дээр товшино.

Миний файлууд

Төхөөрөмж дээр хадгалсан бүх төрлийн файлд хандаж, удирдана.

Миний файлууд хэрэглүүрийг нээ.

Хэрэгцээгүй мэдээлэл байгаа эсэхийг шалгаж, төхөөрөмжийн санах ойг чөлөөлөхийн тулд **Санах ой шинжлэх** дээр товш.

Файл, хавтсыг хайхын тулд  дээр товш.

Цаг

Сэрүүлэг тохируулах, дэлхийн хотуудын цагийг харах, үйл явдлын цагийг хэмжих эсвэл үргэлжлэх хугацаа тохируулна.

Цаг хэрэглүүрийг нээ.

Тооцоологч

Тооны энгийн болон нийлмэл үйлдлийг бодно.

Тооцоологч хэрэглүүрийг нээ.

-  : Тооцооллын түүхийг харна. Түүхийг арилгахын тулд, **Түүх арилгах** дээр товшино уу. Тооцооллын түүхийн самбарыг хаахдаа  дээр товш.
-  : Хөрвүүлэх хэрэгсэл хэрэглэ. Талбай, урт, температур зэрэг төрөл бүрийн утгуудыг өөр нэгжид шилжүүлж болно.
-  : Инженерийн тооны машиныг харуулна.

SmartThings

Ухаалаг цахилгаан хэрэгсэл, Юмсын интернет (IoT) бүхий бүтээгдэхүүнүүдийг ухаалаг утсаар удирдана. Дэлгэрэнгүй мэдээлэл үзэхийн тулд, **SmartThings** аппликейшныг нээж **Цэс** → **Яаж ашиглах** дээр товш.

1 **SmartThings** хэрэглүүрийг нээ.

2 **Төхөөрөмжүүд** → **Төхөөрөмж нэмэх** эсвэл **+** дээр товш.

3 Төхөөрөмжөө сонгоод дэлгэц дээрх зааврыг дагаж холбогдоно уу.



- Холбогдсон төхөөрөмжийн төрөл, хуваалцаж буй агуулгаас хамааран холболтын арга янз бүр байна.
- Бүс нутгаас хамааран холбож болох төхөөрөмж янз бүр байж болно. Холбогдсон төхөөрөмжөөс хамааран ашиглах боломжтой функцүүд янз бүр байж болно.
- Холбогдсон төхөөрөмжийн алдаа, доголдол Samsung баталгаанд хамаарахгүй. Холбогдсон төхөөрөмжид алдаа гарах, доголдол учирвал төхөөрөмжийг үйлдвэрлэгчид хандана уу.

Smart View

Та дэлгэц дээр гаргах функц бүхий TV эсвэл монитор луу төхөөрөмжөө холбоод төхөөрөмжийн харуулж байгаа агуулгыг том дэлгэц дээр гаргаж болно.

1 Мэдэгдлийн самбар дээр доош шудраад  (**Smart View**) дээр товш.

2 Төхөөрөмжийн дэлгэцийг толилуулахдаа төхөөрөмжийг сонгоно уу.



- Ухаалаг дэлгэцээр видео тоглуулахад телевизорын загвараас хамааран нягтрал нь ялгаатай байж болно.

Music Share

Танилцуулга

Дуу хөгжим хуваалцах функцээр төхөөрөмжтэйгөө холбогдсон Bluetooth чанга яригчийг өөр хүнтэй хуваалцах боломжтой. Мөн та өөрийн Galaxy Buds чихэвч болон нөгөө хүний Galaxy Buds чихэвчээр адилхан дуу хөгжим сонсож болно.

Энэ функцийг Дуу хөгжим хуваалцах функцийг идэвхжүүлсэн үед л хэрэглэх боломжтой.

Bluetooth чанга яригч хуваалцах

Та ухаалаг утсан дээрээ болон найзынхаа ухаалаг утсанд буй дуу хөгжмийг Bluetooth чанга яригчаараа сонсож болно.


- 1 Таны ухаалаг утас болон Bluetooth чанга яригч холбогдсон байх ёстой.
Хэрхэн холбогдох талаар [Бусад Bluetooth төхөөрөмжтэй хослох](#) хэсгээс үзнэ үү.
- 2 Ухаалаг утсан дээрээ **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Холболтууд** → **Bluetooth** →  → **Нарийвчилсан** дээр товшоод **Music Share** сэлгүүрийг товшиж идэвхжүүлнэ үү.
Мөн та **Music Share** дээр товшиж төхөөрөмжөө хэнтэй хуваалцах зэрэг нэмэлт функцийг хэрэглэж болно.
- 3 Найзынхаа ухаалаг утсан дээр өөрийн чанга яригчыг Bluetooth төхөөрөмжийн жагсаалтаас сонго.
- 4 Өөрийнхөө ухаалаг утсан дээр холболтын хүсэлтийг зөвшөөрнө.
Таны чанга яригчийг хуваалцана.
Найзынхаа ухаалаг утсаар хөгжим тоглуулбал таны ухаалаг утсаар тоглож буй дуу хөгжмийг түр зогсооно.

Galaxy Buds-аар дуу хөгжим хамт сонсох

Та өөрийн ухаалаг утсан дээр буй дуу хөгжмийг өөрийн болон найзынхаа утасгүй чихэвчээр зэрэг сонсож болно.

Энэ функцийг зөвхөн Galaxy Buds бүтээгдэхүүнд хэрэглэнэ.

- 1 Ухаалаг утас болон утасгүй чихэвч бүр холбогдсон байх ёстой.
Хэрхэн холбогдох талаар [Бусад Bluetooth төхөөрөмжтэй хослох](#) хэсгээс үзнэ үү.
- 2 Найзынхаа ухаалаг утсан дээр **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Холболтууд** → **Bluetooth** → **Нарийвчилсан** дээр товшоод **Music Share** сэлгүүрийг товшиж идэвхжүүлнэ үү.
Мөн та **Music Share** дээр товшиж төхөөрөмжөө хэнтэй хуваалцах зэрэг нэмэлт функцийг хэрэглэж болно.
- 3 Ухаалаг утсан дээрээ, мэдэгдлийн самбарыг нээгээд **Медиа гаралт** дээр товш.
- 4 **Music Share** дээр товшиж, илэрсэн төхөөрөмжийн жагсаалтаас найзынхаа утасгүй чихэвчийг сонго.
- 5 Найзынхаа ухаалаг утсан дээр холболтын хүсэлтийг зөвшөөрнө.
Өөрийн ухаалаг утсаар дуу хөгжим тоглуулбал та хоёр утасгүй чихэвчээр хамт сонсож болно.



Windows-н холбоос

Төхөөрөмжийг Windows компьютерт холбоод зураг, зурвас зэрэг төхөөрөмжийн мэдээлэлд компьютероос хандаж болно.

Дуудлага, зурвас ирэхэд тэдгээрийг компьютерт хүлээн авч болно.



- Энэ онцлогийг бүрэн ашиглахын тулд Windows-н хамгийн сүүлийн хувилбар болон **Таны утас** аппликэйшнийг ашиглахыг зөвлөж байна.
- Энэ функцийг хэрэглэхийн тулд Microsoft-н хэрэглэгчийн бүртгэл шаардлагатай. Microsoft-н хэрэглэгчийн бүртгэл үүсгэсэн бол та Microsoft Office, Windows 10 гэх мэт бүхий л Microsoft төхөөрөмж, үйлчилгээнд нэвтрэх боломжтой.

Компьютертой холбох

1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **Windows-н холбоос** дээр товш.


2 Дэлгэц дээрх зааврыг дагаж холболтыг гүйцэтгэнэ үү.



Нэмэлт мэдээллийг <https://aka.ms/setupltw> хуудаснаас харна уу.

Төхөөрөмжийн мэдээлэл, мэдэгдлийг компьютерт харах

Компьютер дээрээ **Таны утас** хэрэглүүрийг нээгээд хүссэн ангиллаа сонго.



Боломжит функцүүд ба цэс нь программ хангамжийн хувилбараас хамааран янз бүр байж болно.

Google-ийн хэрэглүүрүүд

Google энтертэйнмент, нийтийн сүлжээ, бизнесийн хэрэглүүрээр хангана. Зарим хэрэглүүрийг хэрэглэхэд танд Google бүртгэл шаардлагатай байж магадгүй.

Хэрэглүүрийн мэдээллийг харахын тулд хэрэглүүр тус бүрийн тусламжийн цэсийг үзнэ үү.

- **Chrome:** Мэдээлэл хайж, вэб хуудас үзнэ.
- **Gmail:** Google шуудан үйлчилгээгээр цахим шуудан илгээж, хүлээн авна.
- **Газ. зураг:** Өөрийн байршлыг газрын зураг дээр олж, дэлхийн газрын зургаас газар хайж, өөрийн эргэн тойрны газруудын байршлын мэдээллийг харна.
- **YT Music:** YouTube Music-ээр цацаж буй төрөл бүрийн дуу хөгжим, видео бичлэгийг үзнэ. Мөн та өөрийн төхөөрөмж дээрх дуу хөгжмийн цуглуулгыг харж, тоглуулж болно.
- **Google Play Movies: Play Store**-оос кино, TV нэвтрүүлэг зэрэг видео агуулга худалдан авч, түрээсэлж үзнэ.
- **Драйв:** Агуулгыг үүлэнд хадгалж, хүссэн газраасаа хандаж, бусадтай хуваалцана.
- **YouTube:** Видео бичлэг үзэж, бүтээж, бусадтай хуваалцана.
- **Зураг:** Олон эх үүсвэрээс нэг дор таны бүх гэрэл зургийг хайж, удирдаж, засна.
- **Google:** Интернет эсвэл таны төхөөрөмжөөс ямар нэг зүйлийг хурдан хайж олно.
- **Duo:** Энгийн видео дуудлага хийнэ.
- **Мессеж:** Таны төхөөрөмж эсвэл компьютер дээр зурвас илгээж, хүлээн авах ба зураг видео зэрэг төрөл бүрийн контент хуваалцана.



Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад зарим хэрэглүүрийг ашиглах боломжгүй байж болзошгүй.

S Pen

Агаарын үйлдлүүд

Төхөөрөмжтэй Bluetooth Low Energy (BLE) холболтоор холбогдсон S Pen үзгээр хэрэглүүрүүдийг алсаас удирдана.

Жишээлбэл, S Pen товчийг удаан дараад камер зэрэг хэрэглүүрийг хялбархан нээж болно. Мөн камерын хэрэглүүрийг хэрэглэн уг товчийг нэг дараад зураг авна. Хөгжим тоглуулж байх үедээ S Pen товчийг удаан дарангаа S Pen үзгээ дээш өргөвөл дууны түвшинг чангалж, доошлуулбал дууны түвшинг намсгана.



- Air үйлдэл функцийг хэрэглэхийн өмнө S Pen -ийг цэнэглэх ёстой. Дэлгэрэнгүй мэдээллийг [S Pen үзгийг цэнэглэх](#)-ээс авна уу.
- S Pen үзгийг үүрнээс нь гаргавал төлөвийн мөрөн дээр  дүрс харагдана. Хэрэв S Pen үзгийн цэнэг дууссан, төхөөрөмжөөс хол байгаа, эсхүл S Pen үзэг болон төхөөрөмжийн хооронд юм халхалсан юм уу хөндлөнгийн нөлөө учирч байгаа бол S Pen төхөөрөмжөөс салах ба уг дүрс () сааралтана. Air үйлдэл функцийг дахин хэрэглэхийн тулд, S Pen -ээ төхөөрөмжийнхөө нүхэнд S Pen -ийг дахин хийнэ үү.

S Pen үзгээр зураг авах

Тө төхөөрөмжөө тодорхой зайд байршуулаад, цаг хэмжигч хэрэглэхгүйгээр S Pen товчийг дараад хялбархан зураг авч болно.

- 1 **Тохиргоо** аппликейшнийг ажилуулж, **Дэвшилтэт функц** → **S Pen** → **Агаарын үйлдлүүд** дээр товшиж, дараа нь сэлгүүрийг товшиж функцийг идэвхжүүлнэ.
- 2 **Камер** хэрэглүүрийг нээнэ.
- 3 S Pen товчийг нэг дараад зураг авна.
 - Цуврал зурагнууд авахын тулд S Pen товчийг удаан дарна.
 - Зураг авах горимыг өөрчлөхдөө S Pen товчийг удаан дарангаа S Pen үзгийг зүүн, баруун тийш хөдөлгөнө.
 - Камерыг солихын тулд S Pen товчийг хоёр удаа дарна.

Хэрэглүүр эсвэл функцийг солих

S Pen үзгээр хэрэглэх гэж буй хэрэглүүрийг солино. **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **S Pen** → **Агаарын үйлдлүүд** дээр товш.

S Pen үзгийг шинээр тохируулах

Хэрэв S Pen үзгэнд холболтын асуудал гарсан эсвэл S Pen үзгийн холболт байн байн салж байвал S Pen үзгийг шинээр тохируулаад дахин холбоно уу.

Үүр лүү S Pen үзгийг хий. Дараа нь, Air үйлдэл тохиргооны дэлгэцийг нээж  → **S Pen-г дахин тохируулах** дээр товч.



- Та зөвхөн Samsung-аас баталгаажсан Bluetooth Low Energy (BLE) холболттой S Pens үзэг ашиглаж болно.
- Төхөөрөмжтэй S Pen үзэгтэй холбогдож дуусаагүй байхад салгаж болохгүй. Ингэснээр холболт тасалдана.

Агаарын тушаал


Агаарын тушаал нь S Pen функцийг харуулах цэс бөгөөд байнга хэрэглэдэг хэрэглүүрүүд рүү хурдан хандах боломжийг олгодог.

Хийн командын самбарыг нээхийн тулд S Pen үзгийг үүрнээс салгаад эсвэл S Pen үзгийг дэлгэц рүү зааж байгаад S Pen товчийг дарна. Хийн командын дүрсийг () S Pen үзгээр товшиж болно.

Агаарын командын самбар дээр дээш доош шудраад хэрэгтэй функц юм уу хэрэглүүрээ сонгоно.



Дэлгэц унтарсан эсвэл дэлгэц түгжих аргаар түгжсэн бол S Pen үзгийг салгахад Агаарын командын самбар нээгдэхгүй.



- **Тэмдэглэл үүсгэх:** Попап цонхон дээр хялбархан тэмдэглэл бичнэ. Мөн S Pen товчийг дарж байгаад дэлгэцийг давхар товшиж энэ функцийг нээж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг [Samsung Notes](#)-ээс авна уу.
- **Бүх тэмдэглэлийг харах:** **Samsung Notes** хэрэглүүр дээрх бүх тэмдэглэлийг харна.
- **Ухаалаг сонголт:** S Pen үзгийг хэрэглэн талбай сонгох, хуваалцах, хадгалах гэх мэт үйлдэл хийнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Ухаалаг сонголт](#)-ээс авна уу.
- **Дэлгэцэнд бичих:** Дэлгэцийн зургийг авч дээр нь бичих, зурах, авсан зургийг тайрна. Үргэлжилсэн хуудас, тухайлбал вэб хуудас зэргийн дэлгэцэд ил харагдаж байгаа болон далд байгаа агуулгын зургийг авна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Дэлгэцэнд бичих](#)-ээс авна уу.
- **Live зурвасууд:** Бичвэр зурвасын оронд хөдөлгөөнт зурвасыг гараар бичиж, зурах замаар хөдөлгөөнт файл болгон өвөрмөц зурвас илгээнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Live зурвасууд](#)-ээс авна уу.
- **AR Doodle:** Виртуал орчинд нүүр царай гэх мэт төрөл бүрийн газарт гараар бичих, зурах үйлдлийг хөгжилтэй бичлэг болгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг [AR Doodle](#)-ээс авна уу.
- **Орчуулах:** S Pen үзгээр орчуулах үгийг заана. Дэлгэрэнгүй мэдээллийг [Орчуулах](#)-ээс авна уу.
- **PENUP:** Өөрийн бүтээлийг нийтэлж, бусдын бүтээлийг харж, хэрэгцээтэй зөвлөмжийг авна.
- **Bixby Vision:** Bixby хараа функцийг тусламжтай төстэй зураг хайх, бичвэрийг таньж орчуулах зэрэг үйлдэл хийнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Bixby Vision](#)-ээс авна уу.
- **Томруулах:** S Pen үзгээр томруулах хэсгийн дээгүүр заана.
- **Гүйлгэж харах:** Хэрэглүүрийг өнгөц зураг болгон багасгаж S Pen үзгээр тэдгээр өнгөц зургуудыг заавал хэрэглүүрийг бүтэн дэлгэц дээр нээнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Гүйлгэж харах](#)-ээс авна уу.
- **Будах:** PENUP-аас нийлүүлж буй зурганд S Pen үзгээр өнгө нэмнэ.
- **Хуанли дээр бичих:** **Хуанли** хэрэглүүрийг нээгээд дэлгэц дээр нь бичих юм уу зурна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Хуанли дээр бичих](#)-ээс авна уу.
- **+** : Агаарын командын самбарт тогтмол ашигладаг хэрэглүүрүүдийн холбоосыг нэмнэ.

Агаарын командын дүрс

Агаарын командын самбар хаагдахад Агаарын командын дүрс дэлгэц дээр үлдэнэ. S Pen үзгээр уг дүрсийг товшиж хийн командын самбарыг нээж болно.

Дүрсийг зөөхийн тулд -г шинэ байрлал руу чирнэ.

Дүрсийг арилгахын тулд -г дэлгэцийн дээд талд байх **Арилгах** хэсэг рүү чирнэ.


Хэрэв Агаарын командын дүрс дэлгэц дээр гарч ирэхгүй байвал **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **S Pen** дээр товшоод **Агаарын тушаалын дүрсийг харуул** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.

Air үйлдэл функцийг дэмждэг аппликейшнүүдийг хэрэглэж байхдаа, Air команд айконы дээгүүр S Pen гүйлгэж аппликейшн болгоны хэрэглэж болох үйлдлийг харж болно.

Ухаалаг сонголт

S Pen үзгийг хэрэглэн талбай сонгох, хуваалцах, хадгалах гэх мэт үйлдэл хийнэ. Мөн видео бичлэгээс зарим хэсгийг сонгож GIF хөдөлгөөнт дүрстэй зураг болгон авч болно.

- 1 Зургаас тодорхой хэсгийг салгаж авах гэх мэт таны хүссэн контент байвал Агаарын командын самбарыг нээгээд **Ухаалаг сонголт** дээр товш.
- 2 Хэрэгслийн мөр дээрх дүрсээс нэгийг сонгоод S Pen үзгээр сонгохыг хүссэн контентын дээгүүр чирнэ.




- 3 Сонгосон хэсэгт хэрэглэх үйлдлийг сонго.
 - **Бэхлэх/Оруулах:** Сонгосон хэсгийг дэлгэц дээр байрлуулна.
 -  : Сонгосон хэсгийн харагдах байдлыг автоматаар өөрчилнө.
 -  : Сонгосон хэсэг дээр бичиж, зурна.
 -  : Сонгосон хэсгээс бичвэрийг ялгана.
 -  : Сонгосон хэсгийг бусадтай хуваалцана.
 -  : Сонгосон хэсгийг **Галерей** хадгална.

Видео бичлэгээс зураг авах

Видео тоглуулах явцад тодорхой хэсгийг сонгоод GIF хөдөлгөөнт дүрсийн зураг авна.

- 1 Тоглуулж буй видеоноос тодорхой хэсгийн зургийг авах гэх мэт таны хүссэн контент байвал Агаарын командын самбарыг нээгээд **Ухаалаг сонголт** дээр товш.
- 2 Хэрэгслийн мөр дээр **[GIF]** дээр товш.
- 3 Зураг авах хэсгийн байрлал, хэмжээг тааруул.

Байрлалыг тааруулна.



Хүрээний буланг чирж хэмжээг тааруулна.

- 4 Зураг авч эхлэхдээ **Бичлэг** дээр товш.



- Видеоноос зураг авахын өмнө видео бичлэгийг тоглуулж буй эсэхийг шалгана уу.
- Видеоноос зураг авч болох дээд хугацааг дэлгэц дээр харуулна.
- Видеоноос тодорхой хэсгийг зургийг авахад дуу бичигдэхгүй.

- 5 **Зогсоох** дээр товшоод зураг авахыг зогсооно.

- 6 Сонгосон хэсэгт хэрэглэх үйлдлийг сонго.

-  : Сонгосон хэсэг дээр бичиж, зурна.  дээр товшоод файлыг хадгалахын өмнө үр дүнг харна.
-  : Сонгосон хэсгийг бусадтай хуваалцана.
-  : Сонгосон хэсгийг **Галерей** хадгална.

Дэлгэцэнд бичих

Дэлгэцийн зургийг авч дээр нь бичих, зурах, авсан зургийг тайрна.

- 1 Контентын зургийг авахдаа Агаарын командын самбарыг нээгээд **Дэлгэцэнд бичих** дээр товш.
Тухайн дэлгэцийн зургийг автоматаар авах ба засварлах хэрэгслийн мөр гарч ирнэ.
- 2 Дэлгэцийн зурган дээр бичиж, зурна.



- 3 Дэлгэцийн зургийг хадгалах юм уу хуваалцана.
Дэлгэцээс авсан зургуудыг **Галерей** харж болно.




Зарим хэрэглүүрийг хэрэглэж байхад дэлгэцийн зураг авах боломжгүй.

Live зурвасууд

Бичвэр зурвасын оронд гараар бичиж зурж байгаа үйлдлээ бичиж, үүнийгээ хөдөлгөөнт файл болгон хадгалан, цор ганц зурвас үүсгэн илгээ.

- 1 Та хөдөлгөөнтэй зурвас илгээхийг хүсвэл Хийн командын самбарыг нээгээд **Live зурвасууд** дээр товш.
- 2 Дэвсгэр зургийг тохируулан өөрчлөөд **Дууслаа** эсвэл **Зурж эхлэх** дээр товш.
- 3 Амьд зурвасын дэлгэц дээр бичих юм уу зур.




- 4 **Дууслаа** дээр товш.
Амьд зурвасыг **Галерей** дотор хөдөлгөөнт GIF файл эсвэл видео болгон хадгална.
- 5 **Хуваалцах** дээр товшоод аргыг сонго.

Орчуулах

Орчуулахыг хүссэн бичвэр дээгүүр S Pen үзгээр заа. Бичвэрт агуулагдаж байгаа нэгжийг ч мөн хөрвүүлнэ.

- 1 Таны орчуулахыг хүссэн бичвэр гарч ирвэл Агаарын командын самбарыг нээгээд **Орчуулах** дээр товш.
- 2 Дэлгэцийн дээд талд буй Орчуулагчийн самбарын дээрх хэлээс сонго.
T эсвэл **≡** дээр товшоод үг сонгох, өгүүлбэр сонгох эсэхийг тааруулж болно.
- 3 Орчуулах бичвэр эсвэл хөрвүүлэх нэгжийн дээгүүр S Pen үзгээр заа.
Орчуулсан бичвэр харагдана. Эх бичвэрийн дуудлагыг сонсохыг хүсвэл **🔊** дээр товш. Таны сонгосон хэлээс хамаараад **🔊** дүрс гарч ирж болно.




- Энэ функц зарим хэлээр ажиллахгүй байж болзошгүй.
- Дэлгэц дээр зөвхөн таних боломжтой хэл байгаа үед л энэ функцийг ашиглах боломжтой.

Bixby Vision

Контентын дээгүүр S Pen үзгээр заавал контентыг таних ба хайх дүрс гарч ирнэ. Энэ функцийг тусламжтай төстэй зураг хайх, бичвэрийг таньж орчуулах зэрэг үйлдэл хийнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Bixby Хараа](#)-ээс авна уу.

- 1 Таны дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүссэн эсвэл бичвэр ялгаж танихыг хүссэн зурган дээрээ Агаарын командын самбарыг нээгээд **Bixby Vision** дээр товш.
- 2 Хүссэн контентын дээгүүр S Pen үзгээр заа. Боломжит сонголтууд дэлгэц дээр гарч ирвэл аль нэгийг сонго.




Гүйлгэж харах

Хэрэглүүрийг өнгөц зураг болгон багасгаж S Pen үзгээр тэдгээр өнгөц зургуудыг заавал хэрэглүүрийг бүтэн дэлгэц дээр нээнэ.

Жишээ нь газрын зургийн хэрэглүүрийг нээгээд, Агаарын командын самбарыг нээгээд **Гүйлгэж харах** дээр товш. Хэрэглүүрийг хумсын чинээ өнгөц зураг болгон дэлгэцийн доод талд байрлуулна. Вэб хуудас үзэнгээ өнгөц зурган дээгүүр S Pen үзгээр зааж газрын зургийг бүтэн дэлгэцээр харж газар, байршлыг хайна.

S Pen үзгийг дэлгэцээс холдуулбал дэлгэцийг дахин өнгөц зургийн хэмжээнд багасгана.


Багасгаж эвхсэн хэрэглүүрийг хаахдаа өнгөц зургийг товшоод удаан дарж, дэлгэцийн дээд талд буй **Арилгах** руу чир.



Хуанли дээр бичих


Төлөвлөгөөгөө цаглаврын дэлгэц дээр хялбархан, хурдан бичнэ.

Агаарын командын самбарыг нээгээд **Хуанли дээр бичих** дээр товшоод Хуанли дээр төлөвлөгөөгөө бичнэ. Дууссан бол **Хадгалах** дээр товш. Засахын тулд  дээр товш.



Агаарын харагдац


Дэлгэц дээрх зүйлсийг S Pen үзгээр заагаад агуулгыг харах юм уу мэдээллийг нь попап цонхонд харна. Зарим хэрэглүүрт Үйлдлийг товчийг урьдчилан харах цонхонд харуулна.



Хэрэв энэ функц идэвхжээгүй байвал **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **S Pen** дээр товшиж, **Агаарын харагдац** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.

Үзэг сонгох

S Pen товчийг удаан дарангаа S Pen үзгээр сонгох гэж буй бичвэрийн дээгүүр чирнэ. Мөн та сонгосон зүйлсийг юм уу бичвэсийг өөр хэрэглүүр лүү хуулж эсвэл бусадтай хуваалцаж болно.




Дэл. унтр санамж

Мөн та дэлгэцийг асаахгүйгээр санамж бичиж болно.

Дэлгэц унтраалттай үед, S Pen үзгийг гарган авч эсвэл S Pen үзгээ дэлгэцэн дээр гүйлгэж S Pen товчийг дар.

Санамж бичсэнийхээ дараа **Хадгалах** товчийг дарах юм уу S Pen үзгийг үүр лүү нь хийвэл санамжийг **Samsung Notes** дотор хадгална.




Хэрэв энэ функц идэвхжээгүй байвал **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **S Pen** дээр товшиж, **Дэл. унтр санамж** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.

Always On Display дээр санамжийг байрлуулах

Дэлгэц асаахгүй бичих тэмдэглэлийг Always On Display дээр байрлуулахын тулд  → **Always On Display-д бэхлэ** дээр товш. Байрлуулсан тэмдэглэлийг хадгалахгүй.

Байрлуулсан санамжийг засварлахын тулд тухайн санамжийг давхар товш. Хэрэв Always On Display дээр байрлуулсан санамжийг дахин засахыг хүсвэл анхны санамжийг **Samsung Notes** хадгална.

Байрлуулсан санамжийг эвхэхийн тулд  дээр давхар товш. Санамжийг Always On Display дэлгэц дээр  байдлаар харуулна. Байрлуулсан санамжийг дахин харахын тулд  дээр давхар товш.



Хэрэв санамжийг бичиж эхэлснээс хойш та тодорхой хугацаанд ямар нэг үйлдэл хийгээгүй бол санамжийг автоматаар эвхэнэ.

S Pen үзгээр түгжээг тайлах

Хэрэв S Pen үзэг холбогдсон үед дэлгэцийг түгжсэн бол S Pen товчийг дараад нээж болно.

1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **S Pen** → **S Pen түгжээ тайлах** дээр товш.

2 **S Pen түгжээ тайлахыг ашиглах** → **ОК** дээр товш.

Одоо та S Pen товчийг дараад дэлгэцийн түгжээ тайлж болно.



- **S Pen түгжээ тайлахыг ашиглах** функцийг зөвхөн дэлгэц түгжих аргыг тохируулсан тохиолдолд л хэрэглэж болно.
- Энэ функцийг ашиглахын тулд S Pen үзэг таны төхөөрөмжтэй холбогдсон байх ёстой.

Samsung Notes


Танилцуулга

Товчлуурт гараар эсвэл гар бичмэлээр бичих, дэлгэц дээр зурах зэрэг тэмдэглэл үүсгэнэ. Тэмдэглэлд зураг, дуу бичлэг оруулж болно.

Тэмдэглэл үүсгэх

1 **Samsung Notes** хэрэглүүрийг нээгээд  дээр товшиж, тэмдэглэл бичнэ.

 эсвэл  дээр товшоод оролтын аргыг өөрчилж болно.



2 Тэмдэглэл бичиж дууссан бол Буцах товчийг товшоод хадгална.

Хэрэв өөр форматаар хадгалах бол  → **Файлр хдгл** дээр товш.


Тэмдэглэл устгах

Тэмдэглэл дээр товшоод удаан дарж, **Устгах** дээр товш.

Гараар тэмдэглэл бичих

Бичих дэлгэц дээр  дээр товшоод S Pen үзгээр бичих юм уу зур.

Хоёр хуруугаар салгах хөдөлгөөн хийж дэлгэцийг томруулбал гараар бичихэд улам хялбар байх болно.



Баллуур хэрэглэх

Тэмдэглэлээс гар бичмэлийг арилгахыг хүсвэл  дээр товшоод баллах хэсгийг сонгоно. Эсвэл S Pen товчийг удаан дарж байгаад баллах хэсгийг сонгоно.

Баллуурын төрлийг сонгохдоо  дээр дахин нэг удаа товш.

- **Мөр арилгагч:** Сонгосон зураасыг арилгана.
- **Талбай арилгагч:** Зөвхөн таны сонгосон талбайг арилгана. Та тохируулгын хөндлийг чирээд баллуурын хэмжээг тааруулж болно.




Жижиг хэмжээтэй баллуур байсан ч та хүссэн хэсгээ нарийвчлан арилгаж чадахгүй байж болно.

Гар бичмэл тэмдэглэлийг засах

Гар бичмэл тэмдэглэлийг тайрах, зөөх, хэмжээг нь өөрчлөх зэргээр засах боломжтой.

- 1 Тэмдэглэл дээр гар бичмэл байгаа бол  дээр товш.
Сонголтын хэмжээг өөрчлөхийн тулд  дээр дахин нэг товш.
- 2 Оролтыг сонгохын тулд товших юм уу тойруулан зураас зурна.
 - Оролтыг өөр газарт зөөж байрлуулахын тулд оролтыг сонгосны дараа шинэ байрлал руу чирнэ.
 - Сонголтын хэмжээг өөрчлөхийн тулд оролтыг товшоод гарч ирэх хүрээний булангаас чирнэ.



- 3 Оролтыг боломжит сонголтуудаар засна.

Контентыг хэвтээгээр жигдлэх

Та гар бичмэл, зургуудаа хэвтээгээр жигдрүүлж болно.

Дэлгэц дээр зурах юм уу бичсэний дараа  дээр товш.

Хэв маягийг өөрчлөх

Та гар бичмэл, зургийнхаа хэв маягийг өөрчилж болно.

Дэлгэц дээр бичих юм уу зурсны дараа **A** дээр хоёр удаа товшоод өнгө, зураасны өргөнийг сонго. Дараа нь S Pen ашиглан хэв маягийг өөрчлөхийг хүссэн газраа товш.



Гар бичмэлийг бичвэр болгон хөрвүүлэх


Дэлгэц дээр зурах юм уу бичсэний дараа **IT** дээр товш. Урьдчилан харах цонхонд сонголтууд харагдана. **^** эсвэл **v**-г чирвэл хүссэн гар бичмэлээ сонгож болно. Гар бичмэлийг солихын тулд **Хөрвүүлэх** дээр товш.



Энгийн бичгийн хавтан хэрэглэх

Энгийн бичгийн хавтан хэрэглэвэл гараар бичихэд улам хялбар байна.

Тэмдэглэл бичих дэлгэц дээрх **a↑** дээр товш. Оролтын талбарыг томруулах ба энгийн бичвэрийн хавтан болж харагдана.



Дүрснүүдийг автоматаар засах

 дээр товшоод дүрс зурна. Дүрсийг засна.

Тэмдэглэлд дуу хурааж авах

Тэмдэглэл бичиж байхдаа дуу хурааж, контентыг бичлэгтэй тааруулна.

Тэмдэглэл бичих дэлгэц дээр  → **Дуу хоолойн бичлэг** дээр товшоод тэмдэглэл үүсгэнэ.

Жагсаалтаас тэмдэглэлээ сонгоод  дээр товшиж бичлэгийг тоглуулна. Дараа нь бичлэгийн үеэр таны үүсгэсэн контентыг бичлэгийн хамт дэлгэц дээр харуулна.

PDF файл руу санамж нэмэх

Samsung Notes хэрэглүүрийг нээгээд  дээр товшиж, дараа нь PDF файлыг сонгоно. PDF файлд санамж нэмж болно.

Үндсэн дэлгэц дээр тэмдэглэл байрлуулах

Үндсэн дэлгэц дээр тэмдэглэл байрлуулж, хурдан харах, засах боломжтой.

- 1 **Samsung Notes** хэрэглүүрийг нээ.
- 2 Тэмдэглэлийг сонгоод  → **Энд нэмэх** → **Эх дэлгэц** дээр товш.
Тэмдэглэлийг Үндсэн дэлгэц дээр нэмнэ.

PENUP

PENUP бол S Pen үзгээр зурсан бүтээлээ хуваалцдаг олон нийтийн сүлжээ юм. Өөрийн бүтээлийг нийтэлж, бусдын бүтээлийг харж, хэрэгцээтэй зөвлөмжийг авна.

PENUP хэрэглүүрийг нээ.


Галерей

Танилцуулга

Төхөөрөмжид хадгалсан зураг, видеог харна. Та мөн зураг, видео бичлэгүүдийг цомгоор харах юм уу дурсамж бүтээж болно.

Зургийн цомог хэрэглэх

Галерей хэрэглүүрийг нээнэ.




Төстэй зургуудыг бүлэглэх

Галерей хэрэглүүрийг нээгээд  дээр товшиж төстэй зургуудыг бүлэглэж, хамгийн сайныг нь зургуудын харагдах байдал болгон харуулна. Зургийн харагдах байдлыг товшвол тухайн бүлэг дэх бусад зургийг харж болно.


Зураг үзэх

Галерей хэрэглүүрийг сонгоод зургаа сонго. Бусад файлыг харахын тулд дэлгэц дээр зүүн эсвэл баруун тийш шударна.



Томруулсан зургийг тайрах


- 1 **Галерей** хэрэглүүрийг сонгоод зургаа сонго.
- 2 Хадгалахыг хүссэн хэсэг дээр хоёр хуруугаар дэлгэх үйлдэл хийгээд  дээр товш. Тайрсан хэсгийг файл болгон хадгална.



Видео бичлэг үзэх

Галерей аппликейшныг ачааллаад тоглуулах видеоогоо сонго. Бусад файлыг харахын тулд дэлгэц дээр зүүн эсвэл баруун тийш шударна.

Тоглуулах явцад илүү олон сонголтыг ашиглахын тулд  → **Видео тоглуулагч дэр нээх** дээр товш.



Тоглуулах дэлгэцийн зүүн талыг хуруугаар дээш, доош чирээд цайралтыг тааруулна, эсвэл тоглуулах дэлгэцийн баруун талыг хуруугаар дээш, доош чирээд дууны түвшнийг тааруулна.

Ухраах, урагшлахын тулд тоглуулах дэлгэц дээр зүүн эсвэл баруун тийш шударна.

Видео дүрсийг гэгээлэг, тодоор харах

Видео бичлэгийн дүрсийн чанарыг сайжруулаад илүү гэгээтэй, тод өнгөтэй болгож болно. **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **Видеоны цайралт** → **Тод** дээр товш.



- Энэ функцийг зөвхөн зарим хэрэглүүрт хэрэглэж болно.
- Энэ функцийг хэрэглэвэл батарейн зарцуулалт нэмэгдэнэ.

Цомог

Цомог үүсгэж, зураг, видеонуудаа цэгцэлнэ.

- 1 **Галерей** хэрэглүүрийг нээгээд **Цомог** →  → **Цомог үүсгэх** дээр товшиж цомог үүсгэнэ.
- 2 Цомгоо сонгоод **Зүйлс нэмэх** дээр товшоод хүссэн зураг, видео хуулах юм уу зөөж болно.

Үйл явдал

Зураг авах, бичлэг хийх, зураг, видео хадгалах үед төхөөрөмж огноо, байршлын шошгыг уншиж, зураг болон видеог эрэмбэлээд дурсамж бүтээдэг.

Галерей хэрэглүүрийг нээгээд **Үйл явдал** дээр товшиж, түүхийг сонгоно уу.

Зураг эсвэл видеог нэмж, устгахын тулд, тухайн нэг түүхээ сонгоод  → **Нэмэх** эсвэл **Засварлах** дээр товш.

Зураг, видео бичлэгийг синхрончлох

Галерей хэрэглүүрийг нээгээд  → **Тохиргоо** → **Үүлэн синк** дээр товшоод дэлгэц дээрх зааврыг дагаж синхрончилно уу. **Галерей** хэрэглүүр ба үүлийг синхрончилно.

Галерей хэрэглүүрийг үүлэнд синхрончилбол таны авсан зураг, видео бичлэгийг ч мөн үүлэнд хадгална. Та **Галерей** хэрэглүүрээс болон бусад төхөөрөмжөөс үүлэнд хадгалсан зураг, видео бичлэгээ үзэх боломжтой.



Samsung бүртгэл ба Microsoft-н хэрэглэгчийн бүртгэлээр холбогдож байгаа бол Microsoft OneDrive-ийг үүлэн санах ой болгон тохируулж болно.

Зураг, видео бичлэг устгах

Галерей хэрэглүүрийг нээгээд устгах гэж буй зураг, видео, дурсамжийн аль нэг дээр товшиж удаан дараад **Устгах** дээр товш.

Дахивар функцийг хэрэглэх

Та устгасан зургууд болон видео бичлэгийг дахиврын саванд хадгалж болно. Тодорхой хугацааны дараа файлуудыг устгана.

Галерей хэрэглүүрийг нээгээд  → **Тохиргоо** дээр товшиж, **Хогийн сав** сэлгүүрийг товшоод үүнийг идэвхжүүлнэ.

Дахивар файлуудыг харахдаа **Галерей** хэрэглүүрийг нээгээд  → **Хогийн сав** дээр товш.

AR бүс

Танилцуулга

AR бүс нь AR онцлогуудыг агуулна. Функцийг сонгоод хөгжилтэй зураг авч, видео бичлэг хий.

AR бүсийг нээх

Дараах аргуудаар AR бүсийг нээнэ:

- **AR бүс** хэрэглүүрийг нээ.
- **Камер** хэрэглүүрийг нээгээд **БУСАД** → **AR БҮС** дээр товш.



Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж болзошгүй.


AR Эможи студ

Янз бүрийн онцлогуудад хэрэглэх хөгжилтэй эможинуудаа хүссэн аргаараа үүсгээрэй.

AR Эможи үүсгэх

- 1 **AR бүс** хэрэглүүрийг нээгээд **AR Эможи студ** дээр товш.
- 2 Хурдан эхлэхийн тулд та урьдчилан-хийсэн эможийг сонгож болно. Зүүн эсвэл баруун тийш шударч, эможийгоо сонгоод,  дээр товш.
Хэрэв та өөрийн гэсэн эможи хийх бол, сельфи хийнэ эсвэл зураг сонгоно.

3 Дэлгэц дээрх зааврыг дагаж эможи үүсгэнэ.



AR эможийг хэрэглээнд сонгох

AR бүс аппликейшныг ачаалж, **AR Эможи студ** → дээр товшоод, хүссэн эможийгоо сонго.

AR эможийг устгах

AR бүс аппликейшныг ачаалж **AR Эможи студ** → → товш, устгах эможийг сонгоод **Устгах** дээр товш.

AR эможигийн богино видео үүсгэх ба төхөөрөмжөө үүгээр чимэглэх


Та аль нэг эможигор богинохон видео үүсгэж дэлгэцийн арын зураг, дуудлагын фон зураг болгон хэрэглэж болно.

- 1 **AR бүс** хэрэглүүрийг нээгээд **AR Эможи студ** дээр товш.
- 2 **Видео үүсгэх**-ийг сонго, **Дудлг дэлгц**, эсвэл **Түгжх дэлгц**.
- 3 Хүссэн бэлдэцээ сонго.
Дэлгэцийн фон зургаа сонгохын тулд, дээр товш.
- 4 Видеог хадгалахын тулд **Хадгалах** дээр товш.
Хадгалагдсан видеонуудыг та **Галерей**-гаас үзэж болно.
- 5 Видеог шууд хэрэглэхийн тулд, дэлгэцийн доод хэсгээс сонголтыг хийнэ үү.

AR эможигоор харилцагчийн профайл үүсгэх

Харилцагчид аппликейшныхаа Samsung бүртгэлийн профайлд эможи хэрэглээрэй. Та янз бүрийн позыг болон өөрийн илэрхийлэмжээс сонгож болно.


- 1 **AR бүс** хэрэглүүрийг нээгээд **AR Эможи студ** дээр товш.
- 2 **Профиль** дээр товшоод эможийгоо сонгоорой.
- 3  дээр товшиж хүсч буй илэрхийлэмжээ эсвэл позоо сонго.
- 4 **Боллоо** → **Хадгалах** дээр товш.



AR Эмож камр

Төрөл бүрийн зураг авах горимд эможи дүр бүхий хөгжилтэй зураг авч, видео бичлэг хийнэ.

- 1 **AR бүс** хэрэглүүрийг нээгээд **AR Эмож камр** дээр товш.
- 2 Хэрэглэхийг хүссэн эможи ба горимоо сонго. Боломжит горимууд нь сонгосон эможигоос хамааран янз бүр байж болно.
 - **ҮЗЭГДЭЛ:** Эможи таны нүүрний хувирлыг даган дуурайна. Та мөн дэвсгэр зургийг өөрчилж болно.
 - **БАГ:** Эможиний нүүр царай нь маск зүүсэн мэт харуулна.
 - **ТОЛЬ:** Эможи таны биеийн хөдөлгөөнийг даган дуурайна.
 - **ТОГЛУУЛ:** Эможи бодит орчинд хөдөлнө.



- 3 Эможи дээр товшиж зураг авах юм уу дүрсэн дээр товшиж удаан дараад видео бичлэг хийнэ.
Галерей дотор авсан зураг, видео бичлэгээ харж, хуваалцаж болно.

AR Эможи стикер

Өөрийн эможиний нүүрний хувирал, үйл хөдлөл бүхий стикер бүтээнэ. Зурвас илгээхдээ, мөн сошиал сүлжээнд өөрийн эможиний стикерийг хэрэглэж болно.

Өөрөө стикер бүтээх

- 1 **AR бүс** хэрэглүүрийг нээгээд **AR Эможи стикер** дээр товш.
- 2 Стикерийн жагсаалтын дээр байрлах **+** дээр товш.
- 3 Стикерүүдийг хүссэнээрээ өөрчлөөд **Хадгалах** дээр товш.
Та үүсгэсэн стикерүүдээ харахдаа **Хэрэглэгч** дээр товшиж болно.

AR эможи стикерүүдийг устгах


AR бүс хэрэглүүрийг нээгээд **AR Эможи стикер** →  → **Стикерийг устгах** дээр товш. Устгахыг хүссэн эможи стикерээ сонгоод **Устгах** дээр товш.

Чатлахдаа өөрийн AR эможи стикерүүдээ хэрэглэх

Өөрийн эможиний стикерүүдийг зурвасаар харилцахдаа, мөн сошиал сүлжээнд хэрэглэж болно.

Зурвасууд хэрэглүүрт өөрийн эможиний стикерийг хэрэглэх жишээг доор үзүүлэв.

- 1 **Зурвасууд** хэрэглүүрээр зурвас бичиж байхдаа Samsung товчлуурт гар дээрх 😊 дээр товш.
- 2 Эможиний дүрсийг товш.
- 3 Эможиний стикерээс аль нэгийг сонго.
Эможиний стикер орж ирнэ.




AR Doodle

Хүн, амьтны (муур, нохой) нүүр царай, бусад олон зүйлсийн бичлэгийг хийж, виртуал гар зураг, гар бичмэл нэмнэ. Камер нүүр юм уу хоосон зай илрүүлбэл зурсан зураг нүүрийг дагаж хөдлөх ба хоосон зайн дээрх зураг камер хөдөлсөн ч байрандаа байна.

- 1 **AR бүс** хэрэглүүрийг нээгээд **AR Doodle** дээр товш.
Камер объектыг танивал таних талбай дэлгэц дээр харагдана.

2 Таних талбай дээр бичих юм уу зур.

- Хэрэв арын камер луу шилжвэл мөн таних бүсээс гадна талд бичиж, зурж болно.
- Хэрэв  дээр товшоод зурж эхэлбэл зурах явцын бичлэгийг мөн хийж болно.



3 дээр товшоод видео бичлэг хий.

4 дээр товшоод видео бичлэгийг зогсооно.

Уг видео бичлэгийг **Галерей** хадгалж, хуваалцаж болно.

Deco Pic

Стикертэй зураг авах, видео бичлэг хийх.

AR бүс хэрэглүүрийг нээгээд **Deco Pic** дээр товш.

Дуу хураагуур

Бичлэг хийх ба дуу бичлэгийг тоглуулах.

- 1 **Дуу хураагуур** хэрэглүүрийг нээ.
- 2  дээр товшоод бичиж эхэл. Микрофон руу ярь.
 - Бичлэгийг түр зогсоохын тулд  дээр товш.
 - Дуу бичлэг хийх явцад **ХАВЧУУРГА** дээр товшоод хавчуурга оруулна.
- 3  дээр товшоод бичлэгийг зогсоо.
- 4 Файлын нэрийг оруулаад **Хадгалах** дээр товш.

Бичлэг хийх горимыг өөрчлөх

Дуу хураагуурын дэлгэцийн дээд талд байгаа горимоос сонго.

- **Стандарт:** Ердийн дуу хураах горим.
- **Ярилцлага:** Төхөөрөмжийн дээд, доод талаас ирэх дууг хамгийн их түвшинтэй бичих ба хажуугаас ирэх дууг намсгаж бичнэ.
- **Яриаг бичвэр рүү:** Төхөөрөмж дуу хоолойг бичихийн зэрэгцээ дэлгэц дээр бичвэр болгон хөрвүүлнэ. Хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд нам гүм орчинд төхөөрөмжийг амныхаа ойролцоо барьж, тод чанга дуугаар ярь.



Дуут санамжийн системийн хэл таны ярьж буй хэлтэй тохирохгүй бол төхөөрөмж таны дуу хоолойг танихгүй. Энэ тохиолдолд энэ онцлогийг хэрэглэхийн өмнө одоогийн хэл дээр товшиж, дуут санамжийн системийн хэлийг тохируул.


Сонгосон дуу бичлэгийг тоглуулах

Ярилцлагын бичлэгийг хянахдаа бичлэгт буй зарим дуу чимээний эх үүсвэрийг хааж, нээж болно.

- 1 **Жагсаалт** дээр товшоод ярилцлага горимд бичсэн дуу бичлэгийг сонго.
- 2 Зарим дууны эх үүсвэрийг дарахын тулд тухайн дуу чимээ гарч буй чигт  дээр товш. Дүрс  болж өөрчлөгдөх ба дуу чимээ дарагдана.

Дууны эх үүсвэрийг чимээгүй болгоно

Дууны эх үүсвэрийг чимээгүй болгохгүй



Game Launcher

Game Launcher хэрэглүүр нь **Play Store** болон **Galaxy Store**-оос татаж авсан тоглоомын өгөгдлийг нэг дор нэгтгэж, хэрэглэхэд хялбар болгоно. Тоглоход илүү амар байхын тулд төхөөрөмжийг тоглоомын горимд оруулж болно.

Game Launcher хэрэглүүрийг нээгээд хүссэн тоглоомоо сонго.



- Хэрэв **Game Launcher** гарч ирэхгүй байвал **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** дээр товшоод **Game Launcher** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.
- **Play Store** болон **Galaxy Store**-оос татаж авсан тоглоомуудыг Game Launcher-ийн дэлгэцэд харуулна. Хэрэв тоглоомууд харагдахгүй байвал **Миний тоглоомууд** →  → **Тоглоом нэмэх** дээр товш.

Game Launcher-аас тоглоом хасах

Миний тоглоомууд дээр товшоод, тоглоомыг удаан товшиж, дараа нь **Арилгах** дээр товш.

Гүйцэтгэлийн горимыг өөрчлөх

Та тоглоомын гүйцэтгэлийн горимыг өөрчилж болно.

Game Launcher хэрэглүүрийг нээгээд  → **Game Booster** → **Тоглоомын оновчлол** дээр товшиж хүссэн горимоо сонго.

- **Гүйцэтгэл:** Тоглоом тоглоход гүйцэтгэлийг аль болох өндөр байлгахад анхаарна.
- **Стандарт:** Гүйцэтгэл ба батарей зарцуулах хугацааг тэнцвэртэй байлгана.
- **Батарей хэмнэгч:** Тоглоом тоглох үед батарейн цэнэгийг хэмнэнэ.



Батарейн цэнэгийн ашиглалт тоглоом тус бүрд ялгаатай байж болно.

Game Booster

Game Booster нь илүү дээр орчинд тоглоом тоглох боломж олгоно. Та тоглохдоо Game Booster-ийг хэрэглэж болно.

Тоглоом тоглож байхдаа Game Booster самбарыг нээхийн тулд, залуурдах мөрийн  дээр товш. Залуурдах мөр харагдахгүй байвал дэлгэцийн доод ирмэгээс дээш шударч ил гарга. Та залуурдах мөрийг хэрэглэхээр тохируулсан бол **Дохиог шудрах**, мэдэгдлийн самбарыг нээж **Товшиж Game Booster-г нээх**. дээр товш.

-  : Тоглоом тоглож байхдаа хүрэлцэх/мэдрэгч дэлгэцийг түгж. Мэдрэгч дэлгэцийн түгжээг тайлахдаа түгжээний дүрсийг дурын чиглэлд чир.
 -  : Залуурдах мөр дээрх товчнуудыг нууна. Товчнуудыг харуулахын тулд залуурдах мөрөн дээрх  дээр товш.
 -  : Дэлгэцийн зураг авах.
 -  : Тоглоомын хэсгийг бичих. Бичлэгийг зогсоохын тулд  дээр товш.
 -  : Тоглоомын хурдасгуурын тохиргоог тохируулах.
 - **Нэн тэргүүний горим**: Таны тоглоомыг тасалдуулахгүйн тулд сэрүүлгээс бусад, ирж буй дуудлага болон бүх мэдэгдлийг хориглохоор төхөөрөмжийг тохируулна.
 - **Температурыг хянах / Санах ойг хянах**: Төхөөрөмжийг хэт халахаас сэргийлж, мөн аппликейшнуудыг санах ой ашиглан далд ажиллахаас сэргийлж видео хүрээний хэм буюу дууны чанга сулыг автоматаар тохируулахаар тохируулаарай.
-  • Залуурдах мөрийг **Дохиог шудрах** дээр тохируулаад залуурдах мөрөөс Game Booster самбарыг нээхээр тохируулж болно. Game Booster самбар дээр,  → **Тоглоомын үеэр хориглох** дээр товшоод **Чиглүүлэх дохио** сэлгүүрийг товшиж идэвхжүүлнэ.
- Тоглоомоос хамаараад боломжит сонголтууд нь янз бүр байж болно.

Тоглоом тоглох үед хэрэглүүрийг попап цонхонд нээх

Тоглоом тоглох байхдаа хэрэглүүрийг попап цонхонд нээж болно.

 дээр товшоод жагсаалтаас хэрэглүүрийг сонго.

Агуулга хуваалцах

Төрөл бүрийн хуваалцах сонголтоор агуулга хуваалцана. Зураг хуваалцах жишээг доор харуулав.

1 **Галерей** хэрэглүүрийг сонгоод зургаа сонго.

2  дээр товшоод хуваалцах аргаа сонго.

 Мобайл сүлжээгээр файл хуваалцвал нэмэлт төлбөр тооцож болзошгүй.

Түргэн хуваалцах

Ойролцоох төхөөрөмжтэй контент хуваалцах

Wi-Fi Direct эсвэл Bluetooth-ээр хуваалцах эсвэл SmartThings-д нийцэх төхөөрөмжүүдээр агуулга хуваалцана.

1 **Галерей** хэрэглүүрийг сонгоод зургаа сонго.

2 Нөгөө төхөөрөмж дээр мэдэгдлийн самбар дээр доош шудраад  (**Түргэн хуваалцах**) дээр товшоод үүнийг идэвхжүүл. Хэрэв та түргэн самбараас  (**Түргэн хуваалцах**)-г олж чадаагүй бол  дээр товшиж, товчийг чирээд нэмнэ үү.

3  → **Түргэн хуваалцах** дээр товшоод зураг хүлээн авах төхөөрөмжийг сонго.

4 Нөгөө төхөөрөмж дээр файл дамжуулах хүсэлтийг зөвшөөр.

 Энэ функцээр телевизор юм уу SmartThings бүхий төхөөрөмжөөр видео хуваалцах боломжгүй. Энэ телевизороор видео үзэхийн тулд Ухаалаг дэлгэц онцлогийг хэрэглэнэ үү.

Заагаад хуваалцах

Ойролцоох төхөөрөмжүүдийн дундах нэг төхөөрөмж рүү чиглүүлээд контент хуваалцана.

Энэ функцийг Хэт өргөн зурвас (UWB) функц бүхий Galaxy төхөөрөмж дээр л хэрэглэх боломжтой. Мөн файл хүлээн авч буй бусад төхөөрөмжийн дэлгэц ассан байх ёстой.

1 **Галерей** хэрэглүүрийг сонгоод зургаа сонго.

2 Нөгөө төхөөрөмж дээр мэдэгдлийн самбар дээр доош шудраад  (**Түргэн хуваалцах**) дээр товшоод үүнийг идэвхжүүл. Хэрэв та түргэн самбараас  (**Түргэн хуваалцах**)-г олж чадаагүй бол  дээр товшиж, товчийг чирээд нэмнэ үү.

3 Нөгөө төхөөрөмж дээр  (**Түргэн хуваалцах**) дээр товшиж удаан дараад **Миний байрлалыг бусдад харуул** сэлгүүрийг товшиж идэвхжүүлнэ.

4  → **Түргэн хуваалцах** дээр товшоод төхөөрөмжийн ар талыг нөгөө төхөөрөмж рүү чиглүүл.

5 Нөгөө төхөөрөмж дэлгэцийн дээд талд гарч ирмэгц товш.

6 Нөгөө төхөөрөмж дээр файл дамжуулах хүсэлтийг зөвшөөр.



Таны байгаа улс, бүсээс хамаарч Хэт өргөн зурвас (UWB) функц ажиллахгүй байж болно.

Таны төхөөрөмжийг хэн харж болохыг тохируулах

Хэн таны төхөөрөмжийг хайж олж, контент илгээж болохыг тохируулна.

1 Мэдэгдлийн самбарыг нээгээд, доош шударч,  (**Түргэн хуваалцах**) дээр товш.

2 Аль нэгийг сонго.

- **Хэн ч биш:** Хэн нэгэн таны төхөөрөмжийг хайж олохыг үл зөвшөөр.
- **Зөвхөн харилцагчид:** Төхөөрөмжөөрөө зөвхөн Samsung-гийн харилцагч хуваалцахаар зөвшөөр.
- **Ойролцоо хүн бүхэн:** Ойр ямар төхөөрөмжтэй өөрийн төхөөрөмжөө хуваалцаж холбох.

Samsung DeX

Танилцуулга

Samsung DeX бол ухаалаг утсаа TV, монитор зэрэг нэмэлт дэлгэц, компьютер лүү холбоод компьютер мэт ашиглаж болох төхөөрөмж юм. Ухаалаг утсан дээрээ мауз болон кейборд хэрэглэн том дэлгэцэн дээр гарган ажлаа хурдан хийж гүйцэтгээрэй. Samsung DeX хэрэглэхдээ ухаалаг утсаа нэгэн зэрэг хэрэглэж болно.

Төхөөрөмжийг холбож, Samsung DeX-ийг асаах

Нэмэлт дэлгэц рүү утсаар холбох

Ухаалаг утсаа HDMI адаптер (USB Type-C-г HDMI болгох) хэрэглэн нэмэлт дэлгэц рүү холбож болно.




Зөвхөн Samsung-аас нийлүүлдэг Samsung DeX-д нийцсэн албан ёсны баталгаатай дагалдах хэрэгсэл ашиглана уу. Албан ёсны баталгаагүй дагалдах хэрэгслээс үүдэлтэй гүйцэтгэлд гарах асуудал, доголдол баталгаанд хамрагдахгүй.

- 1 HDMI адаптерыг ухаалаг утсандаа холбо.
- 2 HDMI кабелийг HDMI адаптерт болон TV буюу мониторовын HDMI порт руу залга.

3 Ухаалаг утасны дэлгэц дээр **Эхлэх** дээр товш.

Ухаалаг утасны дэлгэцийг өөрчлөхгүйгээр Samsung DeX дэлгэц холбогдсон TV буюу монитор дээр харагдана.




Компьютертой утсаар холбох

Samsung DeX-ийг ашиглан ухаалаг утсаа компьютертойгоо USB кабелиар холбоно. Төхөөрөмжид дагалдах USB кабелийг хэрэглэхийн тулд компьютер USB Type-C порттой байх ёстой.

- 1 Компьютер дээрээ www.samsung.com/samsung-dex руу ороод Samsung DeX хэрэглүүрийг татаж авна уу.
- 2 Ухаалаг утсыг компьютертой USB кабелиар холбоно.

- 3 Ухаалаг утасныхаа дэлгэц дээр **Одоо эхэл** дээр товш.
Тэдгээрийг холбогдмогц компьютерт Samsung DeX дэлгэц дахин гарч ирнэ.



Утасгүй холболт

Samsung DeX-ийг ашиглан ухаалаг утсаа TV буюу компьютертойгоо утасгүй холбоно.

- 1 Ухаалаг утсан дээрээ мэдэгдлийн самбарыг нээж, доош шудраад  (**DeX**) дээр товш.
 - 2 **ТВ эсвэл дэлгэц дээрх DeX** эсвэл **Компьютер дээрх DeX** дээр товш.
 - 3 Илэрсэн төхөөрөмжийн жагсаалтаас ТВ буюу компьютероо сонгоод **Одоо эхэл** дээр товш.
Зарим телевизорыг зөвхөн дэлгэц дээр гаргах горим ассан үед л илрүүлж болно.
Компьютер таны ухаалаг утастай нэг Wi-Fi сүлжээнд холбогдож, Samsung DeX хэрэглүүр ажиллаж байх ёстой.
 - 4 Хэрэв телевизор юм уу компьютер дээр холбогдох хүсэлт гарч ирвэл хүсэлтийг зөвшөөр.
 - 5 Дэлгэц дээрх зааврыг дагаж холболтыг гүйцэтгэнэ үү.
Тэдгээрийг холбогдмогц телевизор юм уу компьютерт Samsung DeX дэлгэц дахин гарч ирнэ.
-  • Үүнд 2019 оноос хойш үйлдвэрлэгдсэн Samsung ухаалаг ТВ хэрэглэхийг зөвлөж байна.
 - Дэлгэц дээр гаргах функцийг холбогдох гэж буй ТВ дээр тань нийцэж байгаа эсэхийг шалгана уу.

Samsung DeX дэлгэцийг удирдах

Нэмэлт дэлгэц дээр удирдах

Нэмэлт товчлуурт гар, хулганаар удирдах

Та утасгүй товчлуурт гар/хулгана хэрэглэж болно. Төхөөрөмжид харгалзах гарын авлагаас бусад мэдээллийг үзнэ үү.



- Хулганын заагчийг нэмэлт дэлгэцээс утасны дэлгэц рүү шилжихийг тохируулж болно. **Тохиргоо** аппликейшныг ачаалж, **Samsung DeX** → **Хулгана ба тэмтрэх хавтан**-ийг сонго, дараа нь **Урсгал заагчийг утасны дэлгэцэд**-ийг сонгож үүнийг идэвхжүүл.
- Та мөн нэмэлт товчлуурт гарыг ухаалаг утасны дэлгэц дээр хэрэглэж болно.


Ухаалаг утсаа мэдрэгч хавтан болгон хэрэглэх

Та ухаалаг утсаа мэдрэгч хавтангаар ашиглах боломжтой.

Ухаалаг гар утсан дээрээ, залуурдах мөрөн дээрх  товшино уу. Хэрэв та залуурдах мөрийг **Дохиог шударх** ашиглахаар тохируулсан бол, мэдэгдлийн самбарыг нээгээд **Та утсаа мэд.ч хав. бол. ашигла** дээр товш.



- Хэрэв та мэдрэгч хавтан дээр  товчлуурыг хоёр товшвол та мэдрэгч хавтан ашиглан ашиглаж болох дохио зангаагаа үзэх боломжтой.
- Хэрэв ухаалаг утасны гэр нүүрэн талдаа хавтастай бол хавтсыг нээгээд ухаалаг утсаа мэдрэгч хавтан болгон хэрэглэнэ. Хэрэв нүүрэн талын хавтас хаалттай бол мэдрэгч хавтан ажиллахгүй байж болзошгүй.
- Хэрэв ухаалаг утасны дэлгэц унтарвал Хажуугийн товчийг дарах юм уу дэлгэц дээр давхар товшиж дэлгэцийг асаана.



Дэлгэцийн товчлуурт гар хэрэглэх

Зурвас илгээх, тэмдэглэл бичих, бусад ажил хийх зэргээр бичвэр оруулахад нэмэлт товчлуурт гар холбохгүйгээр утасны дэлгэц дээр дэлгэцийн товчлуурт гар харагдана.

Компьютер дээр удирдах

Samsung DeX дэлгэцээ компьютер дээрээсээ кейборд мауз хэрэглэн удирдаарай.

Та компьютер ба Samsung DeX-ийн хооронд чирээд байрлуулах аргаар файлуудыг хялбархан зөөж, бичвэрийг хуулж оруулж болно.



Samsung DeX хэрэглэж байх үед бэлэн товчлуурт гарын холбоосыг харахын тулд, **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Ерөнхий удирдлага** → **Биет гар** → **Keyboard shortcuts** товшино уу.

Samsung DeX Ашиглах

Компьютертой төстэй интерфэйсээр ухаалаг утасны функцийг хэрэглэнэ. Олон хэрэглүүрийг нэгэн зэрэг ажиллуулж, олон ажлын зэрэг амжуулж болно. Мөн ухаалаг утасны дэлгэц, төлөвийг шалгаж болно.



- Samsung DeX-ийн дэлгэцийн харагдах байдал холбогдсон төхөөрөмжөөс хамааран ялгаатай байж болно.
- Samsung DeX-г асаах, унтраахад ажиллаж буй хэрэглүүр хаагдаж болзошгүй.
- Samsung DeX-ийг хэрэглэж байхад зарим хэрэглүүр, функцийг хэрэглэх боломжгүй байж болно.
- Дэлгэцийг тохиргоог тааруулахын тулд холбогдсон TV буюу монитормын дэлгэцийн тохиргоог хэрэглэ.
- Аудио гаралтыг өөрчлөхийн тулд, Төлөвийн бар дээр товшоод, **Медиа гаралт**-ыг сонго, тэгээд төхөөрөмжөө сонго.

Samsung DeX ба ухаалаг утсыг нэгэн зэрэг хэрэглэх

Samsung DeX хэрэглэх үед та тусдаа хэрэглүүрүүдийг нэмэлт дэлгэц юм уу компьютер дээр болон ухаалаг утсан дээр нэгэн зэрэг тусгаарлаж болно.

Жишээ нь: Та холбоотой телевизор юм уу монитор дээр видео бичлэг үзэнгээ найзуудтайгаа чааталж болно.

Холбогдсон TV буюу монитор дээр Samsung DeX дэлгэц дээр ажиллуулах хэрэглүүрийг нээнэ. Дараа нь нөгөө хэрэглүүрийг ухаалаг утсан дээр нээнэ.

Samsung DeX дэлгэцийг түгжих

Хэрэв та Samsung DeX хэрэглэх үедээ Samsung DeX дэлгэц болон ухаалаг утсаа түгжихийг хүсвэл  → **DeX-г түгж**-ийг сонго.



Samsung DeX хэрэглэх үед Samsung DeX дэлгэц ба ухаалаг утасны дэлгэцийг хажуугийн товчоор түгжих боломжгүй.

Компьютерт өгөгдөл дамжуулах

Файл хуулах

Samsung DeX дэлгэц дээр **Миний файлууд** хэрэглүүр эсвэл **Галерей** хэрэглүүрээс файлаа сонгож, удаан дараад компьютерын дэлгэц рүү чирнэ. Компьютерын дэлгэц дээр файлаа сонгоод Samsung DeX дэлгэц, **Миний файлууд** хэрэглүүр эсвэл **Галерей** хэрэглүүр лүү чирнэ.

Бичвэр хуулах, оруулах

Товчлуурт гарын холбоос хэрэглэн Samsung DeX дэлгэц, компьютерын дэлгэц дээрх бичвэрийг хуулж, нөгөө дэлгэц рүү оруулна.

Дэлгэцийн зураг авах, бичлэг хийх

Дэлгэцийн зураг авах

Төхөөрөмжийг хэрэглэж байхдаа дэлгэцийн зураг авч, авсан зурган дээрээ бичиж, зурж, тайрч, хуваалцана. Тухайн дэлгэц дээрх агуулга, гүйлгэж үзэх болох бүх хэсгийн зургийг авч болно.

Дэлгэцийн зургийг хэрхэн авах вэ

Дараах аргуудаар дэлгэцийн зураг авна. Дэлгэцээс авсан зургуудыг **Галерей** харж болно.


1-р арга) Товчоор зураг авах: Хажуугийн товч ба дуу намсгах товчийг зэрэг дарна.

2-р арга) Шудраад зураг авах: Дэлгэц дээгүүр гарын хажуу талаар зүүн эсвэл баруун тийш шударна.



- Зарим хэрэглүүр, функцийг хэрэглэж байхад дэлгэцийн зураг авах боломжгүй.
- Хэрэв шудраад зураг авах функцийг идэвхгүй болгосон бол **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Дэвшилтэт функц** → **Хөдөлгөөн ба дохио** дээр товшоод **Зураг авахад алгаар шудар** сэлгүүрийг товшиж идэвхжүүлнэ.

Дэлгэцийн зургийг авсны дараа дэлгэцийн доод талд буй хэрэгслийн мөр дээрх дараах сонголтыг хэрэглэ:



-  : Үргэлжилсэн хуудас, тухайлбал вэб хуудас зэргийн дэлгэцэд ил харагдаж байгаа болон далд байгаа агуулгын зургийг авна.  дээр товшиход дэлгэц автоматаар доош гүйж бусад агуулгын зургийг авна.
-  : Дэлгэцийн зурган дээр бичих юм уу зурж, зарим хэсгийг нь тасаж авч болно. Тайрсан хэсгийг **Галерей** харж болно.
- **#** : Дэлгэцийн зурган дээр шошго нэмнэ. Дэлгэцийн зургийг шошгоор нь хайхын тулд Хэрэглүүрийн дэлгэцийн дээд талд буй **Хайх** дээр товшиж **Дэлгэцийн зургууд** →  дээр товш. Та мөн шошгоны жагсаалтыг харж, олохыг хүссэн дэлгэцийн зургаа хялбархан хайж болно.
-  : Дэлгэцийн зургийг бусадтай хуваалцана.



Хэрэв авсан дэлгэцийн зураг дээр сонголтууд харагдахгүй байвал **Тохиргоо** аппликейшнийг нээгээд **Дэвшилтэт функц** → **Дэлгэцийн зураг, дэлгэцийн бичлэг хийгч** дээр товшоод **Дэлгэцийн зург.н хэрэгслийн мөр** сэлгүүрийг товшиж идэвхжүүлнэ.

Дэлгэцийн бичлэг хийх

Төхөөрөмжийг ашиглах явцаж дэлгэцийн бичлэг хийнэ.

- 1 Мэдэгдлийн самбарыг нээгээд, доош шударч,  (**Дэлгэц бичих**) дээр товшоод идэвхжүүл.
 - 2 Дууны тохиргоог сонгоод **Бичлэгийг эхлүүлэх** дээр товш.
Тоолж дууссаны дараа бичлэг эхэлнэ.
 - Дэлгэц дээр бичих юм уу зурах бол  дээр товш.
 - Дэлгэцийг өөрийнхөө дүрсийн хамт давхарлан бичихийг хүсвэл  дээр товш.
 - 3 Видео бичлэг хийж дууссаны дараа  дээр товш.
Бичлэгүүдийг **Галерей** харж болно.
-  Дэлгэц бичих тохиргоог өөрчлөхийн тулд, **Тохиргоо** аппликейшныг ачааллаад **Дэвшилтэт функц** → **Дэлгэцийн зураг, дэлгэцийн бичлэг хийгч** дээр товш.

Өмнөх төхөөрөмжөөсөө мэдээлэл дамжуулах (Smart Switch)

Smart Switch-ийг хэрэглэн өмнө хэрэглэж байсан төхөөрөмжөөсөө шинэ төхөөрөмж рүүгээ мэдээллээ дамжуулна.

Тохиргоо аппликейшныг ачаалаад **Данснууд ба нөөцлөлт** → **Хуучин төхөөрмж.с өгөгдөл авчрх** дээр товш.



- Энэ функц зарим төхөөрөмжид эсвэл компьютерт ажиллахгүй байж болзошгүй.
- Хязгаарлалттай байдаг. www.samsung.com/smartswitch хуудсанд зочилж мэдээлэл авна уу. Samsung албан ёсны зохиогчийн эрхтэй. Зөвхөн та өөрт хамаарах, эсвэл дамжуулах зөвшөөрөлтэй агуулгыг дамжуулна.

USB кабелиар мэдээлэл дамжуулах

Та өмнөх төхөөрөмжөө USB кабелиар энэ төхөөрөмжтэйгөө холбоод хурдан бөгөөд хялбархнаар мэдээллээ дамжуулан авч болно.

1 Төхөөрөмжөө өмнөх төхөөрөмжтэйгөө USB кабелиар нь холбо.

Өмнөх төхөөрөмжөөс хамаараад USB залгуур хэрэгтэй байж магадгүй.

2 Хэрэглүүр сонгох попап цонх гарч ирэхэд **Smart Switch** → **Өгөгдөл хүлээн авах** дээр товш.

3 Өмнөх төхөөрөмж дээрээ **Зөвшөөрөх** дээр товш.

Хэрэв танд уг хэрэглүүр байхгүй бол **Galaxy Store** эсвэл **Play Store**-оос татаж ав.

Таны төхөөрөмж өмнөх төхөөрөмжийг таньж, таны дамжуулж болох мэдээллийн жагсаалт гарч ирнэ.

4 Авчрахыг хүссэн зүйлээ сонгоод **Шилжүүлэх** дээр товш.



Файл дамжуулж байхдаа USB кабелийг төхөөрөмжөөс бүү салга. Ингэснээр мэдээлэл алга болох юм уу төхөөрөмж гэмтэж болзошгүй.



Мэдээлэл дамжуулалт нь төхөөрөмжийн батарейн цэнэгийн зарцуулалтыг ихэсгэнэ. Мэдээлэл дамжуулахаас өмнө төхөөрөмжийг хангалттай цэнэглэвэл зохино. Хэрэв батарейн цэнэг бага бол мэдээлэл дамжуулалт тасалдаж болзошгүй.

Мэдээллийг утасгүй дамжуулах

Өмнөх төхөөрөмжөөс Wi-Fi Direct функц хэрэглэн утасгүйгээр мэдээлэл дамжуулах.

- 1 Өмнөх төхөөрөмж дээрээ **Smart Switch**-ийг нээ.
Хэрэв танд уг хэрэглүүр байхгүй бол **Galaxy Store** эсвэл **Play Store**-оос татаж ав.
- 2 Төхөөрөмж дээрээ, **Тохиргоо** аппликейшныг ачлааллаад **Данснууд ба нөөцлөлт** → **Хуучин төхөөрөмж.с өгөгдөл авчрх** дээр товш.
- 3 Төхөөрөмжүүдийг ойр байрлуул.
- 4 Өмнөх төхөөрөмж дээрээ **Өгөгдөл илгээх** → **Утасгүй** дээр товш.
- 5 Төхөөрөмж дээрээ **Өгөгдөл хүлээн авах** гэснийг товшиж, өмнөх төхөөрөмжийнхөө үйлдлийн системийг сонгоод **Утасгүй** товшино уу.
- 6 Өмнөх төхөөрөмж дээрээ **Зөвшөөрөх** дээр товш.
- 7 Төхөөрөмж дээрээ авчрахыг хүссэн зүйлээ сонгоод **Шилжүүлэх** дээр товш.

Гадаад санах ой хэрэглэн мэдээлэл нөөцлөх, сэргээх

Бичил SD карт гэм мэт гадаад санах ой хэрэглэн мэдээлэл дамжуулна.

- 1 Өмнөх төхөөрөмжөөсөө гадаад санах ой руу мэдээлэл нөөцөлж ав.
- 2 Гадаад санах ойн төхөөрөмжийг өөрийн төхөөрөмжид хийх буюу залга.
- 3 Төхөөрөмж дээрээ **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Данснууд ба нөөцлөлт** → **Гадаад санах ойд шилж-х** дээр товшино уу.
- 4 **SD картаас сэргээх** гэдгийн дор байгаа Нөөцлөх огноог сонгоод **Сэргээх** товш.
- 5 Дэлгэц дээрх зааврыг дагаад өмнөх гадаад санах ойгоос мэдээллээ шилжүүл.

Компьютерээс нөөцөлсөн өгөгдлийг дамжуулах

Таны төхөөрөмж болон компьютерийн хооронд өгөгдөл дамжуулах. Та Smart Switch -ийн компьютерийн хувилбарын аппликейшнийг нь татаж авах ёстой www.samsung.com/smartswitch. Өмнөх төхөөрөмжнөөсөө өгөгдлийг компьютерт нөөцөлж төхөөрөмжиндөө импортлох.

1 Компьютер дээрээ, www.samsung.com/smartswitch -руу орж Smart Switch -ийг татаж ав.

2 Компьютер дээрээ Smart Switch-ийг ажиллуул.



Хэрэв өмнөх төхөөрөмж тань Samsung төхөөрөмж биш бол, үйлдвэрлэгчийн нийлүүлсэн програмыг хэрэглэн компьютерт өгөгдлөө нөөцөл. Тав дахь үе шатыг алгас.

3 Төхөөрөмжийн USB кабелийг хэрэглэж өмнөх төхөөрөмжөө компьютерт холбо.

4 Компьютерт дэлгэц дээрх зааврыг дагаад төхөөрөмжөөсөө мэдээллээ нөөцөлнө.
Дараа нь, төхөөрөмжөө компьютерээс салга.

5 USB кабел хэрэглэн төхөөрөмжөө компьютерт холбо.

6 Компьютерт дэлгэц дээрх зааврыг дагаад төхөөрөмж рүүгээ мэдээлэл дамжуулна.

Тохиргоо

Танилцуулга

Төхөөрөмжийн тохиргоог өөртөө тохируулан өөрчилнө.

Тохиргоо хэрэглүүрийг нээ.

Тохиргоог түлхүүр үгээр хайхдаа **Q** дээр товш.

Энэхүү бүлэг нь Samsung төхөөрөмжийн тохиргоо болон функциудад зориулагдсан нийтлэг гарын авлага юм.

Загвараас хамаарч зарим агуулга нь ялгаатай буюу таны төхөөрөмжид зориулагдаагүй функц, сонголтуудын тайлбар орсон байж болно.



Samsung account

Samsung бүртгэлдээ нэвтэрч ороод удирдана уу.

Тохиргооны дэлгэц дээр **Samsung account** дээр товш.

Холболтууд

Сонголт

Wi-Fi функц болон Bluetooth зэрэг төрөл бүрийн холболтын тохиргоог өөрчилнө.

Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** дээр товш.

- **Wi-Fi:** Wi-Fi функцийг идэвхжүүлж Wi-Fi сүлжээ ба Интернетэд эсвэл сүлжээний бусад төхөөрөмжтэй холбогдоно. Дэлгэрэнгүй мэдээллийг [Wi-Fi](#)-ээс авна уу.
- **Bluetooth:** Бусад Bluetooth бүхий төхөөрөмжтэй мэдээлэл эсвэл медиа файл солилцохын тулд Bluetooth функцийг хэрэглэнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Bluetooth](#)-ээс авна уу.
- **NFC ба харилцалгүй хийх төлбөр:** Төхөөрөмжийг аливаа бүтээгдэхүүний мэдээллийг агуулсан ойрын зайн холболтын (NFC) шошгыг уншихыг зөвшөөрөх эсэхийг тохируулна. Энэ функцийг хэрэглэн төлбөр төлж, зохих хэрэглүүрийг татаж авсны дараа нийтийн тээврийн юм уу арга хэмжээний тасалбар худалдан авч болно. Дэлгэрэнгүй мэдээллийг [NFC ба харилцалгүй хийх төлбөр \(NFC-идэвхэжсэн загвар\)](#)-ээс авна уу.
- **Нислэгийн горим:** Төхөөрөмжийн утасгүй холболтын бүх функцийг идэвхгүй болгоно. Та зөвхөн сүлжээний бус үйлчилгээг ашиглах боломжтой байна.



Нисэх буудлын дүрэм журам болон нисэх багийн ажилтны өгсөн зааврыг дага.

Төхөөрөмжийг ашиглахыг зөвшөөрсөн тохиолдолд, түүнийг ямагт нислэгийн горимд ашигла.

- **Гар утасны сүлжээ:** Мобайл сүлжээний тохиргоог өөрчилнө.
- **Өгөгдлийн ашиглалт:** Таны дата хэрэглээний хэмжээг хянаж, хязгаарлах тохиргоог өөрчилнө. Таны хэрэглэсэн мобайл дата хэмжээ заасан хязгаараас хэтэрсэн бол төхөөрөмж мобайл дата холболтыг автоматаар идэвхгүй болгох эсэхийг тохируулна.

Түүнчлэн дата хэмнэх функцийг идэвхжүүлж, зарим хэрэглүүрийг далд ажиллаж, мэдээлэл илгээж, хүлээн авахаас сэргийлж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг [Дата хэмнэгч](#)-ээс авна уу.

Төхөөрөмж Wi-Fi сүлжээнд холбоотой байсан ч зөвхөн мобайл дата ашиглавал зохих хэрэглүүрүүдийг сонгож болно. Дэлгэрэнгүй мэдээллийг [Мобайл дата зөвхөн хэрэглүүрүүд](#)-ээс авна уу.

- **SIM карт удирдах:** SIM эсвэл USIM картыг идэвхжүүлж, SIM картын тохиргоог өөрчилнө. Дэлгэрэнгүй мэдээллийг [SIM карт удирдах](#)-ээс авна уу.
- **Мобайл Хотспот ба Холболт:** Төхөөрөмжийн мобайл дата холболтыг утасгүй интернетийн бүс болгон бусад төхөөрөмжтэй хуваалцаж ашиглана. Утасгүй интернетийн бүсийн тухай бусад мэдээллийг [Мобайл Хотспот](#) хэсгээс үзнэ үү.



Энэ функцийг хэрэглэснээр нэмэлт төлбөр тооцож болзошгүй.

- **Бусад холболтын тохиргоо:** Тохиргоог өөрчлөөд бусад функцийг удирдана. Дэлгэрэнгүй мэдээллийг [Бусад холболтын тохиргоо](#)-ээс авна уу.

Wi-Fi

Wi-Fi функцийг идэвхжүүлж, Wi-Fi сүлжээ ба Интернетэд эсвэл сүлжээний бусад төхөөрөмжтэй холбогдоно.

Wi-Fi сүлжээнд холбогдох

1 Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** → **Wi-Fi** дээр товшиж, сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

2 Wi-Fi сүлжээний жагсаалтаас сүлжээг сонгоно уу.

Түгжээний дүрстэй сүлжээнүүд нууц үг шаарддаг.



- Төхөөрөмж Wi-Fi сүлжээнд нэг удаа холбогдсон бол тухайн сүлжээнд дахин холбогдох болгондоо нууц үг шаардахгүй. Төхөөрөмжийн автоматаар сүлжээнд холбогдохоос сэргийлэхийн тулд сүлжээний хажуу дахь  дээр товшоод **Автоматаар дахин холбогдох** сэлгүүрийг товшиж үүнийг идэвхгүй болгоно.
- Хэрэв Wi-Fi сүлжээнд зүй ёсоор холбогдож чадахгүй байвал төхөөрөмжийн Wi-Fi функцийг эсвэл утасгүй чиглүүлэгчийг унтрааж, асаа.

Wi-Fi сүлжээний чанарын мэдээллийг харах

Wi-Fi сүлжээний хурд, тогтворжилт зэрэг чанарын мэдээллийг харуулна.

Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** → **Wi-Fi** дээр товшиж, сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Сүлжээний чанарын мэдээлэл Wi-Fi сүлжээний хэсэгт харагдана. Хэрэв харагдахгүй байвал  →

Нарийвчилсан дээр товшоод **Сүлжээний чанарн мэд.лэл харуул** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.



Чанартай мэдээлэл нь Wi-Fi сүлжээнээс хамааран харагдахгүй байж болзошгүй.

Wi-Fi сүлжээний нууц үгийг хуваалцах

Хэрэв та аюулгүй Wi-Fi сүлжээ рүү холбогдсон хүн рүү үүний нууц үгийг хуваалцах хүсэлт гаргавал та нууц үг оруулалгүйгээр сүлжээнд холбогдох боломжтой. Энэхүү онцлог нь бие биетэйгээ харилцаатай болон нөгөө төхөөрөмж нь асаалттай төхөөрөмжүүдийн хооронд боломжтой.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** → **Wi-Fi** дээр товшиж, сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
- 2 Wi-Fi сүлжээний жагсаалтаас сүлжээг сонгоно уу.
- 3 **Нууц үг хүсэх** дээр товш.
- 4 Нөгөө төхөөрөмж дээр файл хуваалцах хүсэлтийг зөвшөөрнө үү.
Wi-Fi нууц үгийг таны төхөөрөмж дээр оруулж, энэ нь сүлжээнд холбогдсон байна.

Wi-Fi Direct

Wi-Fi Direct нь хандалтын цэг шаардахгүйгээр Wi-Fi сүлжээгээр төхөөрөмжүүдийг хооронд нь шууд холбоно.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** → **Wi-Fi** дээр товшиж, сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
- 2  → **Wi-Fi Direct** дээр товш.
Илэрсэн төхөөрөмжүүд жагсаалтаар гарч ирнэ.
Таны холбох гэж буй төхөөрөмж жагсаалтад байхгүй бол уг төхөөрөмжийн Wi-Fi Direct функцийг асаахыг хүснэ үү.
- 3 Холбогдох төхөөрөмжөө сонго.
Нөгөө төхөөрөмж Wi-Fi Direct холболтын хүсэлтийг хүлээн авбал төхөөрөмжүүд холбогдоно.
Төхөөрөмжийн холболтыг төгсгөхийн тулд жагсаалтаас салгах төхөөрөмжийг сонго.

Bluetooth

Bluetooth бүхий төхөөрөмжтэй мэдээлэл, медиа файл солилцохын тулд Bluetooth функцийг хэрэглэнэ.



- Bluetooth холболтоор дамжуулан илгээсэн, хүлээн авсан мэдээлэл алдагдах, хөндлөнгийн нөлөөнд орох, зүй бусаар ашиглагдах асуудалд Samsung хариуцлага хүлээхгүй.
- Мэдээлэл хуваалцах юм уу илгээж буй төхөөрөмж найдвартай бөгөөд зохих ёсоор хамгаалагдсан эсэхийг байнга шалгавал зохино. Төхөөрөмжүүдийн хооронд саад болох биет байвал холболтын зай багасаж болно.
- Зарим төхөөрөмж, ялангуяа Bluetooth SIG-ээр шалгуулж, баталгаажаагүй бол таны төхөөрөмжтэй нийцэж ажиллахгүй байж болзошгүй.
- Bluetooth функцийг хууль бус зорилгоор (хууль бусаар файл хуулбарлах, ашиг олох зорилгоор хууль холболт тогтоох гэх мэт) бүү ашигла. Bluetooth функцийг хууль бусаар ашигласнаас үүдэн гарах хохирлыг Samsung хариуцахгүй.

Бусад Bluetooth төхөөрөмжтэй хослох

1 Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** → **Bluetooth** дээр товшиж, сэлгүүрийг товшоод идэвхжүүл. Илэрсэн төхөөрөмжүүд жагсаалтаар гарч ирнэ.

2 Хослуулахыг хүссэн төхөөрөмжөө сонго.

Хэрэв хослуулах гэж буй төхөөрөмж жагсаалтад байхгүй бол уг төхөөрөмжийг Bluetooth-ээр хослуулах горимд оруул. Нөгөө төхөөрөмжийн хэрэглэгчийн гарын авлагыг үзнэ үү.



Bluetooth тохиргооны дэлгэц нь нээлттэй үед таны төхөөрөмж бусад төхөөрөмжид харагдана.

3 Төхөөрөмж дээрээ Bluetooth холболтын хүсэлтийг хүлээн авч зөвшөөр.

Нөгөө төхөөрөмж Bluetooth холболтын хүсэлтийг хүлээж авбал төхөөрөмжүүд холбогдоно.

Төхөөрөмжийн холболтыг салгахын тулд салгах гэж буй төхөөрөмжийн нэрийн хажууд буй  дээр товшоод **Үл хослуулах** дээр товш.

Мэдээлэл илгээх, хүлээн авах

Олон хэрэглүүр Bluetooth-ээр мэдээлэл дамжуулах чадвартай байдаг. Та харилцагчид, медиа файл зэрэг мэдээллийг Bluetooth бүхий бусад төхөөрөмжтэй хуваалцаж болно. Нөгөө төхөөрөмж рүү зураг илгээж байгаа жишээг доор харуулав.

1 **Галерей** хэрэглүүрийг сонгоод зургаа сонго.

2  → **Bluetooth** дээр товшоод зураг хүлээн авах төхөөрөмжийг сонго.

Хэрэв хослуулах гэж буй төхөөрөмж жагсаалтад байхгүй бол төхөөрөмжийн харагдцын сонголтыг идэвхжүүлэхийг хүснэ үү.

3 Нөгөө төхөөрөмж дээр Bluetooth холболтын хүсэлтийг зөвшөөр.

NFC ба харилцалгүй хийх төлбөр (NFC-идэвхэжсэн загвар)

Таны төхөөрөмж бүтээгдэхүүний мэдээлэл бүхий ойрын зайн холболт (NFC) шошго унших чадвартай. Энэ функцийг хэрэглэн төлбөр төлж, зохих хэрэглүүрийг татаж авсны дараа нийтийн тээврийн юм уу арга хэмжээний тасалбар худалдан авч болно.




Төхөөрөмжийн дотор NFC антен бий. Төхөөрөмжийн NFC антеныг гэмтэхээс сэргийлж, төхөөрөмжийг болгоомжтой хэрэглэнэ үү.

NFC шошгоос мэдээлэл унших

NFC функцийг хэрэглэн NFC шошгоо бүтээгдэхүүний мэдээллийг уншина.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** дээр товшиж, **NFC ба харилцалгүй хийх төлбөр** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
- 2 Төхөөрөмжийн ар талд байх NFC антены талбайг NFC шошгын орчим байрлуул. Шошгын мэдээлэл гарч ирнэ.



Төхөөрөмжийн дэлгэц ассан, түгжээ тайлагдсан байх ёстой. Үгүй бол төхөөрөмж NFC шошгыг уншиж, мэдээлэл хүлээн авч чадахгүй.

NFC функцээр төлбөр төлөх

NFC функцийг төлбөр төлөхөд ашиглахын өмнө мобайл төлбөрийн үйлчилгээгээ бүртгэсэн байх ёстой. Үйлчилгээг бүртгэх, бусад мэдээллийг авахыг хүсвэл үйлчилгээ үзүүлэгчээсээ лавлана уу.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** дээр товшиж, **NFC ба харилцалгүй хийх төлбөр** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
- 2 Төхөөрөмжийн ар талд байх NFC антены талбайг NFC карт уншигч дээр хүргэ.

Төлбөрийн өгөгдмөл хэрэглүүрийг тохируулахдаа Тохиргооны дэлгэцийг нээгээд **Холболтууд** → **NFC ба харилцалгүй хийх төлбөр** → **Харилцан үйлчлэлгүй төлбөр** → **Төлбөр** дээр товшиж, хэрэглүүрийг сонгоно уу.



Төлбөрийн үйлчилгээний жагсаалтад бүх төлбөрийн хэрэглүүр ороогүй байж магадгүй.

Дата хэмнэгч

Далд ажиллаж буй зарим хэрэглүүрийн мэдээлэл илгээх, хүлээн авахыг хязгаарласнаас дата хэрэглээг бууруулна.

Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** → **Өгөгдлийн ашиглалт** → **Дата хэмнэгч** дээр товшиж, сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Дата хэмнэгч функцийг идэвхжүүлсэн бол төлөвийн мөрд  дүрс гарч ирнэ.



Дата хэмнэх онцлог
идэвхэжсэн



Хязгааргүй дата хэрэглэх хэрэглүүрийг сонгохдоо **Дата хэмнэгч ассн үед дата ашиглахг зөвшрнө** дээр товшоод хэрэглүүрийг сонгоно уу.

Мобайл дата зөвхөн хэрэглүүрүүд

Төхөөрөмж Wi-Fi сүлжээнд холбоотой байсан ч зөвхөн мобайл дата ашиглавал зохих хэрэглүүрүүдийг сонгоно.

Жишээ нь: Нууцалбал зохих, эсвэл нэвтрүүлэг хийдэг, салгаж болох хэрэглүүрүүдэд зөвхөн мобайл дата ашиглахаар сонгож болно. Wi-Fi функцийг идэвхжүүлээгүй байсан ч уг хэрэглүүр мобайл дата хэрэглэн ажиллах болно.

Тохиргоо дэлгэц дээр, **Холболтууд** → **Өгөгдлийн ашиглалт** → **Мобайл дата зөвхөн хэрэглүүрүүд** дээр товшоод, сонгосон аппликейшнуудынхаа сэлгүүр дээр товш.



Энэ функцийг хэрэглэснээр нэмэлт төлбөр тооцож болзошгүй.

Мобайл Хотспот

Төхөөрөмжийн мобайл дата холболтыг бусад төхөөрөмжтэй хуваалцахын тулд төхөөрөмжийг утасгүй интернетийн бүс болгон ашиглана.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** → **Мобайл Хотспот ба Холболт** → **Мобайл Хотспот** дээр товш.
 - 2 Сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
Төлөвийн мөрөн дээр  дүрс гарч ирнэ.
Та **Тохируулах** дээр товшиж аюулгүй байдлын түвшин болон нууц үгийг өөрчлөх боломжтой.
 - 3 Нөгөө төхөөрөмжийн дэлгэц дээрх Wi-Fi сүлжээний жагсаалтаас өөрийн төхөөрөмжийг олж сонго.
Эсвэл гар утасны утасгүй интернетийн бүс дэлгэц дээрх **QR код** товшоод, QR кодыг нөгөө төхөөрөмжөөс сканнердах боломжтой.
-  • Хэрэв гар утасны утасгүй интернетийн бүс олдоогүй бол, төхөөрөмж дээрээ **Тохируулах** дээр дараад **Давтамж**-ийг **2,4 ГГц** болгож тохируулаад, **Нарийвчилсан** гэсэн сонголтыг товшоод, дараа нь **Нуусан сүлжээ** хөвүүрийг идэвхгүйжүүлнэ үү.
- Хэрэв **Авто хотспот** функцийг идэвхжүүлсэн бол та төхөөрөмжийнхөө мобайл дата холболтыг өөрийн Samsung бүртгэлээр нэвтэрсэн бусад төхөөрөмжтэй хуваалцаж болно.

Бусад холболтын тохиргоо

Холболтын бусад функцүүдийг хянах тохиргоог өөрчилнө.

Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** → **Бусад холболтын тохиргоо** дээр товш.

- **Ойр. төх.г уншиж байна:** Төхөөрөмжийг ойролцоо холбогдох боломжтой төхөөрөмжийг хайх эсэхийг тохируулна.
- **Хэвлэх:** Төхөөрөмж дээр суурилсан хэвлэгчийн туслах программын тохиргоог тааруулна. Файл хэвлэхийн тулд тохирох хэвлэгчийг хайж эсвэл гараар нэм. Дэлгэрэнгүй мэдээллийг [Хэвлэх](#)-ээс авна уу.
- **VPN:** Төхөөрөмж дээр виртуал хувийн сүлжээ (VPN) тохируулж, төхөөрөмжийг сургуулийн эсвэл компанийн хувийн сүлжээнд холбоно.
- **Хувийн DNS:** Төхөөрөмжид сайжруулсан хамгаалалттай DNS тохируулна.
- **Ethernet:** Этернет адаптерт холбогдвол утсан сүлжээ ашиглаж, сүлжээний тохиргоог өөрчилнө.

Хэвлэх

Төхөөрөмж дээр суурилсан хэвлэгчийн туслах программын тохиргоог тааруулна. Төхөөрөмжийг хэвлэгч рүү Wi-Fi эсвэл Wi-Fi Direct-ээр холбож, зураг, бичиг баримт хэвлэнэ.



Зарим хэвлэгч төхөөрөмжид тохирохгүй байж магадгүй.

Хэвлэгчийн туслах программ нэмэх

Төхөөрөмжид холбохыг хүсэж буй хэвлэгчийн туслах программыг нэмнэ.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Холболтууд** → **Бусад холболтын тохиргоо** → **Хэвлэх** → **Залгаасыг татаж ав** дээр товшино уу.
- 2 Хэвлэгчийн туслах программыг сонгоод суурилуул.
- 3 Суурилуулсан хэвлэгчийн туслах программыг сонго.
Төхөөрөмж нэг Wi-Fi сүлжээнд холбогдсон хэвлэгчийг таны төхөөрөмж гэж үзэн автоматаар хайна.
- 4 Нэмэх хэвлэгчээ сонго.



Хэвлэгчийг гараар нэмэхийн тулд  → **Хэвлэгч нэмэх** дээр товш.

Агуулга хэвлэх

Зураг, баримт бичиг зэрэг агуулга үзэхдээ сонголтын жагсаалтад хандаж, **Хэвлэх** → **Хэвлэгч сонгох** → **Бүх принтерүүд...** дээр товшоод хэвлэгчийг сонго.



Агуулгын төрлөөс хамааран хэвлэх арга өөрчлөгдөж болно.

Дуу ба чичиргээ

Сонголт

Төхөөрөмжийн дуу чимээний тохиргоог өөрчилнө.

Тохиргооны дэлгэц дээр **Дуу ба чичиргээ** дээр товш.

- **Дууны горим:** Төхөөрөмжид хэрэглэх дууны горим, чичиргээний горим, чимээгүй горимыг тохируулна.
- **Дуугарах үед чичиргэх:** Дуудлага ирэхэд төхөөрөмжийг хонхны аяыг дуугаргаж, чичирхийлэх эсэхийг тохируулна.
- **Түр дуу хаах:** Төхөөрөмжид заасан хугацаанд чимээгүй горимыг хэрэглэхээр тохируулна.
- **Хонхны ая:** Дуудлагын хонхны аяыг өөрчилнө.
- **Мэдэгдлийн дуу:** Мэдэгдлийн дуу чимээг өөрчилнө.
- **Системийн дуу:** Төхөөрөмжийг цэнэглэх зэрэг үйлдэлд хэрэгдэх дууг өөрчилнө.
- **Дууны хэмжээ:** Төхөөрөмжийн дууны түвшнийг тааруулна.
- **Дуудлагын чичиргээний хэв маяг:** Дуудлагын чичиргээний хэмнэлийг өөрчилнө.
- **Мэдэгдлийн чичиргээний хэв маяг:** Мэдэгдлийн чичиргээний хэмнэлийг өөрчилнө.
- **Чичиргээний хүч:** Чичиргээт мэдэгдлийн хүчийг тааруулна.
- **Системийн дуу/чичиргээ удирдах:** Төхөөрөмжийн дуу, чичиргээг мэдрэгч дэлгэцийг удирдах зэрэг үйлдэлд тохируулна.
- **Дууны чанар ба эффект:** Төхөөрөмжийн дууны чанар, эффектийг тохируулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Дууны чанар ба эффект](#)-ээс авна уу.
- **Хэрэглүүрийн дууг тусад нь гаргах:** Төхөөрөмжийн тоглуулж буй медиаг өөр аудио төхөөрөмж дээр тусад нь тоглуулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Хэрэглүүрийн дууг тусад нь гаргах](#)-ээс авна уу.



Загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж магадгүй.

Дууны чанар ба эффект

Төхөөрөмжийн дууны чанар, эффектийг тохируулна.

Тохиргооны дэлгэц дээр **Дуу ба чичиргээ** → **Дууны чанар ба эффект** дээр товш.

- **Dolby Atmos:** Кино, хөгжим, дуу хоолой гэх зэрэг төрөл бүрийн аудионд зориулан стерео дууны горимыг сонгоно. Dolby Atmos аудио дуу чимээг таны эргэн тойронд амьд, хөдөлгөөнтэй мэт сонгоно.

- **Тоглоомын Dolby Atmos:** Тоглох үед тоглоомонд зориулан тохируулсан Dolby Atmos дууг мэдрүүлнэ.
- **Тэнцвэржүүлэгч:** Дууны жанрт зориулсан сонголтыг сонгож, мэдрүүлнэ.
- **UHQ өсгөгч:** Утастай чихэвч ашиглах үед хөгжим, видеоны дууны нягтралыг сайжруулах.
- **Adapt Sound:** Дууг танд хамгийн сайнаар тохируулж өгнө.



Загвараас хамааран зарим онцлогийг ашиглахын тулд та чихэвч холбох ёстой.

Хэрэглүүрийн дууг тусад нь гаргах

Төхөөрөмжөөс заасан хэрэглүүрээр тоглуулж буй медианы дууг Bluetooth чанга яригч руу эсвэл чихэвч рүү тусад нь гаргаж болно.

Жишээ нь: та Залуур хэрэглүүрийг төхөөрөмжийн чанга яригчаар сонсонгоо Дуу хөгжим хэрэглүүрээр тоглуулж буй дуу хөгжмийг тээврийн хэрэгслийн Bluetooth чанга яригчаар сонсож болно.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Дуу ба чичиргээ** → **Хэрэглүүрийн дууг тусад нь гаргах** дээр товшиж, сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
- 2 Медиа дууг тусад нь тоглуулах аппыг сонгоод Буцах товчийг товшино уу.
- 3 Сонгосон хэрэглүүрийн медиа дууг тоглуулах төхөөрөмжийг сонго.

Мэдэгдлүүд

Мэдэгдлийн тохиргоог өөрчилнө.

Тохиргооны дэлгэц дээрх **Мэдэгдлүүд** дээр товш.

- **Мэдэгдлүүдийн жижиг цонхны загвар:** Мэдэгдлийн гарч ирэх хэв маягийг сонгоод тохиргоог өөрчлөх.
- **Сүүлд илгээсэн:** Саяхан мэдэгдэл хүлээн авсан хэрэглүүрүүдийг харж мэдэгдлийн тохиргоог өөрчилнө. Бусад хэрэглүүрийн мэдэгдлийн тохиргоог өөрчлөхийн тулд **Бусад** → ▼ → **Бүгд** дээр товшоод жагсаалтаас хэрэглүүрийг сонго.
- **Бүү үймүүл:** Төхөөрөмж зөвшөөрснөөс бусад дуу чимээг хаахаар тохируулна.
- **Нарийвчилсан тохиргоо:** Мэдэгдлүүдийн нарийвчилсан тохиргоог хийх.

Дэлгэц

Сонголт

Дэлгэц, үндсэн дэлгэцийн тохиргоог өөрчилнө.

Тохиргооны дэлгэц дээр **Дэлгэц** дээр товш.

- **Гэрэлтэй/Бараан:** Харанхуй горимыг идэвхжүүлэх эсэхийг сонгоно.
- **Бараан горимын тохиргоо:** Шөнийн цагаар эсвэл харанхуй газар төхөөрөмжийг хэрэглэх үед бараан загвар оруулснаар нүдний ачааллыг багасгана. Харанхуй горимыг хэрэглэх хуваарийг тохируулж болно.
 Зарим хэрэглүүрт бараан загвар үйлчлэхгүй байж болзошгүй.
- **Цайралт:** Дэлгэцийн цайралтыг тааруулна.
- **Тохируулж болох цайралт:** Төхөөрөмж цайралтын өөрчлөлтийг хянаж, үүнийгээ адил төстэй гэрэлтүүлэгтэй нөхцөлд хэрэглэнэ.
- **Хөдөлгөөний саадгүй байдал:** Дэлгэцийн кадрын хурдыг өөрчилнө. Кадрын хурдыг ихэсгэх тусам дэлгэц дээрх дүрсийн шилжилт өө сэвгүй болно.
- **Нүдний тав тухыг хамгаалагч:** Дэлгэцээс ялгарч буй цэнхэр гэрлийн хэмжээг бууруулж, нүдний ачааллыг багасгана. Энэ онцлогийг хэрэглэх хуваарийг тохируулж болно.
- **Дэлгэцийн горим:** Дэлгэцийн горимыг өөрчилж, дэлгэцийн өнгө, ялгарлыг тааруулна.
- **Үсгийн хэвийн хэмжээ ба загвар:** Үсгийн хэмжээ ба хэв маягийг өөрчилнө.
- **Дэлгэц томруулах:** Дэлгэц дээрх зүйлсийг томруулж, эсвэл багасгаж болно.
- **Дэлгэцийн нягтрал:** Дэлгэцийн нягтралыг өөрчилнө. Нягтрал өндөр байх тусам батарейн цэнэгийн зарцуулалт их байна. Нягтралыг өөрчлөх үед ажиллаж буй зарим хэрэглүүр хаагдаж болзошгүй.
- **Дэлгэц дүүрэн хэрэглүүрүүд:** Дэлгэцийн харьцааг дүүргэх хэрэглүүрүүдийг сонгоно.
- **Дэлгэц амрах:** Дэлгэцийн гэрэлтүүлгийг унтраахын өмнө төхөөрөмжийн хүлээх хугацааг тохируул.
- **Хялбар горим:** Үндсэн дэлгэцийг томовтор дүрс, энгийн харагдах байдал бүхий хялбар горимд шилжүүлнэ.
- **Захын самбарууд:** Захын самбарны тохиргоог өөрчилнө.

- **Чиглүүлэх мөр:** Залуурдах мөрийн тохиргоог өөрчилнө. Дэлгэрэнгүй мэдээллийг [Залуурдах мөр \(мэдрэгч товчнууд\)](#)-ээс авна уу.
- **Санаандгүй хүрэхээс хамгаалах:** Харанхуй газар, цүнх, халаасанд байхад нь дэлгэцэд санамсаргүй хүрэхээс хамгаална.
- **Дэлгэцийн мэдрэмтгий чанар:** Дэлгэц хамгаалалтын хуулга ашиглах үед дэлгэцийн мэдрэмжийг нэмэгдүүлнэ.
- **Цэнэглэж буй мэдээлэл харуулах:** Төхөөрөмжийн дэлгэц унтарсан үед үлдэж буй зайн хувь хэмжээ зэрэг цэнэглэлтийн мэдээллийг харуулахаар тохируулна.
- **Дэлгэц амраагч:** Төхөөрөмжийг цэнэглэж байх үед дэлгэц амраагчийг ажиллуулахаар тохируул.



Загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж магадгүй.

Хөдөлгөөний саадгүй байдал

Кадрын хурд бол секундэд дүрс хэдэн удаа солигдохыг илтгэх тоо юм. Кадрын хурдыг нэмснээр дүрс солигдох хооронд дэлгэц анивалзахаас сэргийлнэ. Кадрын шилжилт өө сэвгүй болно. Стандарт кадрын хурдыг сонговол зайн цэнэгийг илүү удаан хэрэглэнэ.

1 Тохиргооны дэлгэц дээр **Дэлгэц** → **Хөдөлгөөний саадгүй байдал** дээр товш.

2 Кадрын хурдыг сонгоно.

- **Тааруулж болох:** Дэлгэцийн сэргээх хурдыг автоматаар 120 Гц болгоод хөдөлгөөнт дүрс болон гүйлгэж буй дүрсийг өөгүй цэвэрхэн харна.
- **Стандарт:** Зайн цэнэгийг хэвийн хэмжээнд зарцуулахын тулд стандарт кадрын хурдыг хэрэглэнэ.

Дэлгэцийн горимыг өөрчлөх эсвэл дэлгэцийн өнгийг тааруулах

Таны сонгосноор дэлгэцийн горимыг өөрчлөх юм уу дэлгэцийн өнгийг тааруулна.

Дэлгэцийн горимыг өөрчлөх

Тохиргооны дэлгэц дээр **Дэлгэц** → **Дэлгэцийн горим** дээр товшоод хүссэн горимоо сонго.

- **Тод:** Дэлгэцийн өнгийн цараа, ханалт, хурцлагийг сайжруулна. Мөн өнгийн тэнцвэрийг өнгийн утгаар нь тохируулж болно.
- **Байгалийн:** Дэлгэцийг байгалийн өнгөөр тааруулна.




- Дэлгэцийн өнгийг зөвхөн **Тод** горимд тааруулж болно.
- **Тод** горим нь гуравдагч хэрэглүүрүүдэд нийцэхгүй байж болзошгүй.

Дэлгэц дүүрэн горимд өнгийн тэнцвэрийг тохируулах

Таны сонгосноор өнгийн тоныг тааруулж дэлгэцийн өнгийг тохируулна.

Тохиргооны дэлгэц дээр **Дэлгэц** → **Дэлгэцийн горим** → **Тод** дээр товшоод **Цагааны тэнцвэр** дотор өнгө тааруулах мөрийг тааруул.

Өнгийн тохируулгын хөндлийг **Сэрүүн** чигт чирвэл хөх өнгийн тон нэмэгдэнэ. Хөндлийг **Дулаан** чигт чирвэл улаан өнгийн тон нэмэгдэнэ.



Дэлгэцийн тоныг өнгийн утгаар тааруулах

Улаан, ногоон, цэнхэр утгыг тус бүрд нь өөрчилж сонгосон өнгийн тоныг ихэсгэх юм уу багасгана.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Дэлгэц** → **Дэлгэцийн горим** → **Тод** дээр товш.
- 2 **Нарийвчилсан тохиргоо** дээр товш.
- 3 **УЛН** (Улаан), **НОГ** (Ногоон), **ХӨХ** (Цэнхэр) өнгийн хөндлийг өөрийн сонгосноор тааруул. Дэлгэцийн тон өөрчлөгдөнө.

Дэлгэцийн зураг ба хэв маяг

Үндсэн дэлгэцийн болон түгжих дэлгэцийн зургийн тохиргоог өөрчил.

Тохиргооны дэлгэц дээр, **Дэлгэцийн зураг ба хэв маяг** дээр товш.

Загвар

Төхөөрөмжийн Үндсэн дэлгэц, түгжээтэй дэлгэц, дүрс зэрэгт төрөл бүрийн загвар оруулна.

Тохиргооны дэлгэц дээр **Загвар** дээр товш.

Эхлэл дэлгэц

Үндсэн дэлгэцийн тохиргоог тааруулна, жишээ нь дэлгэцийн зураглал.

Тохиргооны дэлгэц дээр **Эхлэл дэлгэц** дээр товш.

Түгжих дэлгэц

Сонголт

Түгжигдсэн дэлгэцийн тохиргоог өөрчил.

Тохиргооны дэлгэц дээр **Түгжих дэлгэц** дээр товш.

- **Дэлгэцийн түгжээний төрөл:** Дэлгэц түгжих аргыг өөрчилнө.
 - **Smart Lock:** Итгэлтэй байршилд очиход эсвэл төхөөрөмж илрэхэд төхөөрөмж өөрөө түгжээгээ тайлах эсэхийг тохируулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Smart Lock](#)-ээс авна уу.
 - **Хамгаалалтын түгжээний тохиргоо:** Сонгосон түгжих арга дахь дэлгэцийн түгжээний тохиргоог өөрчилнө.
 - **Always On Display:** Дэлгэц унтарсан үед дэлгэцэд харуулах мэдээллийг тохируулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Always On Display](#)-ээс авна уу.
 - **Дэлгэцийн зургийн үйлчилгээнүүд:** Төхөөрөмжид Динамик түгжих дэлгэц зэрэг дэлгэцийн зургийн үйлчилгээг ашиглахаар тохируулна.
 - **Цагийн хэв маяг:** Түгжих дэлгэц дээр гарах цагны өнгө, төрлийг өөрчилнө.
 - **Роуминг цаг:** Аялж явах үед түгжих дэлгэц дээр харуулах орон нутгийн болоод нутгийн цагийн бүсийг өөрчилнө.
 - **Тоноглолууд:** Түгжсэн дэлгэц дээр харуулах зүйлсийн тохиргоог өөрчил.
 - **Холбоо барих мэдээлэл:** Түгжих дэлгэц дээр харуулах таны цахим шуудангийн хаяг зэрэг холбоо барих мэдээллийг тохируулна.
 - **Мэдэгдлүүд:** Түгжээтэй дэлгэц дээр мэдэгдлийг хэрхэн харуулахыг тохируулна.
 - **Холбоос:** Түгжээтэй дэлгэц дээр холбоосыг нь харуулах хэрэглүүрүүдийг сонгоно.
 - **Түгжих дэлгэцийн тухай:** Түгжих дэлгэцийн хувилбар болон эрхзүйн мэдээллийг харна.
- 
- Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж болзошгүй.
 - Боломжит сонголтууд нь сонгосон дэлгэц түгжих функцээс хамааран янз бүр байж болно.

Smart Lock

Төхөөрөмж өөрөө түгжээг тайлахаар тохируулж, найдвартай байршил, төхөөрөмж илэрвэл түгжээгүй хэвээр байна.

Жишээ нь: Хэрэв та гэрийнхээ байршлыг найдвартай гэж тохируулсан бол гэртээ очиход тань төхөөрөмж байршлыг автоматаар таньж, түгжээгээ өөрөө тайлна.

Тохиргооны дэлгэц дээр **Түгжих дэлгэц** → **Smart Lock** товшоод дэлгэц дээрх зааврыг дагаж тохиргоог хийж гүйцэтгэнэ үү.



- Энэ функцийг дэлгэцийн түгжээ тохируулсны дараа хэрэглэх боломжтой.
- Хэрэв та төхөөрөмжөө 4 цаг хэрэглээгүй, дөнгөж асаасан бол дэлгэцийн түгжээг хээ, PIN, нууц үгийн аль тохируулснаар нээх ёстой.

Always On Display

Дэлгэц унтарсан үед цаг, цаглавар зэрэг мэдээллийг харж, хөгжим тоглуулагчийг удирдана.

Мөн шинэ зурвас, аваагүй дуудлагын мэдэгдлийг шалгаж болно.

Always On Display нь зөвхөн дэлгэц товшсон үед харагдахаар тохируулсан байна. Үүнийг байнга эсвэл тогтоосон цагт харуулахаар өөрчлөхийн тулд Тохиргооны дэлгэц дээр **Түгжих дэлгэц** → **Always On Display** дээр товшоод хүссэн горимоо сонго.



Орчны гэрэлтүүлгээс хамааран Always On Display-ний цайралт автоматаар өөрчлөгдөж болно.

Always On Display дээр мэдэгдэл нээх

Зурвас хүлээн авсан, дуудлага аваагүй, хэрэглүүрээс мэдэгдэл ирэхэд Always On Display дээр мэдэгдлийн дүрс гарч ирнэ. Мэдэгдлийн дүрсийг давхар товшоод мэдэгдлийг уншина.



Дэлгэц түгжээтэй бол мэдэгдлийг уншихын тулд түгжээг тайлах ёстой.

Always On Display функцийг идэвхгүй болгох

Мэдэгдлийн самбарыг нээгээд, доош шударч,  (**Always On Display**) дээр товшоод идэвхгүй болго. Хэрэв та түргэн самбараас  (**Always On Display**)-г олж чадаагүй бол  дээр товшиж, товчийг чирээд нэмнэ үү.

Эсвэл Тохиргооны дэлгэц дээр **Түгжих дэлгэц** дээр товшиж, дараа нь **Always On Display** сэлгүүрийг товшиж идэвхгүй болгоно.

Биометрик ба хамгаалалт

Сонголт

Төхөөрөмжийг хамгаалах тохиргоог өөрчил.

Тохиргооны дэлгэц дээр **Биометрик ба хамгаалалт** дээр товш.

- **Нүүр танилт:** Нүүрээ таниулаад дэлгэцийн түгжээг тайлахаар төхөөрөмжийг тохируулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Нүүр таних](#)-ээс авна уу.
- **Хурууны хээ:** Дэлгэцийн түгжээ тайлах хурууны хээг бүртгэнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Хурууны хээ таних](#)-ээс авна уу.
- **Илүү их биометрик тохиргоо:** Биометрийн өгөгдлийн тохиргоонуудыг өөрчил. Та мөн биометр хамгаалалтын шинэчлэлтийн хувилбарыг харж, шинэчлэлтийг шалгаж болно.
- **Google Play Protect:** Хор хөнөөлтэй хэрэглүүр, үйлдлийг шалгаж, болзошгүй аюулыг анхааруулж, устгах эсэхийг тохируулна.
- **Аюулгүй байдлын шинэчлэлт:** Төхөөрөмжийн программ хангамжийн хувилбарыг харж, шинэчлэлт гарсан эсэхийг шалгана.
- **Find My Mobile:** "Миний утсыг ол" функцийг идэвхжүүлж, идэвхгүй болгоно. Миний утсыг ол вэб сайт руу (findmymobile.samsung.com) орж гээсэн, хулгайд алдсан утсыг хайж, хянана.
- **Samsung Pass:** Биометр мэдээллээр өөрийгөө хялбархан, аюулгүй таниулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Samsung Pass](#)-ээс авна уу.
- **Нууцлалтай Хавтас:** Хувийн агуулга мэдээлэл, хэрэглүүрийг бусдаас хамгаалж нууцалсан хавтас үүсгэнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Нууцлалтай Хавтас](#)-ээс авна уу.
- **Найдвартай Wi-Fi:** Хамгаалалтгүй Wi-Fi сүлжээ ашиглах үед таны мэдээллийг хамгаалахаар төхөөрөмжийг тохируулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Найдвартай Wi-Fi](#)-ээс авна уу.
- **Private Share:** Бусадтай файл хуваалцахдаа блокчэйн технологи ашиглан нууцалж дамжуулна.
- **Samsung Blockchain Keystore:** Таны блокчэйний хувийн түлхүүрийг аюулгүй хадгална.
- **Үл таних хэрэглүүр суурилуулах:** Төхөөрөмж үл мэдэгдэх эх үүсвэрээс хэрэглүүр суурилуулахыг зөвшөөрнө.
- **SD картыг шифрлэх буюу тайлах:** Төхөөрөмж санах ойн картан дээрх файлуудыг шифрлэхээр тохируулна.



Хэрэв энэ тохиргоог идэвхжүүлсэн байхад төхөөрөмжийн үйлдвэрийн өгөгдмөл тохиргоог сэргээвэл төхөөрөмж шифрлэсэн картыг унших боломжгүй болно. Төхөөрөмжийн үйлдвэрийн өгөгдмөл тохиргоог сэргээхээс өмнө энэ тохиргоог идэвхгүй болго.

- **Бусад хамгаалалтын тохиргоо:** Хамгаалалтын нэмэлт тохиргоог тохируулна.



Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж болзошгүй.

Samsung Pass

Биометрийн өгөгдлөө Samsung Pass -д бүртгүүлж нэвтрэн орох буюу хувийн мэдээлэл шаарддаг үйлчилгээг хэрэглэхдээ өөрийн таних дугаарыг хялбар баталгаажуул.



- Вэб сайтад нэвтрэх функц нь зөвхөн **Интернэт** хэрэглүүрээр нэвтрэх байгаа вэб сайтуудад ажиллана. Зарим вэб сайт энэ функцэд тохирохгүй байж болзошгүй.
- Бүртгэгдсэн биометрийн өгөгдөл нь зөвхөн таны төхөөрөмжинд хадгалагдах бөгөөд бусад сервер төхөөрөмж рүү синхрончлогдохгүй.

Samsung Pass-д бүртгүүлэх

Samsung Pass-г хэрэглэхийн өмнө биометр мэдээллээ Samsung Pass-д бүртгэнэ үү.

Тохиргооны дэлгэц дээр **Биометрик ба хамгаалалт** → **Samsung Pass** дээр товш. Дэлгэц дээрх зааврыг дагаж тохиргоог дуусгана уу.

Samsung бүртгэлийн нууц үгийг шалгах

Samsung бүртгэлийн нууц үгээ оруулахын оронд бүртгэсэн биометр мэдээллээрээ өөрийгөө таниулж болно. Жишээ нь: **Galaxy Store**-оос контент худалдан авч болно.

Samsung Pass-н үндсэн дэлгэц дээр **☰** → **Тохиргоо** → **Бүртгэл ба синхрончлох** дээр товшиж, **Samsung Pass-тай баталгаажуулах** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Samsung Pass-аар вэб сайтад нэвтрэх

Samsung Pass-ыг хэрэглэн ID, нууц үгийг автоматаар бөглөхийг зөвшөөрдөг вэб сайтуудад хялбархан нэвтрэх болно.

- 1 Нэвтрэх гэж буй вэб сайтны хуудсан дээрээ ID ба нууц үгээ оруулаад вэб сайтын нэвтрэх товчийг товш.
- 2 Танаас нэвтрэх мэдээллээ хадгалах эсэхийг асуусан попап цонх гарч ирвэл **Samsung Pass-аар нэвтрэх**-ийг сонгож, **Санах** дээр товш.

Хэрэглүүрт нэвтрэхдээ Samsung Pass хэрэглэх

Samsung Pass-ыг хэрэглэн ID, нууц үгийг автоматаар бөглөхийг зөвшөөрдөг хэрэглүүрт хялбархан нэвтрэх болно.

- 1 Нэвтрэх гэж буй хэрэглүүрийн хуудсан дээрээ ID ба нууц үгээ оруулаад хэрэглүүрийн нэвтрэх товчийг товш.
- 2 Танаас нэвтрэх мэдээллээ хадгалах эсэхийг асуусан попап цонх гарч ирвэл **Хадгалах** дээр товш.

Нэвтрэх мэдээллийг удирдах

Samsung Pass-ыг хэрэглэхээр тохируулсан вэб сайт, хэрэглүүрийн жагсаалтыг харж, нэвтрэх мэдээллийг удирдана.

- 1 Samsung Pass-н үндсэн дэлгэц дээрээс **Хэрэглүүр** ба **Вэб сайтууд** дээр товшоод жагсаалтаас вэб сайт эсвэл хэрэглүүрийг сонгоно уу.
- 2 **Засварлах** дээр товшоод ID, нууц үг, вэб сайтын эсвэл хэрэглүүрийн нэрийг өөрчил.
Нэвтрэх мэдээллээ устгахын тулд нэвтрэх **Устгах** дээр товш.

Вэб сайт, хэрэглүүрт Samsung Pass хэрэглэх

Samsung Pass-д нийцсэн вэб сайт, хэрэглүүрийг ашиглахдаа Samsung Pass-аар хялбархан нэвтэрч болно.

Samsung Pass нууц үгийг дэмждэг вэбсайт болон аппликейшнуудын жагсаалтыг харахын тулд, Samsung Pass -ийн үндсэн дэлгэц дээр **☰** → **Тохиргоо** → **Түншүүд** гэж товш. Samsung Pass-д нийцсэн вэб сайт, хэрэглүүр байхгүй бол **Түншүүд** харагдахгүй.



- Үйлчилгээ үзүүлэгч эсвэл загвараас хамаараад ашиглах боломжтой вэб сайт, хэрэглүүрүүд янз бүр байж болно.
- Вэб сайт, хэрэглүүрт Samsung Pass-аар нэвтрэн орсноос үүдэн гарах асуудал, учирсан хохиролд Samsung хариуцлага хүлээхгүй.

Хувийн мэдээллээ автоматаар оруулах

Та хувийн мэдээллийг автоматаар бөглөхийг зөвшөөрдөг хэрэглүүрт өөрийн хаяг, төлбөрийн карт зэрэг хувийн мэдээллээ Samsung Pass-аар оруулж болно.

- 1 Samsung Pass үндсэн дэлгэцээс **Хувийн мэдээлэл**-ийн доор байгаа сонголтыг сонгоно уу.
- 2 Мэдээллийг оруулаад **Хадгалах** дээр товш.
Та одоо тохирох хэрэглүүрүүдэд хувийн мэдээллээ автоматаар оруулахдаа Samsung Pass-д бүртгэсэн биометр мэдээллээ хэрэглэж болно.

Samsung Pass-д буй мэдээллийг устгах

Samsung Pass-д бүртгэсэн биометр мэдээлэл, нэвтрэх мэдээлэл, хэрэглүүрийн өгөгдлүүдийг устгаж болно.

Samsung Pass үндсэн дэлгэц дээр,  дээр товшоод → **Тохиргоо** → **Samsung Pass-г ашиглан бүх төхөөрөмжүүдийг харах** →  → **Samsung Pass-с гарах** дээр товш.



- Таны Samsung бүртгэл идэвхтэй үлдэнэ.
- Түүнчилэн бусад төхөөрөмж дээр Samsung бүртгэлдээ нэвтэрсэн таны Samsung Pass дата өгөгдөл усгагдах болно.

Нууцлалтай Хавтас

Нууцалсан хавтас нь таны хувийн агуулга болох гэрэл зураг, харилцагч, хэрэглүүрт бусад этгээд хандахаас хамгаална. Төхөөрөмж түгжээгүй байсан ч хувийн агуулга, хэрэглүүрийг нууцалж болно.



Нууцалсан хавтас бол санах ой дахь бие даасан, хамгаалалтай хэсэг юм. Нууцалсан хавтсанд буй мэдээллийг USB, Wi-Fi Direct зэрэг зөвшөөрөөгүй хуваалцах аргаар бусад төхөөрөмж рүү дамжуулах боломжгүй. Үйлдлийн систем болон программ хангамжийг өөрчлөхийг оролдох нь Нууцалсан хавтсыг автоматаар түгжиж, хандах аргагүй болгоно. Нууцалсан хавтсанд мэдээллээ хадгалахаас өмнө өөр аюулгүй газар нөөцлөн хуулбарлавал зохино.

Нууцалсан хавтсыг тохируулах

1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Биометрик ба хамгаалалт** → **Нууцлалтай Хавтас** дээр товш.

2 Дэлгэц дээрх зааврыг дагаж тохиргоог дуусгана уу.

Нууцалсан хавтас дэлгэц гарч ирэх ба Нууцалсан хавтас хэрэглүүрийн дүрс (🔒) Хэрэглүүрийн дэлгэц дээр нэмэгдэнэ.

Нууцалсан Хавтасын нэр эсвэл шигтгээ зургийг өөрчлөхдөө, ⋮ → **Тусгайлан тохируулах** дээр товш.



- **Нууцлалтай Хавтас** хэрэглүүрийг нээх үед та хэрэглүүрийг урьдчилан тохируулсан түгжих аргаар нээх ёстой.
- Хэрэв Нууцалсан хавтасны түгжээ нээх кодыг мартсан бол үүнийгээ Samsung бүртгэлээр шинээр тохируулж болно. Түгжээтэй дэлгэцийн доод талд буй товчийг товшоод Samsung бүртгэлийн нууц үгийг оруул.

Нууцалсан хавтасны автомат түгжээний нөхцөлийг тохируулах

1 **Нууцлалтай Хавтас** хэрэглүүрийг нээгээд ⋮ → **Тохиргоо** → **Найдвартай Хавтсыг авто. түгжих** дээр товш.

2 Түгжих аргыг сонго.



Нууцалсан хавтсыг гараар түгжихийн тулд ⋮ → **Түгжиж, гарах** дээр товш.

Нууцалсан хавтас руу агуулга зөөх

Нууцалсан хавтас руу гэрэл зураг, видео зэрэг контентыг зөөнө. Ердийн санах ойгоос Нууцалсан хавтас руу зураг зөөж буй жишээг доор үзүүлэв.

1 **Нууцлалтай Хавтас** аппликейшныг ачааллаад ⋮ → **Файл нэм** дээр товшино уу.

2 **Зурагнууд** дээр товшиж, зөөх зургуудыг тэмдэглээд **Хийсэн** дээр товш.

3 **Зөөх** дээр товш.

Сонгосон зүйлсийг эх хавтаснаас устгаж, Нууцалсан хавтас руу зөөнө. Хуулахын тулд **Хуул** дээр товш.



Агуулга зөөх арга нь агуулгын төрлөөс хамааран янз бүр байж болно.

Нууцалсан хавтаснаас агуулга зөөх

Нууцалсан хавтаснаас агуулгыг ердийн санах ой дахь харгалзах хэрэглүүр лүү зөөнө. Ердийн санах ой руу Нууцалсан хавтаснаас зураг зөөж буй жишээг доор үзүүлэв.

- 1 **Нууцлалтай Хавтас** хэрэглүүрийг нээгээд **Галерей** дээр товш.
- 2 Зургаа сонгоод **⋮** → **Нууцлалтай Хавтас-с гаргах** дээр товш.
Сонгосон зүйлсийг ердийн санах ой дахь **Галерей** руу зөөнө.

Хэрэглүүр нэмэх

Нууцалсан хавтсанд хэрэглүүр нэмж хэрэглэнэ.

- 1 **Нууцлалтай Хавтас** хэрэглүүрийг ажиллуулаад **+** товшино уу.
- 2 Төхөөрөмж дээр суурилсан хэрэглүүрүүдээс сонгож тэмдэг тавиад **Нэмэх** дээр товш.

Нууцалсан хавтаснаас хэрэглүүрийг устгах

Устгахыг хүссэн хэрэглүүрээ товшоод удаан дараад **Устгах** дээр товш.

Хэрэглэгчийн данс нэмэх

Нууцалсан хавтсан дахь хэрэглүүрүүдийг синхрончлоход хэрэглэх Samsung болон Google бүртгэл, юм уу өөр бүртгэл нэм.

- 1 **Нууцлалтай Хавтас** аппликейшныг ачааллаад **⋮** → **Тохиргоо** → **Бүртгэлүүд удирдах** → **Данс нэмэх** дээр товшино уу.
- 2 Бүртгэлийн үйлчилгээг сонго.
- 3 Дэлгэц дээрх зааврыг дагаж бүртгэлийн тохиргоог дуусгана уу.

Нууцалсан хавтсыг нуух

Хэрэглүүрийн дэлгэцээс Нууцалсан хавтас холбоосыг нууж болно.

Нууцлалтай Хавтас хэрэглүүрийг нээгээд  → **Тохиргоо** дээр товшиж, **Нууцлалтай Хавтас-г Хэрэглүүрийн дэлгэцэд нэм** сэлгүүрийг товшоод идэвхгүй болго.

Эсвэл мэдэгдлийн самбарыг нээгээд, доош шударч,  (**Найдвартай Хавтас**) дээр товшоод уг функцийг идэвхжүүл. Хэрэв та Түргэн Самбараас  (**Найдвартай Хавтас**) -г олж чадаагүй бол  дээр товшиж, товчийг чирээд нэмнэ үү.

Хэрэв та Нууцалсан хавтсыг дахин харуулахыг хүсвэл **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Биометрик ба хамгаалалт** → **Нууцлалтай Хавтас** дээр товшоод, **Нууцлалтай Хавтас-г Хэрэглүүрийн дэлгэцэд нэм** сэлгүүрийг товшиж үүнийг идэвхжүүл.

Нууцалсан хавтсыг устгах

Нууцалсан хавтсыг доторх агуулгатай нь устгаж болно.

Нууцлалтай Хавтас хэрэглүүрийг нээгээд  → **Тохиргоо** → **Илүү тохиргоо** → **Устгах** дээр товш.

Нууцалсан хавтсыг устгахаас өмнө агуулгыг нь нөөцлөхийн тулд **Медиа файлуудыг Найдвартай хавтаснаас зөө** дээр товшоод **Устгах** дээр товш. Нууцалсан хавтсанд нөөцөлсөн өгөгдөлд хандахдаа, **Миний файлууд** аппликейшныг ачаалж **Дотоод санах ой** → **Download** → **Secure Folder** гэж товш.



Samsung Notes хадгалсан тэмдэглэлүүдийг нөөцлөхгүй.

Найдвартай Wi-Fi

Хамгаалалттай Wi-Fi бол таны Wi-Fi сүлжээний холболтыг хамгаалдаг үйлчилгээ юм. Энэ үйлчилгээ нь Wi-Fi сүлжээгээр мэдээллийг шифрлэж, хянагч хэрэглүүр, вэб сайтуудыг идэвхгүй болгож, Wi-Fi сүлжээг аюулгүй болгоно. Жишээ нь кафе, нисэх буудал зэрэг олон нийтийн газар хамгаалалтгүй Wi-Fi сүлжээ хэрэглэж байгаа үед хамгаалалттай Wi-Fi автоматаар идэвхжих тул таны нэвтрэх мэдээллийг хэн ч хакердаж, таны хэрэглүүр, вэб сайтуудад хийсэн үйлдлийг хянаж чадахгүй.

Тохиргооны дэлгэц дээр **Биометрик ба хамгаалалт** → **Найдвартай Wi-Fi** товшиж, дэлгэц дээрх зааврыг дагаж, тохиргоог гүйцээнэ үү.

Хамгаалалттай Wi-Fi-г идэвхжүүлсэн бол төлөвийн мөрд  дүрс гарч ирнэ.



- Энэ функцийг ашигласнаар Wi-Fi сүлжээ удааширна.
- Wi-Fi сүлжээ, үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад энэ функцийг ашиглах боломжгүй байж болзошгүй.

Хамгаалалттай Wi-Fi сүлжээг ашиглан хамгаалах хэрэглүүрийг сонгох

Хамгаалалттай Wi-Fi сүлжээгээр хамгаалах хэрэглүүрийг сонгосноор та өөрийн нууц үг, программд хийсэн үйлдэл зэрэг хөндлөнгөөс мэдэж болох мэдээллээ аюулгүй нууцална.

Тохиргооны дэлгэц дээр **Биометрик ба хамгаалалт** → **Найдвартай Wi-Fi** → **Хамгаалагдсан хэрэглүүрүүд** рүү ороод Хамгаалалттай Wi-Fi-гаар хамгаалах хэрэглүүрүүдийн дэргэдэх сэлгүүрийг товш.



Зарим хэрэглүүрт энэ функц тохирохгүй.

Хамгаалалтын үйлчилгээ худалдан авах

Танд Wi-Fi сүлжээгээ хамгаалах үйлчилгээг сар бүр үнэ төлбөргүй үзүүлнэ. Та мөн хязгаарлагдмал хугацаанд хязгааргүй хамгаалалтаар хангах төлбөртэй хамгаалалтын үйлчилгээг худалдан авч болно.

1 Тохиргооны дэлгэц дээр **Биометрик ба хамгаалалт** → **Найдвартай Wi-Fi** дээр товш.

2 **Хамгаалалтын багц** → **Ахиулах** дээр товшоод хүссэн үйлчилгээгээ сонго.



Хамгаалалтын зарим үйлчилгээний хувьд та Samsung бүртгэлдээ нэвтэрсэн өөр төхөөрөмжид уг хамгаалалтын үйлчилгээг шилжүүлэн ашиглаж болно.

3 Дэлгэц дээрх зааврыг дагаж худалдан авна уу.

Нууцлал

Нууцлалын тохиргоог өөрчилнө.

Тохиргооны дэлгэц дээр **Нууцлал** дээр товш.

- **Сүүлийн 24 цагт ашигласан зөвшөөрлүүд:** Апликайшн эсвэл функцүүдийн хэрэглсэн зөвшөөрлийн түүхийг хар.
- **Зөвшөөрлийн менежер:** Эдгээрийг хэрэглэх зөвшөөрөлтэй функц, хэрэглүүрийг жагсаалтыг харна. Уг зөвшөөрлийн тохиргоог өөрчилж болно.
- **Удирдлагууд ба сануулгууд:** Апликайшн хандалтын тохиргоог хий.
- **Samsung:** Өөрийн Samsung бүртгэлтэй холбогдох хувийн мэдээллээ удирдаж, Тохируулан өөрчилсөн үйлчилгээний тохиргоог өөрчилнө.
- **Google:** Нууцлалын дэвшилтэт тохиргоог тохируулна.



Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж болзошгүй.

Байрлал

Байршлын мэдээллийн зөвшөөрлийг өөрчилнө.

Тохиргооны дэлгэц дээр **Байрлал** дээр товш.

- **Хэрэглүүрийн зөвшөөрлүүд:** Төхөөрөмжийн байршилд хандах зөвшөөрөлтэй хэрэглүүрүүдийн жагсаалтыг харна.
- **Байрлалын үйлчилгээнүүд:** Таны төхөөрөмжийн ашиглаж байгаа байршлын үйлчилгээг харна.
- **Сүүлийн хандалт:** Ямар аппликейшн таны одоогийн байршлыг мэдээлэл хүссэнийг хар.

Данснууд ба нөөцлөлт

Сонголт

Samsung Cloud хэрэглэн мэдээллээ синхрончилж, нөөцөлж, сэргээнэ. Та мөн Samsung бүртгэл, Google бүртгэл зэрэг бүртгэлдээ нэвтэрч эсвэл Smart Switch-ээр дамжуулан бусад төхөөрөмж рүү мэдээлэл дамжуулж, хүлээн авч болно.

Тохиргооны дэлгэц дээр **Данснууд ба нөөцлөлт** дээр товш.

- **Бүртгэлүүд удирдах:** Синхрончлоход хэрэглэх Samsung болон Google, эсвэл бусад бүртгэлийг нэмнэ.
- **Samsung Cloud:** Өөрийн мэдээлэл ба тохиргоог нөөцөлж, өмнөх төхөөрөмжийн мэдээлэл, тохиргоог одоо байхгүй ч сэргээж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг [Samsung Cloud](#)-ээс авна уу.
- **Google Drive:** Төхөөрөмж дээрх хувийн мэдээлэл, хэрэглүүрийн мэдээлэл, тохиргоог аюулгүй хадгална. Та нууц мэдээллээ нөөцөлж болно. Мэдээллийг нөөцлөхийн тулд та Google бүртгэлдээ нэвтрэх ёстой.
- **Smart Switch:** Smart Switch хэрэглүүрийг нээгээд өмнөх төхөөрөмжөөс мэдээллээ дамжуулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Өмнөх төхөөрөмжөөсөө мэдээлэл дамжуулах \(Smart Switch\)](#)-ээс авна уу.



Мэдээллээ Samsung Cloud юм уу компьютер зэрэг найдвартай газар тогтмол нөөцөлж байвал санамсаргүй шинээр тохируулах үйлдлийн улмаас мэдээлэл гэмтсэн, устсан бол сэргээх боломжтой.

Samsung Cloud

Төхөөрөмжийн мэдээллийг Samsung Cloud руу нөөцөлж, хожим сэргээж болно.

Дата нөөцлөх

Төхөөрөмжийн мэдээллийг Samsung Cloud руу нөөцөлж болно.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Данснууд ба нөөцлөлт** дээр дарж **Samsung Cloud** дор буй **Өгөгдлийг нөөцөл** дээр товшино уу.
- 2 Нөөцлөхийн хүссэн зүйлсийн хажууд байгаа сэлгүүр дээр товшоод **Одоо нөөцлөх** дээр товш.
- 3 **Болсон** дээр товш.
 - Зарим мэдээлэл нөөцлөгдөхгүй. Аль дата нөөцлөгдөхийг шалгахын тулд, Тохиргоо дэлгэц дээр, **Данснууд ба нөөцлөлт** дээр товшоод **Samsung Cloud** дор буй **Өгөгдлийг нөөцөл** дээр товшино уу.
 - Samsung Cloud-д байгаа бусад төхөөрөмжүүдийн нөөц датаг харахын тулд Тохиргооны дэлгэц дээр **Данснууд ба нөөцлөлт** → **Өгөгдөл сэргээх** -г товшоод дараа нь хүссэн төхөөрөмжөө сонгоно уу.

Дата сэргээх

Samsung Cloud-аас төхөөрөмж рүү нөөцөлсөн мэдээллээ сэргээж болно.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Данснууд ба нөөцлөлт** дээр товш.
- 2 **Өгөгдөл сэргээх** дээр товшиж, хүссэн төхөөрөмжөө сонго.
- 3 Сэргээхийг хүсэж буй зүйлс дээр тэмдэг тавиад **Сэргээх** дээр товш.

Google

Google-ийн зарим функцийн тохиргоог тааруулна.

Тохиргооны дэлгэц дээр **Google** дээр товш.

Дэвшилтэт функц

Сонголт

Дэвшилтэт функцүүдийг идэвхжүүлээд, тэдгээрийг хянах тохиргоог өөрчилнө.

Тохиргооны дэлгэц дээр **Дэвшилтэт функц** дээр товш.

- **Windows-н холбоос:** Төхөөрөмж дээрээ хадгалсан мэдээллийг компьютер дээрээ ашиглана. Дэлгэрэнгүй мэдээллийг [Windows-н холбоос](#)-ээс авна уу.
- **Дуудлага ба текст бусад төхөөрөмжүүдэд:** Төхөөрөмжийн дуудлага ба зурвас дамжуулах функцийг Samsung бүртгэлээр нэвтэрсэн бусад төхөөрөмж дээр ашиглана.
- **Бусад төхөөрөмжүүдэд хэрэглүүрүүд үргэлжлүүлэх:** Ашиглаж байсан хэрэглүүрээ Samsung бүртгэлээр нэвтэрсэн бусад төхөөрөмж дээр ашиглана.
- **Samsung DeX:** Төхөөрөмжийг компьютер шиг хэрэглэхээр тохируул. Дэлгэрэнгүй мэдээллийг [Samsung DeX](#)-ээс авна уу.
- **Android Авто:** Төхөөрөмжөө тээврийн хэрэгсэлд холбож, төхөөрөмжийн зарим онцлогийг тээврийн хэрэгслийн дэлгэц дээр хянах боломжтой.
- **Түргэн хуваалцах:** Түргэн хуваалцахын тохиргоог өөрчилнө үү. Дэлгэрэнгүй мэдээллийг [Түргэн хуваалцах](#)-ээс авна уу.
- **Лабууд:** Төхөөрөмжийн шинэ онцлогийг ашиглана.
- **S Pen:** S Pen хэрэглэх тохиргоог өөрчилнө. Дэлгэрэнгүй мэдээллийг [S Pen](#)-ээс авна уу.
- **Хажуу товч:** Хажуугийн товчоор нээх хэрэглүүр буюу функцийг сонгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг [Хажуугийн товчны тохиргоо](#)-ээс авна уу.
- **Хөдөлгөөн ба дохио:** Хөдөлгөөний функцийг идэвхжүүлж, тохиргоог тааруулна. Дэлгэрэнгүй мэдээллийг [Хөдөлгөөн ба дохио](#)-ээс авна уу.
- **Нэг гарын горим:** Төхөөрөмжийг зөвхөн нэг гараар хэрэглэхэд зориулсан ажлын горимыг идэвхжүүлнэ.
- **Bixby Routines:** Таны тодорхой давтамжтайгаар хэрэглэж байгаа тохиргоог автоматжуулсан хэвшмэл үйлдлүүдийг нэмнэ. Төхөөрөмж мөн танд давтагдаж буй нөхцөлд тохируулан хэрэгтэй хэвшил санал болгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг [Bixby Routines](#)-ээс авна уу.
- **Дэлгэцийн зураг, дэлгэцийн бичлэг хийгч:** Дэлгэцийн зураг ба дэлгэцийн бичлэгийн тохиргоог өөрчилнө.
- **Контент хуваалцах үед харилцагчид харуулах:** Төхөөрөмжийн хуваалцах сонголтын самбар дээр агуулгаа шууд хуваалцахыг зөвшөөрсөн харилцагчдыг харуулна.

- **Видео дуудлагын эффектүүд:** Видео дуудлагын үеэр дэвсгэрийг өөрчлөх эсвэл дэвсгэрийн чимээг хаах функцийг ашиглахаар тохируулна.
 -  Энэ функцийг зөвхөн зарим хэрэглүүрт хэрэглэж болно.
 - Загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж магадгүй.
- **Game Launcher:** Game Launcher хэрэглүүрийг идэвхжүүлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Game Launcher](#)-ээс авна уу.
- **Видеоны цайралт:** Илүү тод өнгөөр үзэхийн тулд видео дүрснийхээ чанарыг сайжруулна уу.
 -  Зарим хэрэглүүрт энэ функцийг хэрэглэх боломжгүй байж магадгүй.
- **Хос Мессенжер:** Хоёр дахь хэрэглүүрийг суурилуулаад, зурвас дамжуулах нэг хэрэглүүрт хоёр өөр бүртгэл хэрэглэнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг [Хос Мессенжер](#)-ээс авна уу.
-  Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж болзошгүй.

Хөдөлгөөн ба дохио

Хөдөлгөөн ба дохио зангааны функцийг идэвхжүүлж, тохиргоог тааруулна.

Тохиргооны дэлгэц дээр **Дэвшилтэт функц** → **Хөдөлгөөн ба дохио** дээр товшино уу.

- **Авахад сэрээх:** Төхөөрөмжийг дээш өргөхөд дэлгэцийг асаах эсэхийг тохируулна.
- **Хоёр товшиж дэлгэцийг асаах:** Төхөөрөмжийг дэлгэцийн аль ч хэсэгт давхар товшоод дэлгэцийг асаах эсэхийг тохируулна.
- **Хоёр товшиж дэлгэцийг унтраах:** Үндсэн дэлгэц эсвэл түгжигдсэн дэлгэц дээрх хоосон хэсгийг давхар товшиж дэлгэцийг унтрааж байхаар төхөөрөмжийг тохируулна.
- **Үзэх үед дэлгэцэ асалттай байлг:** Таныг дэлгэц рүү харж байхад дэлгэц унтрахаас сэргийлэх эсэхийг төхөөрөмжид тохируулна.
- **Утсыг авахад анхааруулах:** Гар утсыг авахад аваагүй дуудлага эсвэл шинэ зурвас ирснийг мэдэгдэх дохиог өгч байхаар тохируулна.
 -  Энэ функц дэлгэц ассан, төхөөрөмж хавтгай гадаргуу дээр байрлаагүй үед ажиллахгүй байж болно.
- **Дохиогоор дуу хаах:** Хөдөлгөөнөөр эсвэл дохио зангаагаар зарим дуу чимээг унтраахаар төхөөрөмжийг тохируулна.
- **Зураг авахад алгаар шудар:** Гарын алгаар зүүн, баруун тийш шударч дэлгэцийн зураг авах эсэхийг тохируулна. Авсан зургийг **Галерей** харна. Зарим хэрэглүүр, функцийг хэрэглэж байхад дэлгэцийн зураг авах боломжгүй.
-  Төхөөрөмжийг хэт сэгсрэх, доргиосны улмаас мэдрэгчээр дамжин зарим функцэд санамсаргүй оролт үүсэж болзошгүй.

Хос Мессенжер

Хоёр дахь хэрэглүүрийг суурилуулаад, зурвас дамжуулах нэг хэрэглүүрт хоёр өөр бүртгэл хэрэглэнэ.

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Дэвшилтэт функц** → **Хос Мессенжер** дээр товш.
Тохирох хэрэглүүрүүд гарч ирнэ.
- 2 Хэрэглүүрийн сэлгүүрийг товшоод хоёр дахь хэрэглүүрийг суурилуул.
Хоёр дахь хэрэглүүр суурилна. Хоёр дахь хэрэглүүрийн дүрсийг  дүрстэй харуулна.



-  • Хос зурвас функцийг зарим хэрэглүүрт хэрэглэх боломжгүй байж магадгүй.
- Уг хэрэглүүрийн зарим функц хоёр дахь хэрэглүүрээс хамааран хязгаарлагдаж болзошгүй.

Хоёр дахь хэрэглүүрийг устгах

- 1 Тохиргооны дэлгэц дээр **Дэвшилтэт функц** → **Хос Мессенжер** дээр товш.
- 2 Устгах гэж буй хэрэглүүрийн сэлгүүрийг товшоод **Устгах** дээр товш.
Хоёр дахь хэрэглүүрт хамаарах бүх мэдээллийг устгана.

-  Эхний хэрэглүүрийг устгавал хоёр дахь хэрэглүүрийг мөн устгана.

Digital Wellbeing ба эцэг эхийн хяналт

Төхөөрөмжийнхөө ашиглалтын түүхийг харж, төхөөрөмж таны амьдралд нөлөөлөхөөс сэргийлэн функцүүдийг ашиглаарай. Та мөн хүүхдүүддээ зориулан эцэг эхийн хяналтыг тохируулж, тэдний цахим хэрэглээг удирдаж болно.

Тохиргооны дэлгэц дээр **Digital Wellbeing ба эцэг эхийн хяналт** дээр товш.

- **Дэлгэцийн хугацаа:** Төхөөрөмжийг өдөрт хэрэглэх зорилтыг тохируулна.
- **Хэрэглүүрийн таймер:** Хэрэглүүр бүрд цагийн тоолуур тохируулаад, өдрийн хэрэглээг хязгаарлаж болно. Заасан хязгаарт хүрмэгц хэрэглүүр идэвхгүй болж, хэрэглэх боломжгүй болно.
- **Төвлөрөх горим:** Та анхаарал төвлөрөх горимыг идэвхжүүлж төхөөрөмжөөс анхаарал сарниулж буй зүйлсээс зайлсхийж, хүссэн зүйлдээ төвлөрч болно. Анхаарын горимд ашиглахыг зөвшөөрсөн хэрэглүүрүүдээ хэрэглэж болно.
- **Унтах цагийн горим:** Та амрах, унтахын өмнө нүдний ачааллаа багасгах, нойрсоход садаа болохоос сэргийлэн унтах цагийн горимыг идэвхжүүлж болно.
- **Дууны түвшин хянагч:** Таны сонсголтыг хамгаалахын тулд дууны түвшний монитормыг идэвхжүүлнэ.
- **Жолооны хяналт:** Төхөөрөмжөө хэрэглэж байхдаа машины жолоодсон цагаа хянахын тулд жолоодлогын удирдлагыг идэвхжүүл.
- **Эцэг эхийн хяналт:** Таны хүүхдийн цахим хэрэглээг удирдана.

Зай ба төхөөрөмжийн тусламж

Танилцуулга

"Төхөөрөмжийн арчилгаа" функц нь төхөөрөмжийн батарей, санах ой, шуурхай санах ой, системийн аюулгүй байдлын төлөвийг бүхэлд нь харах боломж олгоно. Та нэг товшилтоор л төхөөрөмжийг ажиллагааг сайжруулах боломжтой.

Төхөөрөмжийг сайжруулах

Тохиргооны дэлгэц дээр **Зай ба төхөөрөмжийн тусламж** → **Одоо оновчил** дээр товшно уу.

Шуурхай сайжруулах функц нь дараах үйлдлүүдээр төхөөрөмжийн ажиллагааг сайжруулна.

- Далд ажиллаж буй хэрэглүүрүүдийг хаах.
- Батарейн хэвийн бус зарцуулалтыг хянах.
- Гэмтсэн хэрэглүүр, хортон байгаа эсэхийг шалгах.

Автоматаар сайжруулах функцийг сайжруулах

Та төхөөрөмжийг хэрэглээгүй байх үедээ автоматаар сайжруулах үйлдлийг гүйцэтгэхээр тохируулж болно.  → **Автоматжуулалт** → **Өдөр болгон авто оновчлох** дээр товшиж сэлгүүр дээр дарж үүнийг идэвхжүүл. Автоматаар сайжруулах цагийг тохируулахдаа **Time** дээр товш.

Зай

Батарейнд үлдсэн цэнэг, төхөөрөмжийг хэрэглэх хугацааг шалгана. Батарейн түвшин багассан төхөөрөмжид тэжээл хэмнэх функцийг идэвхжүүлж, зайны цэнэгийг хэмнэнэ.

Тохиргооны дэлгэц дээр **Зай ба төхөөрөмжийн тусламж** → **Зай** дээр товш.

- **Тэжээл хэмнэх:** Эрчим хүч хэмнэх төлөвийг идэвхжүүлж зайны ажиллах хугацааг уртасга.
- **Далд хэрэглээний хязгаар:** Байнга хэрэглэдэггүй хэрэглүүрийн зайн зарцуулалтын хэрэглээг хязгаарлана.
- **Утасгүй тэжээл хуваалцах:** Өөрийн төхөөрөмжийнхөө зайгаар өөр төхөөрөмж цэнэглэх. Дэлгэрэнгүй мэдээллийг **Утасгүй тэжээл хуваалцах**-ээс авна уу.
- **Илүү их зайн тохиргоо:** Зайнд зориулсан нарийвчилсан тохиргоог хий.



- Хэрэглэх хугацаа нь зайн цэнэг дуусах хүртэл хэр хугацаа үлдсэнийг заана. Хэрэглэх хугацаа нь таны төхөөрөмжийн тохиргоо, ажиллагааны нөхцөлөөс хамаарна.
- Та тэжээл хэмнэх горимд буй зарим хэрэглүүрээс мэдэгдэл хүлээн авахгүй байж болно.

Санах байгууламж

Санах ойн багтаамжийн ашиглаж буй, боломжит зайн хэмжээг шалгана.

Тохиргооны дэлгэц дээр **Зай ба төхөөрөмжийн тусламж** → **Санах байгууламж** дээр товш. Дахин ашиглахгүй аппликэйшнүүд болон файлуудаа устгахын тулд ангиллыг сонгоно уу. Дараа нь удаан дарж эсвэл зүйлийг сонгоод **Устгах** эсвэл **Устгах** дээр товш.



- Үйлдлийн систем болон өгөгдмөл хэрэглүүрүүд санах ойн тодорхой хэсгийг эзэлдэг тул дотоод санах ойн боломжит зай нь заасан багтаамжаас бага байдаг. Төхөөрөмжийг сайжруулахад уг боломжит сул зай өөрчлөгдөж болно.
- Та Samsung-ийн вэб сайтаас уг төхөөрөмжийн үзүүлэлт хэсгээс дотоод санах ойн боломжит зайг харж болно.

RAM

Тохиргооны дэлгэц дээр **Зай ба төхөөрөмжийн тусламж** → **RAM** дээр товш.

Далд ажиллаж буй хэрэглүүрүүдийг зогсоож төхөөрөмжийн хурдыг нэмэгдүүлэхийн тулд **Чөлөөлөх** дээр товш.

Төхөөрөмжийн хамгаалалт

Төхөөрөмжийн аюулгүй байдлын төлөвийг шалгана. Энэ функц нь төхөөрөмжид хортон халдсан эсэхийг шалгана.

Тохиргооны дэлгэц дээр **Зай ба төхөөрөмжийн тусламж** → **Төхөөрөмжийн хамгаалалт** → **Утсыг шалгах** дээр товш.

Хэрэглүүр

Төхөөрөмжийн хэрэглүүрийг удирдаж, тохиргоог нь өөрчилнө. Хэрэглүүрийн ашиглалтын мэдээллийг харж, мэдэгдэл болон зөвшөөрлийн тохиргоог өөрчилж, эсвэл хэрэгцээгүй хэрэглүүрүүдийг устгаж эсвэл идэвхгүй болгож болно.

Тохиргооны дэлгэц дээр **Хэрэглүүр** дээр товш.

Ерөнхий удирдлага

Төхөөрөмжийн системийн тохироог өөрчилж эсвэл төхөөрөмжийг шинээр тохируулна.

Тохиргооны дэлгэц дээр **Ерөнхий удирдлага** дээр товш.

- **Хэл:** Төхөөрөмжийн хэл сонгох. Дэлгэрэнгүй мэдээллийг [Төхөөрөмжид хэл нэмэх](#)-ээс авна уу.
- **Бичвэрийг яриа болгох:** TalkBack идэвхжүүлсэн үед, Бичвэрийг яриа болгон хөрвүүлэх функцийг хэл, хурд зэрэг тохиргоог өөрчилнө.
- **Огноо болон цаг:** Төхөөрөмж цагийг хэрхэн харуулах тохиргоог харж, өөрчилнө.
 Хэрэв батарей бүрэн цэнэггүй болсон бол огноо, цагийг шинээр тохируулна.
- **Samsung товчлуур-н тохиргоо:** Тохиргоог Samsung товчлуурт гарт шилжүүл.
- **Гарын жагсаалт ба өгөгдмөл:** Товчлуурт гарыг үндсэн ашиглах болгон сонгож, товчлуурт гарын тохиргоог өөрчилнө.
- **Биет гар:** Тохиргоог нэмэлт нэг товчлуурт гарт өөрчил.
- **Хулгана ба тэмтрэх хавтан:** Тохиргоог нэмэлт хулгана ба мэдрэгч хавтанд зориулж өөрчил.
- **Нууц үгүүд ба автоматаар бөглөх:** Автоматаар бөглөх үйлчилгээг ашиглахаар сонгох.
- **Дахин тохируулах:** Төхөөрөмжийн тохиргоог шинээр тохируулах эсвэл үйлдвэрийн тохиргоог сэргээнэ.
- **Тохируулгын үйлчилгээ:** Таны сонирхол, төхөөрөмжийг хэрэглэж байгаа хэвшинжид тулгуурлан тохируулан өөрчилсөн үйлчилгээ авахаар тохируулна.
- **Бидэнтэй холбоо барих:** Асуулт асуух буюу асуулт, хариултыг харуулна.

Төхөөрөмжид хэл нэмэх

Та төхөөрөмжид хэрэглэх хэлийг нэмж болно.

- 1 Тохиргооны дэлгэц дээр, **Ерөнхий удирдлага** → **Хэл** → **Хэл нэмэх** дээр товш.
Нэмж болох хэлүүдийг харахдаа  → **Бүх хэл** дээр товш.
- 2 Нэмэхийг хүссэн хэлээ сонго.
- 3 Сонгосон хэлийг өгөгдмөл хэл болгон тохируулахдаа **Өгөгдмөл болгох** дээр товш. Одоо хэрэглэж байгаа хэлний тохиргоог өөрчлөхгүй бол **Хэвээр хадгал** дээр товш.
Сонгосон хэлийг таны хэлний жагсаалтад нэмнэ. Хэрэв өгөгдмөл хэлийг өөрчилсөн бол сонгосон хэлийг жагсаалтын дээд талд оруулна.

Хэлний жагсаалтаас өгөгдмөл хэлийг өөрчлөхийн тулд хүссэн хэлээ сонгоод **Хэрэглэх** дээр товш. Хэрэв хэрэглүүрт өгөгдмөл хэлийг хэрэглэх боломжгүй байвал жагсаалтад байгаа хэлнээс аль боломжтойгоо хэрэглэнэ.

Тусгай боломжууд

Төхөөрөмжийн хэрэглээний хүртээмжийг сайжруулахын тулд төрөл бүрийн тохиргоог өөрчилнө. Дэлгэрэнгүй мэдээллийг [Тусгай боломжууд](#)-ээс авна уу.

Тохиргооны дэлгэц дээр **Тусгай боломжууд** дээр товш.

Software update

Төхөөрөмжийн программ хангамжийг Техникийн программыг агаараар дамжуулах (FOTA) үйлчилгээгээр дамжуулан шинэчилнэ. Та мөн программ хангамжийн шинэчлэлтийн хугацааг төлөвлөж болно.

Тохиргооны дэлгэц дээр **Software update** дээр товш.

- **Татаж авах ба суурилуулах:** Шинэчлэлтийг та өөрөө шалгаж, суурилуулна.
- **Wi-Fi-р автоматаар татаж авах:** Төхөөрөмж Wi-Fi сүлжээнд холбогдмогцоо шинэчлэлтийг автоматаар татаж авна.
- **Сүүлийн шинэчлэл:** Программ хангамжийн хамгийн сүүлийн шинэчлэлтийн мэдээллийг харна.



Хэрэв төхөөрөмжийн аюулгүй байдалд зориулсан программ хангамжийн яаралтай шинэчлэлт гарсан бөгөөд шинэ төрлийн халдлагыг хориглох шаардлагатай болсон бол таны зөвшөөрөлгүйгээр автоматаар суурилуулна.

Хамгаалалтын шинэчлэлтийн мэдээлэл

Таны төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангаж, хувийн мэдээллийг тань хамгаалахын тулд хамгаалалтын шинэчлэлтийг хийдэг. Таны төхөөрөмжийн загварт тохирсон хамгаалалтын шинэчлэлтийг security.samsungmobile.com хуудаснаас үзнэ үү.



Уг вэб сайтыг цөөн тооны хэлээр үзэх боломжтой.

Утасны тухай

Таны төхөөрөмжийн мэдээллийг харуулна.

Тохиргооны дэлгэц дээр **Утасны тухай** дээр товш.

Төхөөрөмжийнхөө нэрийг харуулахын тулд **Засварлах** дээр товш.

- **Төлөвийн мэдээлэл:** Төхөөрөмжийн SIM картын төлөв, Wi-Fi MAC хаяг, серийн дугаар зэрэг мэдээллүүдийг харуулна.
- **Хууль эрх зүйн мэдээлэл:** Төхөөрөмжид хамаарах эрхзүйн мэдээллийг, тухайлбал хамгаалалтын мэдээлэл, нээлттэй эхийн лицензийн тухай харуулна.
- **Програмын мэдээлэл:** Төхөөрөмжийн программ хангамжийн мэдээлэл, үүнд: үйлдлийн системийн болон техникийн программ хангамжийн хувилбарыг харуулна.
- **Зайны мэдээлэл:** Төхөөрөмжийн батарейн төлөв, мэдээллийг харуулна.

Хавсралт



Тусгай боломжууд

Хүртээмжийн тухай

Хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй хэрэглэгчдэд зориулан төхөөрөмжийг хэрэглэхэд хялбар болгох функцүүдийн тусламжтай хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** дээр товш. Санал болгож буй онцлог болон ашиглаж буй хүртээмжтэй онцлогийг шалгахын тулд, **Танд санал болгосон** дээр товш. Хэрэглэж байгаа онцлогийг идэвхгүй болгохын тулд, **Унтраах** дээр товш.

TalkBack (Дуут санал хүсэлт)

TalkBack идэвхжүүлэх эсвэл идэвхгүй болгох

TalkBack-г идэвхжүүлбэл, төхөөрөмж дуу хоолойгоор хариу өгч эхэлнэ. Сонгосон функцийг нэг удаа товшвол, төхөөрөмж дэлгэц дээрх бичгийг чанга уншина. Уг функцийг давхар товшвол функцийг идэвхжүүлнэ.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд, **Тусгай боломжууд** → **TalkBack** дээр товшиж, дараа нь сэлгүүрийг товшиж идэвхжүүлнэ үү.

TalkBack-г идэвхгүй болгохын тулд сэлгүүрийг товшоод, дэлгэцийн дурын цэг дээр хоёр удаа хурдан товш.

TalkBack-г хэрхэн ашиглахыг харахын тулд, **Тохиргоо** → **Практик хичээл, тусламж** дээр товш.



TalkBack-г хэрэглэж байгаа үед зарим функц ажиллахгүй байж болно.

Хурууны дохио зангаагаар дэлгэцийг удирдах

Та TalkBack хэрэглэж байгаа үедээ хуруугаар янз бүрийн дохио зангаа хэрэглэн дэлгэцийг удирдаж болно.

Байгаа хурууны дохио зангааг харах болон тохируулан өөрчлөхийн тулд **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **TalkBack** → **Тохиргоо** → **Зангааг өөрчлөх** дээр товшино уу.

Унших цэс хэрэглэх нь

TalkBack ашиглаж байгаа үед гурван хуруугаар зүүн эсвэл баруун тийш шудар. Унших цэс гарч ирэх ба төхөөрөмж дээрх сонголтуудыг чанга уншина. Гурван хуруугаар зүүн тийш эсвэл баруун тийш шудраад сонголтуудыг гүйлгэж хар. Хүссэн сонголтоо сонсвол дээш эсвэл доош шудраад тухайн сонголтыг хэрэглэх буюу тухайн сонголтын тохиргоог өөрчилнө. Жишээ нь: **Ярианы хурд** гэхийг сонсвол та дээш юм уу доош шудраад ярианы хурдыг тааруулж болно.

Зурагт тайлбар нэмж, удирдах

Та дэлгэц дээрх зурагт тайлбар нэмж болно. Зургуудыг сонговол төхөөрөмж тайлбаруудыг чанга уншина. Дээш эсвэл доош, дараа нь баруун тийш шударч тайлбаргүй зургуудад тайлбар нэмнэ. Дараа нь TalkBack цэс гарч ирэхэд **Шошго нэмэх** дээр товш.

Тайлбаруудыг удирдахын тулд **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **TalkBack** → **Тохиргоо** → **Дэвшилтэт тохиргоо** → **Захиалгат шошго** дээр товш.

TalkBack тохиргоог тохируулах

Таны хэрэгцээнд нийцүүлэн TalkBack тохиргоог тааруулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **TalkBack** → **Тохиргоо** дээр товш.

- **TalkBack-н шинэ онцлогууд:** TalkBack-ийн гол шинэчлэлт болон өөрчлөлтийг шалгана.
- **Бичвэрийг ярианд хувиргах тохиргоо:** TalkBack идэвхэжсэн үед хэрэглэгддэг бичвэрийг яриа болгох онцлогуудын хэл, хурд гэх мэт тохиргоог өөрчилнө.
- **Нуршилт:** Дуу хоолойгоор өгөх хариу үйлдлийн нарийвчилсан тохиргоог өөрчилнө.
- **Нууц үгийг хэлэх:** Таныг нууц үгээ оруулахад төхөөрөмж тэмдэгтийг унших эсэхийг тохируулна. Хэрэв та энэхүү онцлогийг идэвхгүй болговол, төхөөрөмж нь зөвхөн чихэвч ашиглаж байх үед нууц үгээ чанга унших болно.
- **Хонхны ая болон чичиргээ:** TalkBack-ийн дууны тохиргоог өөрчил.
- **Фокусын заалтыг өөрчлөх:** Зүйлсүүд дээр товшиход харагдах фокус заагчийн хүрээг нарийсгах, төхөөрөмжийн тохиргоог хий. Та мөн заагчийн өнгийг өөрчилж болно.
- **Зангааг өөрчлөх:** TalkBack ашиглаж байх үедээ дэлгэцийг удирдахын тулд хурууны янз бүрийн дохио зангаа үзэх, дохионы зангааны тохиргоог тохируулан өөрчилнө.
- **Цэсийг өөрчлөх:** TalkBack болон унших цэсээс алийг нь хэрэглэхээ сонгоно уу.
- **Брайл гар:** 6 цэг бүхий брайль товчлуурт гар ашиглан дэлгэц дээр үсэг, тоог хялбархан оруулаарай.
- **Практик хичээл, тусламж:** TalkBack-ийг хэрхэн ашиглах талаар сурна.
- **Дэвшилтэт тохиргоо:** TalkBack-ийн нарийвчилсан тохиргоог хийнэ.
- **Galaxy Store дээр TalkBack-г нээ:** **Galaxy Store** -ос TalkBack-йг ажиллуулаад шинэчлэлт байгаа эсэхийг шалгаарай.

Товчлуурт гараар бичвэр оруулах

Товчлуурт гарыг гаргахдаа бичвэр бичих нүдийг товшоод дэлгэцийн дурын цэг дээр хоёр удаа хурдан товшино.

Түргэн оруулгын товчнуудын функцийг идэвхжүүлэхдээ **Тохиргоо** аппликейшныг ачаалж **Тусгай боломжууд** → **TalkBack** → **Тохиргоо** → **Дэвшилтэт тохиргоо** → **Бичих сонголт** → **Сонгох товчлуурыг удаан дараад хуруугаа өргөнө үү** дээр орхи.

Хуруугаар товчлуурт гарт хүрэхэд төхөөрөмж хуруугаар зааж байгаа тэмдэгтийг чанга хэлнэ. Та хүссэн тэмдэгтээ сонсвол хуруугаа дэлгэцээс салгаж уг тэмдэгтийг сонго. Тэмдэгтийг оруулах ба төхөөрөмж бичгийг чанга уншина.

Хэрэв **Товчлуур сонгохыг удаан дараад дараа нь хоёр товшино уу** сонгогдосн, хүссэн тэмдэгтээсээ хуруугаа авч, хурдхан дэлгэцийн хаа нэгтээ хоёронтоо товш.

Нэмэлт тэмдэг оруулах

Товчлуурт гар дээр дээрх товшоод удаан дараад тухайн товчны нэмэлт тэмдгийг оруулна. Товчны дээр попап цонх гарч хэрэглэх боломжтой тэмдгүүдийг харуулна. Тэмдэгтийг сонгохын тулд хуруугаар попап цонхон дээр чирээд хүссэн тэмдэгтээ сонсмогц хуруугаа салга.

Харагдах байдлын сайжруулалт

Дэлгэцийн горим

Дэлгэцийн горимыг өөрчилөх.

Тохиргоо аппликейшныг ачаалж **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** дээр товш, тэгээд **Дэлгэцийн горим** дотроос хүссэн горимоо сонго.

Өндөр ялгаралтай загвар хэрэглэх

Бараан дэвсгэр дээр агуулгыг цайвар өнгөөр харуулах энгийн загварыг хэрэглэнэ.

Тохиргоо хэрэглүүрийг товшоод **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** → **Өндөр ялгаралтай загвар** дээр товшсоны дараа хүссэн загвараа сонго.

Өндөр ялгаралтай үсгийн хэв

Үсгийн өнгө, хүрээг тааруулж дэвсгэр ба бичгийн хоорондох ялгарлыг нэмэгдүүлнэ.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** дээр товшсоны дараа **Өндөр ялгаралтай үсг. хэв** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Өндөр ялгаралтай товчлуурт гарыг хэрэглэх

Samsung товчлуурт гарын өнгийг өөрчлөөд дэвсгэр ба бичгийн хоорондох ялгарлыг нэмнэ.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** дээр товшсоны дараа **Өндөр тодролтой гар** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Харуулах товчны хэлбэр

Хүрээ бүхий харуулах товчны хэлбэр нь түүнийг тодотгож өгнө.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** дээр товшсоны дараа **Товчийг тодруулах** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Дэлгэцийн өнгийг урвуулах

Хэрэглэгчид дэлгэц дээрх бичгийг танихад нь туслахын тулд дэлгэцийн харагдцыг сайжруулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** дээр товшсоны дараа **Өнгөний өөрчлөлт** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Өнгө тохируулга

Өнгө ялгах бэрхшээлтэй хүмүүст зориулан дэлгэц дээрх өнгийг хэрхэн харуулахыг тааруулна.

Төхөөрөмж заасан өнгийг ялгахад амар өнгөөр өөрчилнө.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** → **Өнгө тохируулга** сэлгүүрийг товшоод идэвхжүүл. Аль нэгийг сонго.

Өнгийн эрчийг тааруулахын тулд **Эрч**. тохируулгын хөндлийг чир.

Хэрэв **Өөриймшүүлсэн өнгө** гэж сонгосон бол дэлгэцийн өнгийг өөртөө тохируулан өөрчилж болно. Дэлгэц дээрх зааврыг дагаад өнгийн тохируулгын үйлдлийг гүйцэтгэ.

Өнгөний шүүлтүүр нэмэх

Бичиг уншихад бэрхшээлтэй хүмүүст зориулан дэлгэцийн өнгийг тааруулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** → **Өнгөний шүүлтүүр нэмэх** сэлгүүрийг товшоод идэвхжүүл. Хүссэн өнгөө сонго.

Тунгалагшилтын хэмжээг тааруулахын тулд **Тунгалаг шинж** тохируулгын хөндлийг чир.

Дэлгэцийн хөдөлгөөний эффектийг бууруулах

Хөдөлгөөнт дүрс, дэлгэцийн хөдөлгөөнийг харахад эмзэг бол хөдөлгөөний эффектийг бууруулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** дээр товшсоны дараа **Хөдөлгөөнт зургуудыг арилгах** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Тунгалаг болон бүүдийлгэх эффектүүдийг багасгах

Дэлгэц дээрх агууламжийг тодорхой харагдуулахын тулд тунгалаг, бүүдгэр болгох эффектүүдийг багасга.

Тохиргоо аппликейшныг ачаалж, **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** дээр товш, тэгээд **Тод байдал, бүдгэрэлт багасгах** дээр товшиж үүнийг идэвхжүүл.

Дэлгэцийн гэрлийг бууруулах

Илүү тав тухтай үзэхийн тулд дэлгэцийг хамгийн бага тодролтын тохиргооноос доогуур бүдгэрүүлнэ үү.

Тохиргоо аппликейшныг ачаалж, **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** дээр товш, тэгээд **Нэмэлт бүдэг** дээр товшиж үүнийг идэвхжүүл.

Дэлгэцийг томруулах

Дэлгэцийн тодорхой хэсгийг томруулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд, **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** → **Өсгөлт** → **Өсгөлт холбоос** сэлгүүрийг товшоод идэвхжүүл. Дараа нь энэ функцийг шууд ашиглаж эхлэхэд ашиглах үйлдлүүдийг тэмдэглэ.

- **Хандалтыг хялбаршуулах товчийг товш:** Залуурдах мөрөн дээрх  дүрсийг товшсоны дараа дэлгэц дээр товшоод тухайн хэсгийг томруул. Дэлгэцийг түр томруулахын тулд дэлгэцийг томруулахыг хүссэн газраа удаан дарна уу.
- **Дуу намсгах, чангалах товчийг 3 секунд удаан дар:** Дуу чангалах болон Дуу намсгах товчийг 3 секунд дарж байгаад, томруулан харах газартаа товшж зургийг Татан харна. Дэлгэцийг түр томруулахын тулд дэлгэцийг томруулахыг хүссэн газраа удаан дарна уу.
- **Хажуу ба Дуу чангалах товчийг дарна уу:** Хажуугийн товчийг болон Дуу чангалах товчийг зэрэг дарж зургийг татаж, томруулж харах газартаа товш. Дэлгэцийг түр томруулахын тулд дэлгэцийг томруулахыг хүссэн газраа удаан дарна уу.
- **Дэлгэцийг гурав товших:** Дэлгэцийг гурван удаа товшоод томруулна. Дэлгэцийг түр томруулахын тулд дэлгэцийг гурван удаа товшоод удаан барина уу.

Томруулагчийг хэрэглэн дэлгэцийн нэг хэсгийг томруулахын тул,  дээр товш. Томруулагчийг зөөхдөө, томруулагчийн хүрээний ирмэг дээр дараа чир.

Дэлгэцийг бүрэн харахын тулд хоёр хуруугаар томруулсан дэлгэцийг чирнэ.

Томруулах харьцааг тааруулахын тулд хоёр хуруугаар томруулсан дэлгэц дээр чимхэх буюу салгах хөдөлгөөн хийнэ.



- Дэлгэц дээрх товчлуурт гар ба залуурдах мөрийг томруулах боломжгүй.
- Энэ функцийг идэвхжүүлсэн бол зарим хэрэглүүрийн гүйцэтгэлд нөлөөлж болно.

Хулгана, мэдрэгч хавтангийн заагчийг томруулах

Нэмэлт хулгана, мэдрэгч хавтан хэрэглэх үед заагчийг томруулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** дээр товшсоны дараа **Том хулгана/тмэдрэгч гарын заагуур** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Үсгийн хэвийг өөрчлөх

Үсгийн хэмжээ, загварыг өөрчилнө.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** → **Үсгийн хэвийн хэмжээ ба загвар** дээр товшоод идэвхжүүл.

Дэлгэц томруулах хэмжээг өөрчлөх

Дэлгэц ээрх зүйлсийг томруулах буюу багасгана.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харагдах байдлын сайжруулалт** → **Дэлгэц томруулах** дээр товш.

Сонгол сайжруулалт

Шууд бичвэр болгон сийрүүлэх

Төхөөрөмжийн микрофоноор яриаг бичиж авч дэлгэц дээр бичвэр болгон хөрвүүлэхээр тохируулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд, **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** → **Шууд бичвэр болгон сийрүүлэх** → **Шууд бичвэр болгон сийрүүлэх холбоос** дээр товшоод дараа нь үүнийг идэвхжүүлэхийн тулд сэлгүүр дээр товшино уу. Дараа нь  дээр товшоод яриаг хөрвүүлнэ.

Шууд хадмал

Таныг видео бичлэг юм у подкаст зэрэг медиа агуулгыг тоглуулах үеэр төхөөрөмж яриаг таньж, хадмал бичвэрийг үүсгэнэ.

Тохиргоо аппликейшныг ачаалж, **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** → **Шууд хадмал** дээр товш, тэгээд **Шууд тайлбарыг ашиглах** дээр товшиж үүнийг идэвхжүүл.

Хадмал бичвэрийн тохиргоо

Тохиргоо аппликейшныг ачаалж, **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** → **Зураг авах сонголт** дээр товш, тэгээд **Тайлбаруудыг харуул** дээр товшиж үүнийг идэвхжүүл.

Хадмал бичвэрийн тохиргоог өөрчлөх сонголтыг хий.

Дуу танигчид

Төхөөрөмж хүүхэд уйлах, хаалганы хонхны чимээг таних эсэхийг тохируулна. Төхөөрөмж ийм дуу чимээг танивал чичирхийлж, уг дохиог бүртгэж хадгална.



Энэ функцийг идэвхжүүлсэн бол дуу хоолой таних функц ажиллахгүй.

Хүүхэд уйлж буй

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** → **Дуу танигчид** → **Хүүхэд уйлж буй** → **Эхлүүлэх** дээр товш.

Хаалганы хонх

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** → **Дуу танигчид** → **Хаалганы хонх** дээр товш.
- 2 **Бичлэг** дээр товшоод хаалганы хонхны чимээг бүртгэнэ.
Төхөөрөмж хаалганы хонхны чимээг илрүүлнэ.
- 3 **Сорил** дээр товшоод хаалганыхаа хонхыг дуугаргаж, зөв бүртгэж байгаа эсэхийг шалга.
Төхөөрөмж хаалганы хонхны чимээг илрүүлбэл **Эхлүүлэх** дээр товш.
Хаалганы хонхны чимээг өөрчлөхийн тулд **Хаалганы хонхны дууг өөрчлөх** дээр товш.

Сонголын аппаратын дэмжлэг

Төхөөрөмжийн дуу чимээний дуугаралтыг сонголын аппаратад нийцүүлэх эсэхийг тохируулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** → **Сонголын аппаратын дэмжлэг** дээр товшсоны дараа **Сонголын аппаратын тохиромж** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Орчны дууг нэмэгдүүлэх

Чихэвч хэрэглэж байгаа үед таны эргэн тойрны дуу чимээг өсгөж, сонсоход тань тусална.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** → **Орчны дууг нэмэгдүүлэх** дээр дарж дараа нь **Орчны дууг нэмэгдүүлэх холбоос** сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
- 2 Чихэвчээ төхөөрөмжид залгаад зүү.
- 3  дээр товш.

Adapt Sound

Дууны тохиргоог оновчтой тохируулж дууны чанарыг хамгийн өндөр болгож, медиа тоглуулахад ашиглана.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** → **Adapt Sound** дээр товшоод дууны тохиргоог оновчтой тохируул.

Бүх дуу чимээг унтраах

Төхөөрөмж медианы дуу, дуудлагын үеэр залгагчийн яриа зэрэг бүх дуу чимээг унтраах эсэхийг тохируулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** дээр товшсоны дараа **Бүх дууг хаах** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.

Моно аудио

Моно гаралт нь чихэвчний бүх сувгаар гарах дууг нэгтгэж нэг сигнал болгодог. Сонголын бэрхшээлтэй эсвэл өрөөсөн чихэвч хэрэглэдэг бол үүнийг ашигла.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** дээр товшсоны дараа **Моно аудио** сэлгүүрийг товшиж идэвхжүүл.

Дууны тэнцвэрийг тааруулах

Дууны тэнцвэрийг тааруулах эсэхийг төхөөрөмжид тохируулна.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Сонгол сайжруулалт** дээр товш.
- 2 **Зүүн/баруун дууны хэмжээ** тохируулгын хөндлийг зүүн, баруун тийш чирээд дууны тэнцвэрийг тааруул.

Харилцан үйлчлэл ба эв дүй

Универсал сэлгүүр

Та мэдрэгч дэлгэцийг нэмэлт залгуурт залгаад толгойн хөдөлгөөн, нүүрний дохио зангаагаар удирдаж болно.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Универсал сэлгүүр** дээр товш.
- 2 Дэлгэц дээрх зааврыг дагаж **Болсон** дээр товш.
- 3 Сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
- 4 Хэрэв универсал сэлгүүрийг төхөөрөмжид бүртгээгүй бол **Сонголт нэмэх** дээр товшоод төхөөрөмжийг удирдах сэлгүүрийг нээ.



Универсал сэлгүүр функцийг идэвхжүүлэхийн тулд төхөөрөмжид багадаа нэг сэлгүүр бүртгэсэн байх ёстой.

Төхөөрөмж сэлгүүрийг удирдах эсэхийг тохируулахын тулд **Шилжилтүүд** хэсэгт буй сэлгүүрийг товш.

Энэ функцийг идэвхгүй болгохын тулд Хажуугийн товч ба дуу чангалах товчийг зэрэг дар.

Туслах цэс

Туслах холбоосны дүрсийг харуулах

Төхөөрөмжид хэрэглүүр, функц, тохиргоонд хандахад зориулсан туслах холбоосны дүрсийг харуулах эсэхийг тохируулна. Та дүрсний туслах цэсийг товшоод төхөөрөмжийг хялбархан удирдаж болно.

- 1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Туслах цэс** дээр товш.
- 2 Сэлгүүрийг товшоод идэвхжүүл.
Дэлгэцийн баруун доод талд туслах холбоосны дүрс гарч ирнэ.
Туслахын холбоосны дүрсийн тунгалагшилтын хэмжээг тааруулахын тулд **Тунгалагжилт** дээр товш.

Туслах цэсэд хандах

Туслах холбоосны дүрс хөвөгч дүрс болж харагдах ба дурын дэлгэцээс туслах цэс рүү хандахад хялбар болгоно.

Туслах холбоосны дүрсийг товшвол дүрсэн дээр туслах цэсийг дэлгэн харуулна. Зүүн эсвэл баруун талын суман дээр товшоод, эсвэл зүүн эсвэл баруун тийш шудраад бусад цэсийг сонгоно.

Курсор хэрэглэх

Туслах цэсэн дээр **Курсор** дээр товш. Та мэдрэх хэсэг дээгүүр хурууны үл ялиг хөдөлгөөнөөр дэлгэцийг удирдаж болно. Мэдрэх хэсэгт хуруугаар чирээд курсорыг хөдөлгөнө. Түүнчлэн дэлгэцийг товшоод курсорын зааж буй зүйлийг сонгоно.

Дараах сонголтуудыг хэрэглэж болно:

-  /  : Дэлгэц дээгүүр зүүн, баруун тийш гүйлгэх.
-  /  : Дэлгэц дээгүүр дээш, доош гүйлгэх.
-  : Курсорын байгаа газрыг томруулах.
-  : Мэдрэх хавтан ба тохиргоог өөрчлөх.
-  : Мэдрэх хэсгийг өөр тийш зөөх.
-  : Мэдрэх хэсгийг хаах.

Сайжруулсан туслах цэсийг хэрэглэх

Төхөөрөмжид сонгосон хэрэглүүрүүдэд сайжруулсан туслах цэсийг харуулах эсэхийг тохируулна.

Тохиргоо хэрэглүүрийг товшоод **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Туслах цэс** → **Тусгайлсан цэсийг харуулах хэрэглүүрүүд сонго** дээр товшиж, идэвхжүүлэхийг хүссэн хэрэглүүрийн дэргэдэх сэлгүүрийг товшиж идэвхжүүл.

Voice Access

Дуу хоолойгоор төхөөрөмжөө удирдахын тулд энэхүү функцийг хэрэглэ.

Тохиргоо аппликейшныг ачаалж, **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Voice Access** гэж товшоод, аппликейшныг татаж аваад, идэвхжүүлэхийн тулд товш.

Дуудлагад хариулах, дуусгах

Дуудлагад хариулах, дуусгах аргыг өөрчилнө.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Дуудлага хариулах ба таслах** дээр товшсоны дараа хүссэн аргын дэргэдэх сэлгүүрийг товшиж идэвхжүүл.

Харилцах удирдлага

Харилцан үйлдлийн хяналтын горимыг идэвхжүүлж хэрэглүүрийг хэрэглэх явцад төхөөрөмжийн хариу үйлдлийг хязгаарлана.

1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Харилцах удирдлага** дээр товш.

2 **Харилцах удирдлага холбоос** сэлгүүрийг товшоод үүнийг идэвхжүүл.

3 Хэрэглүүрийг хэрэглэх явцдаа Хажуугийн товч ба дуу чангалах товчийг нэгэн зэрэг дар.

4 Хязгаарлахыг хүссэн хэсгийн хүрээний хэмжээг өөрчлөх юм уу тойруулан зураас зур.

5 **Дууслаа** дээр товш.

Төхөөрөмж хязгаарласан хэсгийг харуулна. Хязгаарласан хэсэгт таныг хүрэхэд хариу үйлдэл үзүүлэхгүй ба төхөөрөмжийн товчийг хязгаарлана. Гэсэн ч харилцан үйлдлийн хяналтын горимд Хажуугийн товч ба дууны товч, товчлуурт гарын функцийг идэвхжүүлж болно.

Харилцан үйлдлийн хяналтын горимыг идэвхгүй болгохын тулд Хажуугийн товч ба дуу чангалах товчийг нэгэн зэрэг дар.

Төхөөрөмжийн дэлгэцийг харилцан үйлдлийн хяналтын горимыг идэвхгүй болгосны дараа түгжихээр тохируулахын тулд **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Харилцах удирдлага** дээр товшиж, **Идэвхгүй болгоход дэлгэц түгжих** сэлгүүрийг товшиж идэвхжүүлнэ.

Товшиж, барих хүлээлт

Дэлгэц дээр удаан дарах танилтын хугацааг тохируул.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Товшиж, барих хүлээлт** дээр товшоод аль нэгийг сонго.

Үргэлжлэх хугацааг товш

Төхөөрөмж товших үйлдлийг зөв танихын тулд дэлгэцийг товших хугацааг тааруулах ёстой.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Үргэлжлэх хугацааг товш** дээр товшиж, сэлгүүрийг товшиж идэвхжүүлээд, хугацааг тааруул.

Давтагдсан товшилтыг үл тоох

Тодорхой хугацааны турш дэлгэцийг олон давтан товшиход төхөөрөмж зөвхөн эхний товшилтыг хүлээж авах эсэхийг тохируул.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Давтагдсан товшилтыг үл тоох** дээр товшиж, сэлгүүрийг идэвхжүүлээд, хугацааг тохируул.

Заагч зогссоны дараах автомат үйлдэл

Хулганын заагчийг ямар тухайн зүйл дээр байрлуулсны дараа автоматаар сонгох эсэхийг тохируулна.

Тохиргоо аппликейшныг ачаалж, **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Заагч зогссоны дараах автомат үйлдэл** → **Авто үйлдэл** дээр товш, тэгээд сонголтоо хий.

Наалдамхай товчлуур

Нэмэлт товчлуурт гарын Shift, Ctrl, Alt товчлуур зэргийг дарагдмал байдалтай болгож тохируулна. Ингэснээр нэгэн зэрэг хоёр товч дарахгүйгээр товчлуурт гарын команд өгөх боломжтой болно.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** дээр товшоод **Наалдамхай товчлуур** сэлгүүрийг товшиж идэвхжүүлнэ.

Удаан түлхүүр

Нэмэлт товчлуурт гар дээр товчны даралтыг таних хугацааг тохируулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Удаан түлхүүр** дээр товшиж, сэлгүүрийг товшиж идэвхжүүлээд, хугацааг тааруул.

Ойлтын товчлуур

Тодорхой хугацааны турш дэлгэцийг олон давтан дарахад төхөөрөмж уг товчны зөвхөн эхний даралтыг хүлээж авах эсэхийг тохируул.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Харилцан үйлчлэл ба эв дүй** → **Ойлтын товчлуур** дэр товшиж, сэлгүүрийг товшиж идэвхжүүлээд, хугацааг тааруул.

Нарийвчилсан тохиргоо

Хүртээмжийн функцүүдийг хурдан нээх

Хүртээмжийн функцүүдийг хурдан нээхийг тохируулна.

Тохиргоо аппликейшныг ачаалж **Тусгай боломжууд** → **Нарийвчилсан тохиргоо** дээр товш.

Хандалтыг хялбаршуулах товч → **Үйлдлүүд сонгох** гэж товшоод, эсвэл **Хажуу ба Дуу чангалах товч** эсвэл **Дуу намсгах ба чангалах товч** дээр дараад, хүсэж буй хүртээмжийн функцээ сонго.

Гэрэлт мэдэгдлийг тохируулах

Сэрүүлэг дуугарах, дуудлага юм уу зурвас ирэх зэргийг мэдэгдэхдээ төхөөрөмжийн гялсгуур асах эсэхийг тохируулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Нарийвчилсан тохиргоо** → **Гялсхийх мэдэгдэл** дээр товшиж, сэлгүүрийг товшоод идэвхжүүл.

Үйлдэл авах цаг

Мэдэгдэл, дууны түвшний удирдлага зэрэг үйлдэл хийхийг хүссэн попап цонхнуудыг харуулах хугацааг тохируулна.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Нарийвчилсан тохиргоо** → **Үйлдэл авах цаг** дээр товшоод аль нэгийг сонго.

Гарны оролтыг чанга унших

Товчлуурт гарт оруулсан бүхнийг төхөөрөмж чангаар хэлдэг байхаар тохируул.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Нарийвчилсан тохиргоо** → **Гарны оролтыг чанга унших** дээр товшиж, сэлгүүрийг товшин үүнийг идэвхжүүлээд сонголтыг сонгоно уу.

Хандлт хялбаршуулх Bixby Vision

Bixby харааны хүртээмжийн функцүүдийг идэвхжүүлсэн бол та Bixby харааны нэмэлт функцүүдийг хэрэглэж болно.

1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Нарийвчилсан тохиргоо** → **Хандлт хялбаршуулх Bixby Vision** дээр товшиж, сэлгүүрийг товшоод идэвхжүүлнэ.

2 **Bixby Vision нээх** дээр товш.

3 Хэрэглэхийг хүссэн функцээ сонго.

-  : Таны харж буй үзэгдэх орчныг шинжилж дуу хоолойгоор тайлбарлана.
-  : Бичвэрийг таних юм уу дуу хоолойгоор объектыг тайлбарлан хэлнэ.
-  : Бичвэрийг таньж, чанга уншина.
-  : Объектын өнгийн таньж, чанга уншина.



Үйлчилгээ үзүүлэгч, загвараас хамаараад зарим функцийг ашиглах боломжгүй байж болзошгүй.

Дуут шошгод дуу бичлэг нэмэх

Дуут шошгыг адил төстэй хэлбэр бүхий объектуудыг ялгахдаа дуут шошгоор тэмдэглэнэ. Та дуу хурааж, NFC дуут шошгод түүнийгээ нэмж болно. Шошгын ойролцоо төхөөрөмжөө байрлуулахад дуу бичлэгийг сонсоно.



Энэ функцийг хэрэглэхийн өмнө NFC функцийг асаавал зохино.

1 **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Тусгай боломжууд** → **Нарийвчилсан тохиргоо** → **Дуут Шошго** дээр товш.

Дуу хураагуур нээгдэнэ.

2  дээр товшоод бичиж эхэл. Микрофон руу ярь.

3 Бичлэг хийж дууссан бол **Болсон** дээр товшоод зогсоо.

4 Төхөөрөмжийн ар талыг дуут шошгон дээр барь.

Дуу бичлэгт орсон мэдээллийг дуут шошгод бичнэ.

Суурилуулсан хэрэглүүрүүд

Төхөөрөмж дээр суурилсан хүртээмжид зориулсан үйлчилгээнүүдийг харуулна.

Тохиргоо аппликейшныг ачаалж **Тусгай боломжууд** → **Суурилуулсан хэрэглүүрүүд** дээр товш.

Гэмтэл оношлох

Samsung-ийн засвар үйлчилгээний төвд хандахын өмнө дараах арга хэмжээг авахыг оролдоно уу. Зарим тохиолдол нь таны төхөөрөмжид таарахгүй байж болно.

Мөн та Samsung гишүүнийг хэрэглээд төхөөрөмжийг ашиглахад тулгарч болох аливаа бэрхшээлийг арилгаж болно.

Төхөөрөмжийг асаахад эсвэл төхөөрөмжийг хэрэглэх үед дараах эдгээр кодын нэгийг оруул:

- Нууц үг: Төхөөрөмжийг түгжих функц идэвхэжсэн бол та төхөөрөмжид тохируулсан нууц үгээ оруулах ёстой.
- PIN: Төхөөрөмжийг эхний удаа хэрэглэх эсвэл PIN оруулах шаардлага идэвхэжсэн бол та SIM буюу USIM картын PIN кодыг оруулах ёстой. SIM картын цэсээс энэ функцийг идэвхгүй болгож болно.
- PUK: Ихэвчлэн SIM буюу USIM картынхаа PIN кодыг олон удаа буруу оруулснаас блоклогдсон. Үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн PUK кодыг оруулах ёстой.
- PIN2: PIN2 шаарддаг цэсэд хандаж байгаа бол та SIM буюу USIM картад дагалдах PIN2 кодыг оруул. Нэмэлт мэдээллийг үйлчилгээ үзүүлэгчээсээ лавлана уу.

Таны төхөөрөмжид сүлжээний эсвэл үйлчилгээний алдааны зурвас харуулах

- Та дохионы чадал сул байх эсвэл муу хүлээж авч байгаа газар байгаа тохиолдолд холболт тасарч болзошгүй. Өөр газар очоод дахин оролд. Шилжин явах үед алдааны зурвас давтан гарч ирж болно.
- За үйлчилгээнд бүртгүүлэлгүйгээр зарим сонголтод хандах боломжгүй. Нэмэлт мэдээллийг үйлчилгээ үзүүлэгчээсээ лавлана уу.

Таны төхөөрөмж асахгүй байх

Батарей бүрэн цэнэг алдсан бол төхөөрөмж унтарна. Төхөөрөмжийг асаахаас өмнө батареиг бүрэн цэнэглэ.

Мэдрэгч дэлгэцийн хариу удаан эсвэл буруу

- Та дэлгэцэд хамгаалалтын хуулга эсвэл нэмэлт дагалдах хэрэгсэл хэрэглэсэн бол мэдрэгч дэлгэц зөв ажиллахгүй байж болзошгүй.
- Та бээлийн өмсөн байгаа бол, мэдрэгч дэлгэцэд хүрч байгаа гар цэвэр биш, мэдрэгч дэлгэцэд нарийн объектоор товшиж байгаа бол мэдрэгч дэлгэц ажиллахгүй байж болзошгүй.
- Мэдрэгч дэлгэц чийгтэй нөхцөлд эсвэл усанд норсон бол ажиллахгүй байж болзошгүй.
- Төхөөрөмжийг унтрааж асаагаад программ хангамжид шигдсэн алдааг цэвэрлэ.
- Төхөөрөмжийн программ хангамж хамгийн сүүлийн хувилбараар шинэчлэгдсэн байвал зохино.
- Мэдрэгч дэлгэц зурагдсан, гэмтсэн бол Samsung-ийн засвар үйлчилгээний төвд хандана уу.

Төхөөрөмжид ноцтой алдааны дараа гацсан.

Дараах аргуудыг хэрэглээд үз. Хэрэв асуудал хэвээр байвал Samsung-ийн засвар үйлчилгээний төвд хандана уу.

Төхөөрөмжийг унтраагаад асаах

Төхөөрөмж гацсан эсвэл хариу өгөхгүй байвал та хэрэглүүрүүдийг хааж, төхөөрөмжийг унтрааж, асаах шаардлагатай.

Албадан унтрааж асаах

Хэрэв таны төхөөрөмж гацсан, хариу үйлдэл байхгүй бол хажуугийн товчийг дуу намсгах товчтой нэгэн зэрэг 7 секундээс багагүй хугацаанд дараад унтрааж асаана уу.

Төхөөрөмжийг шинээр тохируулах

Хэрэв уг аргуудаар бэрхшээлийг арилгахгүй байвал үйлдвэрийн тохиргоог сэргээ.

Тохиргоо хэрэглүүрийг нээгээд **Ерөнхий удирдлага** → **Дахин тохируулах** → **Үйлдвэрийн өгөгдлийг сэргээх** → **Дахин тох.** → **Бүгдийг устгах** дээр товш. Үйлдвэрийн тохиргоог сэргээхийн өмнө төхөөрөмжид хадгалсан чухал хэрэгтэй мэдээллүүдээ нөөцөлж авна уу.

Дуудлага хийх боломжгүй болох

- Төхөөрөмж зөв үүрэн холбооны сүлжээнд холбоонд хандаж байгаа эсэхийг шалга.
- Таны залгаж байгаа дугаарын дуудлагыг саатуулах тохиргоо хийсэн эсэхийг шалга.
- Ирж буй дуудлагын утасны дугаарыг саатуулах тохиргоо хийсэн эсэхийг шалга.

Бусад хүмүүс дуудлагын үеэр таны яриаг сонсохгүй байх

- Та микрофоноо халхалсан эсэхээ шалга.
- Микрофоныг амандаа ойр байлгах ёстой.
- Чихэвч хэрэглэж байгаа бол зөв залгасан эсэхийг шалга.

Дуудлагын үеэр яриа цуурайтах

Дууны товчийг дараад дууг тааруулах юм уу өөр газар оч.

Үүрэн холбооны сүлжээ эвсэл Интернет байнга салах эсвэл аудио дууны чанар муу

- Төхөөрөмжийн дотоод антеныг халхалсан эсэхийг шалга.
- Та дохионы чадал сул байх эсвэл муу хүлээж авч байгаа газар байгаа тохиолдолд холболт тасарч болзошгүй. Үйлчилгээ үзүүлэгчийн баз станцын асуудлаас шалтгаалан танд холболтын асуудал үүсэж байж болзошгүй. Өөр газар очоод дахин оролд.
- Төхөөрөмжийг хөдөлгөөнт орчинд хэрэглэх явцад үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээний асуудлаас шалтгаалан утасгүй сүлжээний үйлчилгээ идэвхгүй болж болзошгүй.

Зайг зөв цэнэглэхгүй байна (Samsung-ын зөвшөөрсөн цэнэглэгчээр)

- Цэнэглэгчийн зөв залгасан эсэхийг шалга.
- Samsung-ийн засвар үйлчилгээний төвд хандаж зайг солиулна уу.

Зайн цэнэг анх худалдан авсан үеийнхээс илүү хурдан дуусах

- Төхөөрөмжийг хэт халуун эсвэл хэт хүйтэн хэмд байлгавал зайн ашигтай цэнэг багасаж болзошгүй.
- GPS, тоглоом, интернет зэрэг зарим функцийг хэрэглэвэл батарейн цэнэгийн зарцуулалт ихэснэ.
- Зай бол элэгдэх эд бөгөөд хугацаа өнгөрөх тусам ашигтай цэнэг нь багасаж байдаг.

Камерыг нээхэд алдааны зурвас гарах

Төхөөрөмжид санах ойн сул зай хангалтгүй, батарейн цэнэг камерыг ажиллуулахад хүрэлцэхгүй байна. Хэрэв камерыг нээхэд алдааны зурвас гарч ирвэл дараах үйлдлийг хий:

- Батарейг цэнэглэ.
- Файлуудыг компьютер луу зөөж эсвэл төхөөрөмжөөс устгаад санах ойг чөлөөл.
- Төхөөрөмжийг унтраагаад асаа. Хэрэв эдгээр зөвлөмжийг дагасан ч камерын хэрэглүүрт алдаа гарсаар байвал Samsung-ийн засвар үйлчилгээний төвд хандана уу.

Фото зургийн чанар нь тоймлон харснаас муу байх

- Гэрэл зургийн чанар нь орчин, гэрэл зургийн технологиос хамаарч болно.
- Гэрэл зургийг шөнө, дотор орчинд, харанхуй газар авбал зураг бүрсийх юм уу зураг фокусгүй гарсан байж болзошгүй.

Мультимедиа файлуудыг нээхэд алдааны зурвас гарч ирэх

Алдааны зурвас эсвэл мультимедиа файл хүлээн авбал төхөөрөмж дээрээ нээж болохгүй бөгөөд дараах арга хэмжээг ав:

- Файлуудыг компьютер луу зөөж эсвэл төхөөрөмжөөс устгаад санах ойг чөлөөл.
- Дууны файл Дижитал эрхийн менежмент (DRM)-ээр хамгаалагдсан эсэхийг шалга. Хэрэв файл DRM хамгаалалттай бол танд уг файлыг тоглуулах лиценз байгаа эсэхийг шалга.
- Файлын формат тухайн төхөөрөмжид тохирох эсэхийг шалга. Файлын формат нь DivX эсвэл AC3, зэрэг тохирохгүй байл байвал тохирох хэрэглүүрийг суурилуул. Төхөөрөмжид тохирох файлын форматыг Samsung-ын вэб сайтаас үзнэ үү.
- Төхөөрөмжид өөрийнх нь авсан гэрэл зураг, видео бичлэг тохирно. Бусад төхөөрөмжийн авсан гэрэл зураг, видео бичлэг ажиллахгүй байж болзошгүй.
- Таны төхөөрөмжид танай сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрсөн мультимедиа файл эсвэл нэмэлт үйлчилгээ үзүүлэгчээс зөвшөөрсөн мультимедиа файл тохирно. Зарим интернетэд эргэлдэж байдаг агуулга, тухайлбал хонхны ая, видео бичлэг, дэлгэцийн зураг зохих ёсоор ажиллахгүй байж болзошгүй.

Bluetooth сайн ажиллахгүй байх

Хэрэв Bluetooth төхөөрөмж олдохгүй, эсвэл холболтын асуудалтай, ажиллагаа доголдсон бол үүнийг оролдоод үз:

- Холбогдох гэж буй төхөөрөмж хайж, холбогдоход бэлэн эсэхийг шалга.
- Таны төхөөрөмж болон Bluetooth төхөөрөмж Bluetooth-ийн холболтын хязгаараас (10 м) эсэхийг шалга.
- Төхөөрөмж дээрээ **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Холболтууд** дээр товшоод **Bluetooth** сэлгүүрийг товшиж дахин идэвхжүүл.
- Төхөөрөмж дээрээ **Тохиргоо** хэрэглүүрийг нээгээд **Ерөнхий удирдлага** → **Дахин тохируулах** → **Сүлжээний тохиргоог дахин тохируул** → **Тохиргоог сэргээх** → **Дахин тох.** дээр товшоод сүлжээний тохиргоог шинээр тохируул. Шинээр тохируулах явцад өмнө бүртгэсэн мэдээлэл алга болж болзошгүй.

Дээрх зөвлөмжийг дагасан ч асуудал хэвээр байвал Samsung-ийн засвар үйлчилгээний төвд хандана уу.

Мэдэгдлийн самбар дээр дэлгэцийн цайралтын тохируулгын хөндөл харагдахгүй байх

Төлөвийн мөрийг доош чирч мэдэгдлийн самбарыг нээгээд, уг мэдэгдлийн самбарыг доош чир. ⋮ → **Түргэн самбарын зураглал** → **Гэрэлтүүлгийн хяналт** → **Үргэлж харуул.**

Төхөөрөмжийг компьютерт залгахад холболт тогтохгүй

- Таны ашиглаж буй USB кабель таны гар утсанд тохирсон эсэхийг шалга.
- Компьютерт зохих драйвер суусан, шинэчлэгдсэн эсэхийг шалга.

Төхөөрөмж тухайн байршлыг зөв тодорхойлохгүй.

Зарим газар, тухайлбал байшин дотор GPS дохио халхлагдсан байж болзошгүй. Эдгээр тохиолдолд төхөөрөмжийн байрлалыг тодорхойлоход Wi-Fi эсвэл мобайл сүлжээ ашиглах эсэхийг тохируул.

Төхөөрөмжид хадгалсан мэдээлэл алга болсон

Төхөөрөмж дээр хадгалсан чухал мэдээллийг байнга нөөцөлж байна уу. Үгүй бол алга болсон, гэмтсэн мэдээллийг сэргээх боломжгүй. Samsung төхөөрөмжид хадгалж байсан мэдээлэл алга болоход хариуцлага хүлээхгүй.

Гар утасны гэрийн гадна талд жижиг завсар бий болох

- Энэ бол зайлшгүй хэрэгтэй үйлдвэрийн онцлог бөгөөд эд ангид бага зэргийн хөдөлгөөн, чичиргээ үүсэж болзошгүй.
- Хугацаа өнгөрөх тусам эд ангийн хоорондох үрэлтээс болж энэ завсар нэмэгдэж болзошгүй.

Төхөөрөмжийн санах ойд зай хүрэлцээгүй байх

Хэрэгцээгүй болсон кэш гэх мэт мэдээллийг төхөөрөмжийн арчилгаа функцээр эсвэл хэрэглэхгүй файл юм уу хэрэглүүрүүдийг гараар устгаж санах ойн зайг чөлөөлнө.

Үндсэн товч харагдахгүй байх

Зарим хэрэглүүр, функцийг хэрэглэж байхад үндсэн товчийг харуулдаг залуурдах мөр харагдахгүй болж болно. Залуурдах мөрийг гаргаж ирэхийн тулд дэлгэцийн доод талаас дээш чирнэ.

Зохиогчийн эрх

Зохиогчийн эрх © 2021 Samsung Electronics Co., Ltd.

Уг гарын авлага нь Олон улсын зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагдсан болно.

Уг гарын авлагын аль ч хэсгийг хуулбарлах, түгээх, орчуулах, аливаа хэлбэрээр, үүнд цахим, механик хэрэгсэл ашиглан дамжуулах, олшруулах, бичлэг хийх, аливаа санах ойн байгууламж эсвэл хайлтын системд хадгалахыг хориглоно.

Худалдааны тэмдгүүд

- SAMSUNG болон SAMSUNG-ийн лого нь Samsung Electronics Co., Ltd. компанийн бүртгэлтэй худалдааны тэмдгүүд юм.
- Bluetooth® нь олон улсын Bluetooth SIG, Inc. байгууллагын бүртгэлтэй худалдааны тэмдэг юм.
- Wi-Fi®, Wi-Fi Direct™, Wi-Fi CERTIFIED™, болон Wi-Fi лого нь Wi-Fi Alliance байгууллагын бүртгэлтэй худалдааны тэмдгүүд юм.
- Dolby Laboratories-ийн лицензээр үйлдвэрлэв. Dolby, Dolby Atmos, хос D тэмдгүүд нь Dolby Laboratories-ийн бүртгэлтэй худалдааны тэмдэг юм.
- Худалдааны бүх тэмдэг болон зохиогчийн бүх эрх холбогдох эзэмшигчдийнх нь өмч болно.